



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, МАРКЕТИНГ, СУДАЛГАА БОТЬ-II



Гүйцэтгэсэн: “OASIS BEAR” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛГ. СОЁЛМАА

Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,

Ider tower 61 тоот, утас:976-99183518, 86890199

И-мэйл хаяг: oasis.bear.llc@gmail.com

2021 он

АГУУЛГА

1. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4
1.1. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОНОЛ АРГА ЗҮЙ	5
1.1.1. Стратеги төлөвлөгөөний ажлын бүтэц	5
1.1.2. Төлөвлөлтийн үндэслэл.....	8
1.1.3. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БИЧИГ 2021-2031 ОН БАРИМТЛАХ ҮНДЭСЛЭЛ	9
1.1.4. СТРАТЕГИЙН ГОЛ ХУЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ	11
1.1.5. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО 2021-2031 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ	13
1.1.6. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН.....	22
АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС	22
1.1.7. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН.....	23
ХӨГЖЛИЙН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТУУД	23
1.1.8. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУДЫН ЛОГИК ХОЛБОО	34
1.1.9. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ.....	36
1.2. ГОВЬ АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН МЕНЕЖМЕНТ	44
1.2.3. ГОВЬ АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗАГВАР 53	
1.2.4. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС НУТГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ	56
1.2.5. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ	71
1.2.6. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	89
1.3. МАРКЕТИНГ ТӨЛӨВЛӨГӨӨ	101
1.3.1. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРКЕТИНГИЙН БОДЛОГО	101
1.4. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	129

Зургийн жагсаалт

Зураг 1. Стратеги төлөвлөгөөний загвар	5
Зураг 2. Аялалын бүс нутгийн судалгаа	6
Зураг 3. Аялалын нөөцийн судалгаа	6
Зураг 4. Явцын эхний хэлэлцүүлэг	7
Зураг 5. Явцын хоёрдах хэлэлцүүлэг	7
Зураг 6. Аймгийн аялал жуулчлалын стратегийн томъёолол	10
Зураг 7. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын стратегийн модель	13
Зураг 8. Эрхэм зорилго, зорилтуудын логик холбоо	34
Зураг 9. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны загварчлал	36
Зураг 10. Мэргэжлийн сургалт, судалгаа	37
Зураг 11. Төрийн зохицуулалт, дэмжлэг	38
Зураг 12. Орон нутгийн оролцоо	38
Зураг 13. Үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд	39
Зураг 14. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт	40
Зураг 15. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын схем	41
Зураг 16. Нутгийн иргэдийн нөхөрлөлийг хөгжүүлэх загвар	42
Зураг 17. Говь Алтай аймгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх оролцооны түвшин	44
Зураг 18. Говь Алтай аймгийн аялал жуулчлалын оролцогч талууд болон үйл ажиллагааны харилцан хамаарал	53
Зураг 19. Аялал жуулчлалын оролцогч талуудын уялдаа холбоо, хамаарал	54
Зураг 20. Говь Алтай аймгийн оролцоонд тулгуурласан аялал жуулчлалын загварчлал	55
Зураг 21. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөлтийг хэрэгжүүлэх төслийн ажлын явцын загвар	88
Зураг 22. Төсөл хэрэгжих явц дунд төсвийн зарцуулалт болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн олон улсын стандарт	89
Зураг 23. Цагийн менежментийн загвар	89
Зураг 24. Ж.Жафарын загвар	101
Зураг 25. Системийн загвар	102
Зураг 26. Олон улсын жуулчдын тоо болон аялал жуулчлалаас олсон орлого	105
Зураг 27. Жуулчдын аяллын зорилго	106
Зураг 28. Жуулчдын тооны өөрчлөлт бүс нутгаар	106
Зураг 29. Жуулчдын тооны урьдчилсан тооцоо, 2021-2024	106
Зураг 30. Ази болон Номхон далайн орнуудыг аялал жуулчлалын хэтийн төлөв	107
Зураг 31. Казакстанд ирсэн гадаадын жуулчдын тоо болон АЖ-ын салбарын орлогын хэмжээ	108
Зураг 32. ӨМӨЗО-д ирсэн гадаад жуулчдын тоо	109
Зураг 33. Дотоодын аялагчдын аялах чиглэл, аймгуудаар	111
Зураг 34. Аялал жуулчлалын бүс нутгийн ялгарал	112
Зураг 35. Жуулчдын тооны харьцаа бүс нутгаар	113
Зураг 36. Хятад жуулчдын Монгол орноор аялсан бүс нутгууд	114
Зураг 37. Баруун бүсийн аялал жуулчлалын үндсэн чиглэл	118
Зураг 38. Судалгаанд оролцогчдын насны бүлэг	119
Зураг 39. Судалгаанд оролцогчдын харъяалал	119
Зураг 40. Нэг жилд Монгол орноор аялах давтамж	120
Зураг 41. Монгол орноор аялах шалтгаан	121
Зураг 42. Говь-Алтай аймаг руу аялах аяллын замнал	122
Зураг 43. Аялах улирал	125
Зураг 44. Говь-Алтай аймаг руу аялах аяллын зорилго	125
Зураг 45. Аяллын үед хийхийг хүссэн зүйлс	128

Хүснэгийн жагсаалт

Хүснэгт 1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын Тусгай аяллын бүтээгдэхүүн	15
Хүснэгт 2. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын арга хэмжээ	18
Хүснэгт 3. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутаг дахь бүтээн байгуулалт ..	20
Хүснэгт 4. Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүсийн аяллынбүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх	25
Хүснэгт 5. Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх 7	25
Хүснэгт 6. Говь-Алтай аймгийн өмнөд бүсийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх	26
Хүснэгт 7. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын стратегийн замын зураг	43
Хүснэгт 8. Сургалтын чиглэл, хугацаа, үр дүн	57
Хүснэгт 9. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн төлөвлөлт	68
Хүснэгт 10. Эрсдэлийн үнэлгээний матриц	71
Хүснэгт 11. Гадаад орчны эрсдэлийн үнэлгээ	72
Хүснэгт 12. Гадаад орчны эрсдэлийн үнэлгээний матриц	79
Хүснэгт 13. Дотоод орчны эрсдэлийн матриц	79
Хүснэгт 14. Дотоод орчны эрсдэлийн үнэлгээ	85
Хүснэгт 15. Эрсдэлийн үнэлгээний нэгтгэл	87
Хүснэгт 16. Менежментийн хэрэгцээ	87
Хүснэгт 17. Хяналттай холбоотой нэвтрүүлэх менежментүүд.....	88
Хүснэгт 18. Аялал жуулчлалын үйл ажиллагааны стандарт.....	95
Хүснэгт 19. Ус болон ариун цэврийн байгууламжийн стандартууд.....	96
Хүснэгт 20. Стандарт болон норм дүрмийн жагсаалт	98
Хүснэгт 21. Үйлчилгээний технологи буюу олон улсын стандартууд.....	100
Хүснэгт 22. Маркетингийн зорилтууд ба тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд	104
Хүснэгт 23. Жуулчдын тооны өсөлт бүс нутгаар	105
Хүснэгт 24. Гадагшаа аялсан Казакстан улсын жуулчид/мян/	108
Хүснэгт 25. Монголын аялал жуулчлалын зах зээлийн харьцуулалт	109
Хүснэгт 27. Бүс нутгуудад аялсан жуулчдын тоо үзүүлэлт/ТХГН-т нэвтэрсэн хүний тоо/	113
Хүснэгт 28. Бүсүүдийн жуулчин хүлээн авах хүчин чадал	114
Хүснэгт 29. Баруун бүсээр аялсан хятад жуулчдын үнэлгээ.....	115
Хүснэгт 30. Жуулчны аялахаас өмнөх аяллын хүлээлт, аялсны дараах сэтгэл ханамж, дахин ирэх сонирхол	116
Хүснэгт 31. Зорих газрын эрэмбэ (жуулчны бодит сэтгэл ханамжаар).....	116
Хүснэгт 32. Нэгдсэн эрэмбийн дүн.....	117
Хүснэгт 33. 21 аймгийн байрлах хэрэгсэлийн судалгаа	118
Хүснэгт 34. Дотоодын аялагчдын аялсан аймгууд.....	120
Хүснэгт 35. Аяллын зохион байгуулах хэлбэр насны бүлгээр	122
Хүснэгт 36. Аяллын зохион байгуулах хэлбэр орлогын түвшингээр	122
Хүснэгт 37. Дотоодын аялагчдын Говь-Алтай аймгийн талаарх хандлага.....	123
Хүснэгт 38. Регрессийн шинжилгээний үр дүн.....	124
Хүснэгт 39. Говь-Алтай аймаг руу хийгдэх аяллын зорилго насны бүлгээр/хувиар/.....	126
Хүснэгт 40. Говь-Алтай аймаг руу хийгдэх аяллын зорилго дотоод аялагчдын харъялалаар/аялагчдын тоогоор/	126
Хүснэгт 41. Нэг өдөрт Говь-Алтай аймгийн аялалд зарцуулах зардал насны бүлгээр.....	127

1. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОНОЛ АРГА ЗҮЙ

1.1.1. Стратеги төлөвлөгөөний ажлын бүтэц

Говь-Алтай аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын бичиг 2021-2031 нь дараах бүтэцтэй хийгдсэн болно.

Үүнд:

Нэгдүгээрт, судалгаа, шинжилгээ буюу нөхцөл байдалдаа үнэлгээ өгөх;

Хоёрдугаарт, ач холбогдол бүхий асуудлуудыг тодорхойлох, төрөлжүүлэх;

Гуравдугаарт, санал үйл ажиллагааны төлөвлөлт;

Дөрөвдүгээрт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт гэсэн дөрвөн агуулгаас бүрдсэн болно.


Говь-Алтай аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын бичиг 2021-2031 нь “3-9-18” гэсэн агуулгатайгаар дараах ABCDE загварын дагуу төлөвлөгдөв. Ингэхдээ мэргэжилтнүүд болон орон нутгийн удирдлага, иргэд, байгууллагуудын саналыг тусгаж ажиллав.

Зураг 1. Стратеги төлөвлөгөөний загвар





Зураг 2. Аялалын бүс нутгийн судалгаа



Зураг 3. Аялалын нөөцийн судалгаа

Говь-Алтай аймгийн БОАЖГазар, Тусгай хамгаалалттай газар, ГАА Аялал Жуулчлалын Холбооны төлөөлөлтэй санал бодлоо солилцов
2021.10.29 , 2021.11.02 нд

2021.10.29

Уулзалтанд

ГАА БОАЖГазрын ахлах мэргэжилтэн

Я.Жаргалцэцэг, Г.Буянжаргал, ГИДЦГ-ийн О.Хүрэлбаатар, Эрэн нуур ЖБ захирал Б.Нарантуул, Г.Булгантамир, Чинзориг нар ГАА АЖХолбооны гүйцэтгэх захирал Ж. Гантогх

2021.11.02

Уулзалтанд

ГАА Аялал Жуулчлалын Холбооны гүйцэтгэх захирал Ж. Гантогх,

Монгол Элсний ТХГ дарга Г. Даржаа

Гэгээннуур ЖБ захирал



Зураг 4. Явцын эхний хэлэлцүүлэг



Зураг 5. Явцын хоёрдах хэлэлцүүлэг

1.1.2. Төлөвлөлтийн үндэслэл

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн стратегийг тодорхойлохдоо аялал жуулчлал, эдийн засаг, байгаль орчин, судлаач, зураглаач, ARCGIS кадастрын мэргэжилтэн, кино студи, хэвлэлийн байгууллагууд, аялал жуулчлалын холбоо, төр хувийн хэвшлийн аялал жуулчлалын мэргэжилтнүүд болон орон нутгийн удирдлага, иргэд, байгууллагуудын нөхцөл байдлыг тодорхойлов. Нөхцөл байдлын судалгааны ажил нь экспертийн шинжилгээний аргыг өргөн ашигласан бөгөөд баримтын судалгаа, асуудал шалтгааны шинжилгээ, ярилцлага, хэлэлцүүлэг зэрэг аргуудыг ашиглав.

Шинэ төрлийн коронавирусын халдварт өвчний цаг үеийн байдлаас шалтгаалан олон нийтийг хамарсан болон зарим шинжилгээний аргуудыг ашиглахад төвөгтэй байдал үүссэн болно. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжилд стратегийн ач холбогдол бүхий нөлөөллийн үйл ажиллагаанд судалгааны дараах зорилго, зорилтуудыг чиглүүлэв. Үүнд:

1. Аялал жуулчлалын салбарын төрийн бодлого, төлөвлөлт
2. Аялал жуулчлалын салбарын хууль эрх зүй
3. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн орчин
4. Аялал жуулчлалын салбарын технологийн орчин
5. Аялал жуулчлалын салбарын хүн ам зүй, нийгэм соёлын хүчин зүйл
6. Аялал жуулчлалын салбарын эрсдэлт хүчин зүйлс
7. Аялал жуулчлалын салбарын олон улсын хамтын ажиллагаа
8. Аялал жуулчлалын салбарын төр-хувийн хэвшлийн түншлэл

1.1.3. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БИЧИГ 2021-2031 ОН БАРИМТЛАХ ҮНДЭСЛЭЛ

1.1.3.1. Стратегийн нөхцөл байдал, томъёолол

Аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлс

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын бичиг 2021-2031 төслийн багийнхан гадаад орчны улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл, хүн, ам зүй, байгаль, экологи, технологи, олон улс, түншлэл, хэрэглэгч, өрсөлдөгч, хамтрагч, дэмжигч, бэлтгэн нийлүүлэгч, хөрөнгө оруулагч, орчны хүчин зүйлсийг тодорхойлон ажигласан.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах орчны нөлөөлөх байдлыг авч үзвэл гадаад орчны хувьд 62 боломж, аюул 40 байгаа бол нөлөөлөл эерэг байна. Ач холбогдлын зэрэглэлээр авч үзвэл улс төр, хэрэглэгч, технологи, олон улс зэрэг нь бусдаасаа илүү нөлөө үзүүлэхээр бол бусад орчин ерөнхий жигд нөлөөтэй байгаа нь харагдаж байна.

Аймгийн аялал жуулчлалын дотоод орчны хувьд давуу тал 38, сул тал 53 орчим нийт 193 хүчин зүйлс тодорхойлогдсон. Үүнээс ач холбогдлын зэрэглэлээр авч үзвэл ховор ан амьтан, байгалийн унаган төрх нэгдүгээр зэрэглэлтэй байгаа бол удирдлага, санаачлага дараагийн зэрэглэлийн нөлөөллийг үзүүлэхээр байна. Мөн дотоод орчны хувьд аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй байна. Аймгийн удирдлага, мэргэжлийн байгууллагын санаачилга сайн оролцоо сайн. Саяхан Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо байгуулагдан гүйцэтгэх захирлаа томилон ажиллаж бодлогын бичиг баримт боловсруулж буй багтаа уулзан санал бодлоо хуваалцсан. Аймгийн Засаг Даргын Тамгийн Газар, Байгаль Орчин Аялал Жуулчлалын Бодлого Төлөвлөлтийн Газар, сумдын удирдлагуудтай уулзалт хийхэд бүгд санал бодлоо нээлттэй хэлж аялал жуулчлалыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй байгаа нь сайн. Аливаа төслийг удирдах баг чин эрмэлзэлтэй байвал төсөл амжилттай хэрэгждэг.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хувьд хэдийгээр сул тал, аюул бэрхшээл байгаа хэдий ч боломж их, нийгэмд болон хамтрагчид үнэ цэнэ бий болгоход тэргүүлэх хангалттай давуу тал, бололцоо байгаа нь шинжилгээний дүнгээс илэрхий байна. Тиймээс аймгийн аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, хадгалахын тулд сул талаа арилгаж, бэрхшээлийг даван туулах замаар үйл ажиллагаагаа явуулах хамтын ажиллагааны менежментийн стратегийн томъёоллыг тодорхойлов.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын стратегийн томъёолол

Зураг 6. Аймгийн аялал жуулчлалын стратегийн томъёолол



Судалгааны үр дүнд 193 хүчин зүйлсийн тоогоор боломж давамгайлсан байна. Харин дотоод орчны давуу болон сул хүчин зүйлсийг харьцуулж үзэхэд 53 хүчин зүйлсээр сул тал давамгайлсан байна. Тус нөхцөл байдлаас үзэхэд дунд хугацааны буюу 5 жилээр стратегийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ. Паркийн хувьд хэдийгээр аюул, бэрхшээлүүд давамгайлж буй хэдий ч өргөн боломж, зах зээлд тэргүүлэх хангалттай давуу талууд байгаа нь шинжилгээний дүнгээс илэрхий байна. Тиймээс Парк нь аялал жуулчлалын салбар дахь байр сууриа тогтвортой хадгалахын тулд **“давуу тал, боломжоо ашиглан сул талаа арилгаж, бэрхшээлийг даван туулах”** замаар үйл ажиллагаагаа явуулах стратегийн томъёоллыг тодорхойлсон болно.

1.1.4. СТРАТЕГИЙН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

1.1.4.1. Стратегийн гол хүчин зүйлсийн шинжилгээний арга зүй

А.Х.Мексоны “5Х5” шинжилгээний арга нь байгууллагад шууд болон дам байдлаар нөлөөлөх орчны хүчин зүйлсийг илрүүлж, боломжуудыг ашиглан эрсдлээс зайлсхийх арга замыг тодорхойлдог. Тус аргачлалаар хийсэн шинжилгээний үр дүнд тулгуурлан хөгжлийн зорилго, зорилтуудыг чухал хүчин зүйлүүдийг үндэслэж, харин хамгийн чухал зүйлсэд тулгуурлан стратеги төлөвлөгөөний эрхэм зорилгыг тус тус тодорхойлсон болно.

Говь-Алтай аймгийн хамгийн давуу 5 хүчин зүйлс

1. Аймгийн хэмжээнд Говийн Их Дархан Газар А.Б, Хасагт Хайрхан, Монгол Элс, Хар Азрагын Нуруу, Ээж Хайрхан, Бурхан Буудай, Шарга Манхан, Алаг Хайрхан, Сутай Хайрхан зэрэг тусгай хамгаалалтай газрыг хамгаалан хамгаалтын захиргаа үйл ажиллагаа явуулж хамгаалж байна.
2. Дэлхийд болон Монгол оронд нэн ховор GG-6, Уулын эзэн Ирвэс, Аргаль, Янгир зэрэг амьтадыг хамгийн ойроос харах боломж
3. Аймгийн аялал жуулчлалыг эхнээс нь бодлогтойгоор хөгжүүлэхийг зорьж байгаа
4. Аяллын бүсэд олон төрлийн эвентийг зохион байгуулах боломж нөөц их. Мөн орон нутгийн иргэдийн оролцоотой бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх давуу талтай
5. Байгалийн босоо 6 бүсийг хамгийн богино зайд харах цорын ганц газар.

Говь-Алтай аймгийн хамгийн сул 5 хүчин зүйлс

1. Аялал жуулчлалын хөгжил тааруу, аялал жуулчлал хөгжсөн бүсээс алслагдмал
2. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хөгжил сул
3. Аялал жуулчлалын төлөвлөлт хийгдээгүй
4. Дэд бүтэц зам харилцаа сул хөгжсөн
5. Үзвэр хоорондын зай хол

Говь-Алтай аймгийн хамгийн таатай нөлөө бүхий 5 боломж

1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Говь-Алтай аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл зэрэг бодлогын баримт, Бүсчлэлийн хөгжлийн бичигт заасны дагуу тогтвортой аялал жуулчлал бүхий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулагдаж байна. Засгийн Газар болон орон нутгийн хөрөнгөөр аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд дэд бүтцийг сайжруулахаар ажил эхэлсэн, олон улс, монгол улсын хөтөлбөрүүдэд хамрагдаж хөрөнгө оруулалтыг шийдэж ажиллах боломжтой.
2. Говь-Алтай аймаг дахь байгалийн үзэсгэлэнт газрууд, ховор амьтан ургамалыг аяллын бүтээгдэхүүн болгох төлөвлөлтийг үнэ цэнэтэй тусгай сонирхлын аялал зохион байгуулах боломж байна.
3. Аймаг, орон нутгийн онцлогт тулгуурласан эвент бүтээгдэхүүн олныг зохион байгуулах.
4. Аялал жуулчлал харьцангуй сул хөгжсөн нь эхнээс зөв төлөвлөх.

5. Баруун бүсийн хатуу хучилттай зам аймгийн нутгаар дайран өнгөрдөг

Говь-Алтай аймгийн хамгийн аюултай 5 бэрхшээл

1. Улс төрийн тогтворгүй байдал болон аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, гадаад улс орнуудад сурталчлах үйл ажиллагааг бодлогын хувьд дэмжиж ажиллахгүйгээс үүдэн хууль эрх зүйн хүрээнд хэрэгжиж байгаа стандарт, дүрэм журам хэрэгжихгүй байх, цаашлаад дэмжигч олон улсын байгууллагууд дэмжиж ажиллахгүй байх нөхцөл бүрдэх эрсдэлтэй.
2. Цар тахал өвчний дэгдэлтээс шалтгаалан аялал жуулчлалын үйл ажиллагааг тогтвортой явагдахад хүндрэл үүсэх 2023 он хүртэл аялал жуулчлалын салбар сэргэхгүй байх
3. Аяллын газруудад байгальд ээлтэй жуулчны бааз, үзмэрийн газар, дэд бүтцийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана
4. Жуулчдын урсгал нэмэгдсэнээр зэрлэг ан амьтан дайжих
5. Аялал жуулчлалын бүх талын оролцоог хагахгүй бол хэрэгжихгүй байх

Говь-Алтай аймгийн хамгийн чухал 5 хүчин зүйлс

Дээр дурьдсан аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаанд нөлөөлж буй 20 хүчин зүйлсээс хамгийн чухал нөлөө үзүүлж буй 5 хүчин зүйлийг сонгон авч үзлээ. Эдгээр нь:

1. Хамгийн давуу тал: Дэлхийд болон Монгол оронд нэн ховор GG-6, Уулын эзэн Ирвэс, Аргаль, Янгир зэрэг амьтадыг хамгийн ойроос харах боломж
2. Хамгийн сул тал: Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хөгжил сул
3. Хамгийн таатай боломж: Аялал жуулчлалын нөөцөд тулгуурлан тус аймагт брэнд аялал жуулчлал бий болох, бусад аймгуудаас ялгарах дүр төрхийг бий болгох
4. Хамгийн таатай боломж: Засгийн газрын бодлого төлөвлөлтөнд байгальд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх
5. Хамгийн аюултай бэрхшээл: Аяллын газруудад байгальд ээлтэй жуулчны бааз, үзмэрийн газар, дэд бүтцийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн үзэл баримтлалын агуулга

1. Байгалийн үзэсгэлэнт тусгай хамгаалалттай газрууд, ховор ан амьтад жуулчдын зорих газар
2. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2050, аялал жуулчлалын хөгжлийн зорилго, зорилтууд
3. Иргэдийн оролцоотой аялал жуулчлал
4. Аймгийн аялал жуулчлалыг бодлоготойгоор төлөвлөх
5. Аяллын нөөцийг хамгаалангаа ашиглах

1.1.5. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО 2021-2031 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

1.1.5.1. Говь-Алтай аймгийн стратегийн үзэл баримтлал

Говь-Алтай аймгийн байгалийн нөөцийг хамгаалангаа ашиглах

СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Говь-Алтай аймгийн стратегийн үндсэн чиглэл нь:

1. Байгалийг хамгаалангаа ашиглах үнэ цэнэ
2. Иргэддээ чиглэсэн үнэ цэнэ гэсэн хоёр үндсэн стратегийг баримтлах нь зүйтэй гэж ажлын хэсэг тодорхойлсон болно.

Зураг 7. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын стратегийн модель



1.1.5.2. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын стратеги

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого нь “3-9-18 ” гэсэн үзэл баримтлалын хүрээнд стратегийг хэрэгжүүлэнэ.

Тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх “3” гэсэн томъёоллын хөгжлийн зорилгууд

Тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх “3” гэсэн томъёоллын хөгжлийн зорилгууд нь дараах үндсэн чиглэлүүдтэй байна. Үүнд:

1. Нийгмийн тогтвортой хөгжлийн асуудлууд
2. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн асуудлууд
3. Байгаль экологи, хүрээлэн буй орчны асуудлууд

Гадаад орчны шинжилгээнээс үзвэл нийт 102 гаруй хүчин зүйлсийг иргэд, байгууллагууд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор тодорхойлсон байна. Эдгээрээс боломжийн тоо 62 хүчин зүйлсийн тоогоор давамгайлсан байгаа нь анхаарал татаж байна. Харин аюул бэрхшээл багагүй байгаа нь Говь-Алтай аймгийн орон нутгийн удирдлага, орон нутгаас сонгогдсон Засгийн Газрын гишүүдэд тулгамдаж буй саад бэрхшээлийг ойлгуулан холбогдох төр, захиргааны төв байгууллагуудтай хамтран зөвшилцөх, шийдвэрлэх тал дээр санаачлагатай ажиллах нь чухал юм.

Тэдгээрийн бэрхшээлүүдийг эрэмбэлж үзвэл

- *Нэгдүгээрт*-Эдийн засгийн хүчин зүйлс онцгой нөлөөтэй байгаа нь судалгаанаас тодорхой байна. Тэр тусмаа зам харилцаа нэлээд анхаарах.
- *Хоёрдугаарт*-Тулгамдаж буй асуудлыг авч үзвэл улс төрийн орчин хамтын ажиллагааг анхаарах
- *Гуравдугаарт*-Эрх зүйн хүчин зүйлс өндөр нөлөөлөлтэй байгаа нь нийгэмд чиглэсэн асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр эн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Иймд 2021-2031 онуудад хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөө нь *улс төр, эрх зүй, эдийн засгийн* хувьд гишүүдэд тодорхой тулгамдсан нийгмийн асуудлуудад үйл ажиллагаагаа чиглүүлэх шаардлага байгаа нь тодорхой байна.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс нутгийн нөөцийн “3” гэсэн томъёоллын хөгжлийн зорилгууд

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний зохистой оролцоог бий болгох стратегийн ач холбогдол бүхий нөөцүүдийг судалсны үндсэн дээр “3-9-18” гэсэн үзэл баримтлалын “3 ” гэсэн томъёоллын хөгжлийн зорилгууд нь дараах үндсэн чиглэлүүдтэй байна. Үүнд: Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын Үндсэн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээ, аялал жуулчлалын бүсчлэл

- **Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ** (Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайшир, Дэлгэр)
- **Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ**(Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга)
- **Говь-Алтай аймгийн өмнөд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ** (Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун, Есөнбулаг)

Гурван бүсээр хөгжүүлэх нь хамгийн оновчтой гэж тодорхойлж байгаа.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн “9” гэсэн томъёоллын хөгжлийн зорилгууд

Байгууллагын хөгжлийн үндсэн зорилгууд нь дараах байдлаар тодорхойлогддог. Үүнд:

1. Системийн хүрээнд
2. Хөгжлийн бодлогын хүрээнд
3. Аялал жуулчлалын онолын хүрээнд

Дээр дурдсан гурван шаардлагыг үндэс болгон Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн 9 үндсэн зорилго ба дотоод үйл ажиллагаанд чиглэсэн зорилгуудыг тодорхойлов.

Говь-Алтай аймгийн дотооддоо хэрэгжүүлэх “3-9-18” гэсэн үзэл баримтлалын “9” гэсэн томъёоллын хөгжлийн зорилгууд нь дараах үндсэн чиглэлүүдтэй байна. Үүнд:

1. Удирдлага ба засаглалын хөгжил
2. Аялал жуулчлалын гурван бүсийн үйл ажиллагааны хөгжил

3. Аялал жуулчлалын хөтөлбөрийн үйл ажиллагааны хөгжил
4. Маркетингийн хөгжил
5. Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, чанар стандартын хөгжил
6. Нутгийн иргэдэд чиглэсэн аялал жуулчлалын хөгжил
7. Хүний нөөцийн хөгжил
8. Дэд бүтэц, барилга, техник технологи, материаллаг баазын хөгжил
9. Санхүү, хөрөнгө оруулалтын хөгжил

Дээр дурдсан 9 бүлэг зорилгуудаар дотоод менежментийн чадамжийг сайжруулахаар төлөвлөн ажиллах нь зүйтэй болно. Мөн гурван бүсийг хөгжүүлэх хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд бүс тус бүрийг дэмжих тусгай аяллын 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ 9 хөтөлбөр нь өөр өөрийн онцлог бүхий нутгийн иргэдийг дэмжсэн тогтвортой байдлыг хангасан байх. Үүнийг дараах байдлаар төлөвлөн хөгжүүлэх нь зүй.

Хүснэгт 1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын Тусгай аяллын бүтээгдэхүүн

Тусгай аяллын нэр	Онцлог	Гол үзвэр	Байршил	Хугацаа	
Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүс (Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайшир, Дэлгэр)					
1	Ирвэс ажиглах аялал	Байгалийн 6 бүслүүрийг нэг дор үзэх боломж	Ирвэс	Хасагт хайрхан уул	Жилийн аль ч улиралд
2	Байгалийн бүс бүслүүр өвөрмөц тогтоцтой газраар аялах	400 км үргэлжилэх элсэн манхан	Элс, байгалийн онцлог шинж бүхий газар, ховор ургамал,	Эрээн, Дөргөн нуур, Монгол элс	Жилийн аль ч улиралд
3	Элсний морин аялал	Манхан элс, Эрээн нуурын орчимд мориор аялах	Элсний морин аялал	Эрээн нуурын жуулчны баазууд, иргэдийн нөхөрлөл	5 сараас 10 сарыг дуустал
4	Ховор ургамал, амьтны зураг авах аялал	Байгалийн үзэсгэлэнт хасагт хайрхан ууланд ургамал, амьтны зураг авах	Улаан номонд орсон ургамал, амьтан	Хасагт хайрхан, Гэгээн, Хөх морьт, Баян-Уул, Эрээн нуур, Завхан гол орчим	Жилийн аль ч улиралд
5	Монгол үндэсний эко хоол хүнс зоог барих аялал	Халтар арвай, хөх арвай, сульхир,	Эрүүл мэндийн хоол зооглон байгалийн өвөрмөц тогтоцтой газарт	Баян-Уул, Жаргалан Хөх морьт, Баян-Уул, Тайшир, Дэлгэр сумын нутаг	5 сараас 10 сарыг дуустал
6	SPA хүнхэрийн рашааны аялал	Ходоод таван цулын рашаан	Хасагт хайрхан уулын байгалийн гоо үзэмж, рашаан	Хасагт хайрхан Хүнхэр	7 сараас 10 сар хүртэл
7	Түүх соёлын дурсгалт газраар аялах аялал	Үл хөдлөх дурсгалыг судлах ЭШ судалгааны аялал	Хүн чулуу, Булш хиргисүүр, сүм хийдийн туурь, хадны зураг	Хөх морьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Дэлгэр сумын нутаг	6 сараас 9 сар дуустал
8	Тэмээн аялал	Элсэн манханаар тэмээгээр аялах	Малчин айлын зан үйл	Хөх морьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир,	Жилийн аль ч улиралд

БОТЬ II- СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

9	Малчин айлд зочилох аялал	Мал маллах уламжлал, цагаан идээ	Нүүдэлчидийн соёл	Хөх морьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Дэлгэр сумын нутаг	Жилийн аль ч улиралд
Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аялал (Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга)					
1	GG -6 аялал (Монгол бөхөн, хар сүүлт)	Мөстлөгөөс үлдсэн зөвхөн монголд байдаг амьтан	Монгол бөхөн	Шарга манханы тал	Жилийн аль ч улиралд
2	GG -6 аялал (Тахи, Хулан, Хар сүүлт)	Дэлхийн нэн ховор амьтныг нэг дор харах, судлах зураг авах боломж	Тахи, Хулан, Хар сүүл	Говийн Их дархан газар Б (Зүүн гарын говь)	Жилийн аль ч улиралд
3	Палеонтологи, байгалийн үзэсгэлэнт газрын зураг авах хосолсон аялал	Улсын тусгай хамгаалтанд авсан дурсгал Юра, Цэрдийн үеийн олдвор	эртний амьтан ургамлын чулуужсан олдвор	Говь-Алтай Алтай сум Шар тээг	Тусгай зөвшөөрлөөр
4	Палеонтологи, байгалийн үзэсгэлэнт газрын зураг авах хосолсон аялал	Улсын тусгай хамгаалтанд авсан дурсгал Юра, Цэрдийн үеийн олдвор	Үлэг гүрвэл Завропод, теропод, ургамал, шавжийн олдвор	Говь-Алтай аймгийн Дарви сум Гурван Эрээний нуруу	Тусгай зөвшөөрлөөр
5	Сүсэг бишрэлийн аялал	Сутай хайрхан Галдан хааны онгон	Сутай Хархан уул Ацын хар уул	Говь-Алтай аймгийн Тонхил сум Хар хяраачийн ар үзүүр	Жилийн аль ч улиралд
6	Тэмээчин айлын зан үйл, ингэний сүүний сувиллын аялал	Хос зогдорт тэмээ маллан амьдрах тэмээчин өрхүүд	Хос зогдорт тэмээ, Орсон буур, Тэмээний баяр, тэмээн аялал, ингэний сүү, сувилал	Говь-Алтай аймгийн Шарга, Төгрөг, сум	Жилийн аль ч улиралд
7	Түүх соёлын аялал	Хүннү-Их Монгол-Богд Хаант Монгол	Хүн чулуу, буган чулуу, хиргисүүр, хот балгадын туурь	Говь-Алтай аймгийн Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга	Жилийн аль ч улиралд
8	Малчин айлд зочилох аялал	Нүүдэлчдийн соёл, мал маллагааны уламжлал, идээ ундааны соёл	Өндөр уулаас говийн бүсийн малчин өрхүүдийн онцлог	Говь-Алтай аймгийн Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга	Жилийн аль ч улиралд
9	Ховор амьтан ургамлын зураг авах судлах аялал	Дэлхий, Монголын улаан номонд орсон амьтан ургамал	Зөвхөн Монгол, Говь-Алтайд байдаг Унаган ургамал, амтан	Говь-Алтай аймгийн Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга	Жилийн аль ч улиралд
Говь-Алтай аймгийн өмнөд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ (Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун, Есөнбулаг)					
1	GG -6 аялал (Мазаалай, Хавтгай, Хулан, Хар сүүлт)	Дэлхийн нэн ховор амьтныг нэг дор харах судлах зураг авах боломж	Тахи, Хулан, Хар сүүл	Говийн Их дархан газар Б (Зүүн гарын говь)	Жилийн аль ч улиралд

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

2	Палеонтологи, байгалийн үзэсгэлэнт газрын зураг авах хосолсон аялал	Улсын тусгай хамгаалтанд авсан дурсгал Юра, Цэрдийн үеийн олдвор	эртний амьтан ургамлын чулуужсан олдвор	Говь-Алтай аймгийн Бигэрийн явар, Аж Богд, Улаан ганга, Бунгийн гол	Тусгай зөвшөөрлөөр
3	Байгалийн зураг авах аялал	Уулс, Говь хээрт хослон орших байгалийн онцлог газрууд	Бурхан буудай, Говийн Их дархан газар, Хар Азрага, Ээж хайрхан, Зоос хад, Явар, Уулсын хавцалууд, Говь	Говь-Алтай аймгийн Бигэр, Цогт, Цээл, Халиун сумын нутаг	Жилийн альч улиралд
4	Сүсэг бишрэлийн аялал	Байгаль, Шашны зан үйлийн	Бигэр Номуун хааны туурь, Ээж хайрхан уул, Бурхан буудай, Зоос хад, Аав хөшөө	Говь-Алтай аймгийн Бигэр, Цогт, Баянтоорой, Чандмань, Эрдэнэ, Халиун сумын нутаг	6 сараас 11 сар
5	Эрдэм Шинжилгээ судалгааны аялал	Бурхан буудай, Говийн Их дархан газар, Хар Азрага, Ээж хайрхан,	Говийн ургамал, амьтан, байгаль	Говь-Алтай аймгийн Бигэр, Цогт, Цээл, Халиун сумын нутаг	Тусгай зөвшөөрлөөр
6	Малчин айлд зочилох аялал	Нүүдэлчдийн соёл, мал маллагааны уламжлал, идээ ундааны соёл	Өндөр уулаас говийн бүсийн малчин өрхүүдийн онцлог	Говь-Алтай аймгийн Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун	Жилийн альч улиралд
7	Агро аялал	Газрын алим, Цацаргана, Виски, Оргилуун дарс, жимс жимсгэнэ амтлах	Говь, Уул хоорондын хөндийд тариалж байгаа нутгийн бренд бүтээгдэхүүнийг амтлах	Говь-Алтай аймгийн Бигэр, Халиун	6 сараас 11 сар
8	Монгол үндэсний эко хоол хүнс зоог барих аялал	Говийн идээ ундаа зооглох	Эрүүл мэндийн хоол зооглон байгалийн өвөрмөц тогтоцтой газарт	Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун	5 сараас 10 сарыг дуустал
9	Эрүүл мэнд сувилалын аялал	Бөөрний сувилал	Элсэн манхан дундах рашаан сувилалд амрах	Говь-Алтай аймгийн Бигэр сум	7 сараас 9 сар

Говь-Алтай аймгийн дотооддоо хэрэгжүүлэх “3-9-18” гэсэн үзэл баримтлалын “18” гэсэн томъёоллын хөгжлийн зорилтууд нь дараах үндсэн чиглэлүүдтэй байна. Үүнд: Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 3 бүсийн 9х3 н аяллын бүтээгдэхүүнийг дэмжин хөгжүүлэх 18-н Эвентийг төлөвлөсөн. Эдгээр арга хэмжээ нь аяллын нөөцийн рекреацийн үнэлгээ, нөөцийн орон зай, бүс нутгийн төлөвлөлтөнд тулгуурлан тодорхойлогдсон. Үүнийг дараах байдлаар төлөвлөх

Хүснэгт 2. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын арга хэмжээ

№	Арга хэмжээ	Онцлог	Болох газар	хугацаа
Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүс (Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайшир, Дэлгэр)				
1	Элсний эвент	Элсний чарга, элсний тэмээн поло, үндэсний зоог, элсний аялал	Говь-Алтайн Жаргалан сум	7 сараас 10 сар хүртэл
2	Уулын эзэн Ирвэс эвент	Ирвэс өсгөн үржихэд тааламжтай орчин нөхцөл бүрдүүлэхэд хөрөнгө оруулах аялал	Говь-Алтайн Жаргалан сум Хасагт хайрхан уул	Жилд 2 удаа ()
3	Эрүүл Монгол-Алтай рашаан сувилал эко хоол эвент	Биеэ эрүүлжүүлэх, эрүүл мэндийн аялал	Говь-Алтайн Жаргалан, Хөхморьт, Тайшир, Баян- Уул	
4	Фото сафари эвент	Хасагт хайрхан, Даривийн нуруу, Жаргалант хайрхан	Говь-Алтайн Жаргалан сум	5 сараас 12 сар
5	Ургацын баяр эвент	Эко хүнс, генийн өөрчлөлтгүй бүтээгдэхүүн	Говь-Алтайн Тайшир	9-10 сард
6	Мөсний баяр эвент	Хүний гараар бүтээсэн Монголын хамгийн том нуур	Говь-Алтайн Тайшир Гэгээн нуур	2-3 сард
Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аялал (Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга)				
7	Сутай хайрханы тахилга эвент	Төрийн тахилгат уул	Тонхил сум Сутай хайрханы орчим	2025,2029,2033 онууд
8	Галдан Бошгот хааны онгон шүтээн шашны зан үйлийн эвент	Шашны зан үйл, сүсэг бишрэл	Тонхил сум Галдан хааны онгон шүтээн цогцолбор	
9	GG-6 Говь-Алтай эвент (Тахь, Хулан, Хар сүүлт, Бөхөн)	Тахь, Хулан, Хар сүүлт, Бөхөн тус тусд нь арга хэмжээ зохион байгуулж амьдрах орчныг нь сайжруулах хөрөнгө оруулах	Говийн Их дархан газар Б, Тахийн тал, Төгрөг сумын Жуулчны бааз, сувилал	5 сараас дараа оны 2 сар хүртэл
10	Тэмээний баяр эвент	Хос зогдорт тэмээний баяр (нүүдэллэх,ингэний сүүний сувилал)	Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Жуулчны бааз, сувилал	5 сараас дараа оны 2 сар хүртэл
11	Ан амьтан, байгалийн зураг авах эвент	Аргаль, Янгир, Алтайн хойлог, улаан номонд орсон	Говь- Алтай аймгийн Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга	Ан амьтан ургамлын амьдралын онцлогийг

		ховордсон ургамал амьтны зураг авах		харгалзан цаг хугацааг тодорхойлох
Говь-Алтай аймгийн өмнөд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ (Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун, Есөнбулаг)				
12	Ээжийн элбэрэл эвент	Ээжийг алдаршуулах, Ээж Хайрхан уулын байгалийн сайхнаар аялах	Говь-Алтай аймгийн Баянтоорой, Цогт сум	4 сараас 10 сар хүртэл
13	Тоорой мод эвент	Дэлхийд ховор ТООРОЙ модыг ургуулах, үржүүлэхэд хөрөнгө оруулах	Говь-Алтай аймгийн Баянтоорой сум	6 сард
14	GG-6 Говь-Алтай эвент (Мазаалай, Хавтгай, Хар сүүлт)	Мазаалай, Хавтгай, Хар сүүлтийн амьдралын орчныг сайжруулах, өсгөх үйлд хөрөнгө оруулах	Говь-Алтай аймгийн Баянтоорой, Цогт сум	5 сараас дараа оны 2 сар хүртэл
15	Ан амьтан, байгалийн зураг авах эвент	Аргаль, Янгир, Алтайн хойлог, Ирвэс, улаан номонд орёон хордсон ургамал амьтны зураг авах	Говь-Алтай аймгийн Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун, Есөнбулаг	Ан амьтан ургамлын амьдралын онцлогийг харгалзан цаг хугацааг тодорхойлох
16	Эрүүл Монгол-Алтай рашаан сувилал эко хоол эвент	Таван элсний сувилал, жимс жимсгэнэ, идээ ундаа,	Говь-Алтай аймгийн Бигэр, Халиун сум	6 сараас 9 сар
17	Говь-Алтайн соёлын наадам	Аймгийн соёл, зан заншил, угсаатны наадам	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум	7,8 сар
18	Алтайн хотын Мазаалай Парк аялал жуулчлал нутгийн бред бүтээгдэхүүний эвент	Аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүнийг дэмжих жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум	6-9 сар

Говь-Алтай аймгийн байгаль газарзүй, нөөцийн судалгаа, “ATTRACTION” үүсгэж, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах боломжтой болох юм.

Байгалийн нөөцөд түшиглэн дээрх стратегийг хэрэгжүүлэхэд туслах бүс нутгийн бүтээн байгуулалтыг дараах байдлаар төлөвлөж байна.

Хүснэгт 3. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутаг дахь бүтээн байгуулалт

№	Бүтээн байгуулалт	Онцлог	Байгуулах газрын байршил	Хүчин чадал		Ажиллах хугацаа
				2021	2031	
Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүс (Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайшир, Дэлгэр)						
1	Эрээн нуур жуулчны бааз	Олон улсын элсний гар бөмбөгийн сургалтын төв бааз	Говь-Алтай аймгийн Жаргалан сум Эрээн нуур	45 ор	99 ор	5 сараас 11 сар
2	Гэгээн нуур жуулчны бааз	Амрагч жуулчинд үйлчилэх хиймэл бассейн бүхий	Говь-Алтай аймгийн Тайшир сум 1-р баг	30 ор	50 ор	5 сараас 10 сар
3	Nomadic camp	Нүүдлийн ж/б	Аялалын бүс нутагт нүүдэллэн байрлана	40 ор	60 ор	5 сараас 9 сар
4	Амьтан ажиглах отог	Баянбогд хайхан, Бүрэн хайрхан, Хасагт хайрхан	Нэр бүхий ууланд ТХГ зөвшилцөх	10 ор	20 ор	5 сараас 11 сар
5	Хүнхэрийн амралт	Эмчилгээ сувилгаа	Говь-Алтай аймгийн Жаргалан сум	150 ор	150 ор	5 сараас 9 сар
Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аялал (Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга)						
6	Галдан хааны шүтээн цогцолбор	Буддын шашны онцлог бүхий зан үйлийн	Говь-Алтай аймгийн Тонхил сумын Хяр Хараачийн уулын Баруун хойд үзүүр (Цогнооч)		55 ор	5 сараас 9 сар
7	Тахийн талын амьтан үржүүлгийн парк	GG-6 (Тахь, Хулан, Харсүүлт) эвэнт арга хэмжээг зохион байгуулах	Говь-Алтай аймгийн Бугат сумын Биж баг тахь үржүүлгийн төв		30 ор	5 сараас 10 сар
8	Монгол бөхөн бааз	Монгол бөхөн, Хос зогдорт Төгрөгийн хүрэн тэмээнд түшиглэсэн Ингэний сувилал	Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Тунгалаг баг		55 ор	5 сараас 10 сар
9	Алаг хайрханы отог	Ховор амьтан ажиглах аяллын отог	Говь-Алтай аймгийн Бугат сумын Алаг хайрхан уул		15 ор	5 сараас 9 сар

Говь-Алтай аймгийн өмнөд бүс (Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун, Есөнбулаг)						
10	Бурхан буудай бааз	Байгальд түшиглэсэн бааз	Говь-Алтай аймгийн Бигэр сумын Улаан яварын урд үзүүр		55 ор	5 сараас 10 сар
11	Бигэрийн таван элс	Бөөрний сувилал	Говь-Алтай аймгийн Бигэр сумын таван элс		150 ор	6 сараас 9 сар
12	Ээж хайрхан уул	Байгалийн өвөрмөц тогтоцот уулд түшиглэсэн бааз	Говь-Алтай аймгийн Баянтоорой сум Ээж хайрхан уулын зүүн бэл Хөшөөний дэргэд	20	99 ор	4 сараас 9 сар
13	Баянтоорой отог	GG-6(мазаалай, хавтгай, харсүүлт)	Говь-Алтай аймгийн Баянтоорой сум		33 ор	5 сараас 9 сар
14	Аялал жуулчлалын мэдээллийн төвийн төв цогцолбор	Говь-Алтай аймгийн аяллын тур оператор, нутгийн бренд, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээний төв цогцолбор	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум Мазаалай паркт		150 суудал	Жилийн улирал 4

1.1.6. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС

1.1.6.1. Алсын хараа

Нутгийн иргэдийг дэмжин тогтвортой хөгжлийг хангаж олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зорилтот аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.1.6.2. Эрхэм зорилго

Говь-Алтай аймгийн аялал жуулчлал нь байгалийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалыг хүрээлэн буй орчны менежмент, стандартад нийцүүлэн бодлогын хүрээнд хөгжүүлнэ.

1.1.6.3. Үнэт зүйлс

1. ҮНЭ ЦЭНЭТЭЙ БАЙДАЛ

Судалгаа шинжилгээ тулгуурласан байгаль экологийн үнэ цэнийг бүтээх

2. ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

Ургамал, амьтан, биологийн төрөл зүйлийн тэнцвэр, унаган төрхийг хадгалах

3. ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Байгаль, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг эрхэмлэнэ. Нутгийн иргэд болон бусад оролцогч талуудын сонирхлыг нэгтгэх

4. БҮТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Аяллын нөөцөд тулгуурлан тусгай сонирхлын үнэ цэнэтэй аяллын төрлийг хөгжүүлэх

5. ШИНЭЛЭГ САНАА ИННОВАЦИ

Олон улсын стандарт нийцсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх

1.1.6.4. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн зорилгууд

1. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО (3)
2. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО (9)
3. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО (18)

1.1.7. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТУУД**1.1.7.1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн зорилтууд****Хөгжлийн зорилт 1.1 Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн нийгмийн тогтвортой байдлыг дэмжих**

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд аялал жуулчлалын 3- н бүс орчмын иргэд болон аймгийн иргэдийг хамруулах замаар стратегийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1. Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох
2. Байгаль орчин, аялал жуулчлал, бизнес эрхлэхтэй холбоотой чадамжид суурилсан хүний хөгжлийг дэмжсэн сургалт зохион байгуулах
3. Аймгийн аяллын бүсийг хөгжүүлэх тогтолцоог нээлттэй, хүртээмжтэй, тэгш оролцоонд тулгуурласан бизнес орчинг бүрдүүлэх
4. Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллах
5. Бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог нэвтрүүлэх

Хөгжлийн зорилт 1.2 Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд хөрш улс, аймгуудын аялал жуулчлалтай хамтын ажиллагааг хийж стратегийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1. Хамтран ажиллах тогтолцоог бий болгох замаар үйлчилгээний салбарыг хөгжүүлэх
2. Бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бий болгох замаар нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх
3. Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нутгийн иргэдийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллах
4. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, хэлэлцээрүүдийг байгуулж, томоохон төслүүдийг хэрэгжүүлэх

5. ОУ-ын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллах

Хөгжлийн зорилт 1.3 Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн байгаль экологи, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг дэмжих

Байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно.

1. Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах
2. Байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах; цэвэр технологийг дэмжих,
3. Хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх;
4. Байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх;
5. Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх
6. Усны нөөцийн нэгдсэн менежмент - Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.
7. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх
8. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх
9. Экосистемийн тэнцвэрт байдал - Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгалах

1.1.7.2. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийн урт, дунд хугацааны зорилтууд

Хөгжлийн зорилт 2.1 Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын стратегийн ач холбогдол бүхий нөөцүүдийг судалсны үндсэн дээр аялал жуулчлалын үйл ажиллагааг хоорондоо хамаарал бүхий зорих газар “ATTRACTION” үүсгэж, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах шаардлагатай.

1. Есөнбулаг сумд аймгийн аялал жуулчлалын мэдээлэл, үйлчилгээний төв байгуулах
2. Аяллын бүс бүрт голлох үйлчилгээ үзүүлэх баазыг байгуулах
3. Түр амрах, үдлэх отгуудыг байгуулах
4. Аялал жуулчлалын иргэдийн нөхөрлөл байгуулах
5. Амралт сувилалын газруудыг сайжруулах
6. Эвент арга хэмжээг хөгжүүлэх

Хөгжлийн зорилт 2.2 Говь- Алтай аймгийн аялал жуулчлалын Үндсэн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээ, аялал жуулчлалын бүсчлэл

1. Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ (Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайшир, Дэлгэр)
2. Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ (Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга)
3. Говь-Алтай аймгийн өмнөд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ (Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл, Халиун, Есөнбулаг)

Хөгжлийн зорилт 2.3 Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх (Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайшир, Дэлгэр)

Хүснэгт 4. Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх

№	Бүтээн байгуулалт	Онцлог	Байгуулах газрын байршил	Хүчин чадал	Ажиллах хугацаа
				2031	
Говь-Алтай аймгийн зүүн, зүүн хойд бүс (Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайшир, Дэлгэр)					
1	Эрээн нуур жуулчны бааз	Олон улсын элсний гар бөмбөгийн сургалтын төв бааз	Говь-Алтай аймгийн Жаргалан сум Эрээн нуур	99 ор	5 сараас 11 сар
2	Гэгээн нуур жуулчны бааз	Амрагч жуулчинд үйлчилэх хиймэл бассейн бүхий	Говь-Алтай аймгийн Тайшир сум 1-р баг	50 ор	5 сараас 10 сар
3	Nomadic camp	Нүүдлийн ж/б	Нүүдлийн	60 ор	5 сараас 9 сар
4	Амьтан ажиглах отог	Баянбогд хайхан, Бүрэн хайрхан, Хасагт хайрхан	Нэр бүхий ууланд ТХГ зөвшилцөх	20 ор	5 сараас 11 сар
5	Хүнхэрийн амралт	Эмчилгээ сувилгаа	Говь-Алтай аймгийн Жаргалан сум	150 ор	5 сараас 9 сар

Хөгжлийн зорилт 2.4 Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх (Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга)

Хүснэгт 5. Говь-Алтай аймгийн баруун, баруун хойд бүсийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх 7

№	Бүтээн байгуулалт	Онцлог	Байгуулах газрын байршил	Хүчин чадал	Ажиллах хугацаа
6	Галдан хааны шүтээн цогцолбор	Буддын шашны онцлог бүхий зан үйлийн	Говь-Алтай аймгийн Тонхил сумын Хяр Хараачийн уулын Баруун хойд үзүүр (Цогнооч)	55 ор	5 сараас 9 сар
7	Тахийн талын амьтан үржүүлгийн парк	GG-6 (Тахь, Хулан, Харсүүлт) эвэнт арга хэмжээг зохион байгуулах	Говь-Алтай аймгийн Бугат сумын Биж баг тахь үржүүлгийн төв	33 ор	5 сараас 10 сар
8	Монгол бөхөн бааз	Монгол бөхөн, Хос зогдорт Төгрөгийн хүрэн тэмээнд түшиглэсэн Ингэний сувилал	Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Тунгалаг баг	55 ор	5 сараас 10 сар

9	Алаг хайрханы отог	Ховор амьтан ажиглах аяллын отог	Говь-Алтай аймгийн сумын хайрхан уул	Бугат Алаг	20 ор	5 сараас 9 сар
---	--------------------	----------------------------------	--------------------------------------	------------	-------	----------------

Хөгжлийн зорилт 2.5 Говь-Алтай аймгийн өмнөд бүсийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх (Чандмань, Эрдэнэ, Бигэр, Цогт, Цээл, Есөнбулаг)

Хүснэгт 6. Говь-Алтай аймгийн өмнөд бүсийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх

№	Бүтээн байгуулалт	Онцлог	Байгуулах газрын байршил	Хүчин чадал	Ажиллах хугацаа
10	Бурхан буудай бааз	Байгальд түшиглэсэн бааз	Говь-Алтай аймгийн Бигэр сумын Улаан яварын урд үзүүр	55 ор	5 сараас 10 сар
11	Бигэрийн таван элс	Бөөрний сувилал	Говь-Алтай аймгийн Бигэр сумын таван элс	150 ор	6 сараас 9 сар
12	Ээж хайрхан уул	Байгалийн өвөрмөц тогтоцот уулд түшиглэсэн бааз	Говь-Алтай аймгийн Баянтоорой сум Ээж хайрхан уулын зүүн бэл Хөшөөний дэргэд	99 ор	4 сараас 9 сар
13	Баянтоорой отог	GG-6(мазаалай, хавтгай, харсүүлт)	Говь-Алтай аймгийн Баянтоорой сум	33 ор	5 сараас 9 сар
14	Аялал жуулчлалын мэдээллийн төвийн төв цогцолбор	Говь-Алтай аймгийн аяллын тур оператор, нутгийн бренд, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээний төв цогцолбор	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум Мазаалай парк	150 суудал	Жилийн улирал 4

1.1.7.3. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааны хөгжлийн урт, дунд хугацааны зорилтууд

Монгол улсын “Тогтвортой хөгжил-2050”, Тогтвортой хөгжлийн зорилтууд-2050, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, салбарын бодлого зорилтууд, Говь-Алтай аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлт болон хууль эрх зүй, эдийн засаг, байгаль экологи, олон улсын хандлага, технологийн шийдэл, зах зээл, бэлтгэн нийлүүлэгчдийн судалгааны үр дүнд аймгийн хөгжлийн зорилго, зорилтууд болон хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон болно.

Хөгжлийн зорилт 3.1 Удирдлага, зохион байгуулалтын хөгжил

Засаглал, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож орчин үеийн менежментийн хандлагыг нэвтрүүлнэ.

1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалд оролцогч талуудын харилцаа хамтын ажиллагааны менежментийг хөгжүүлэх
2. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэх чиглэлээр байнгын үйл ажиллагаатай албан бус бүтцийг байгуулах

3. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх стратеги, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулж, салбар хоорондын зохицуулалт хийх, үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах
4. Төслийн удирдлагыг нэвтрүүлж бэлтгэн нийлүүлэгч, хамтран ажиллагч байгууллагуудын төслийг хүлээн авч сонгон шалгаруулалт хийх
5. Төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх
6. Ханган нийлүүлэлтийн сүлжээний үйл ажиллагааг сайжруулах
7. Зорих газрын менежментийг сайжруулах
8. Аймгийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалтыг сайжруулах
9. Говь-Алтай аймгийн тусгай хамгаалалтай газар нутгийн захиргаатай хамтран олон улсын байгууллагууд болон хөрөнгө оруулагч талуудтай нягт хамтын ажиллагааг урт хугацаанд бий болгох
10. Улс төр, олон улсын байгууллагын бодлого, хөтөлбөрт хамрагдах замаар аялал жуулчлалыг хөрш оронтой хөгжүүлэх
11. Хил залгаа аймгуудын аялал жуулчлалтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

Хөгжлийн зорилт 3.2 Аялал жуулчлалын бүс нутаг, бүтээн байгуулалтын үйл ажиллагааны хөгжил

Аймгийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх. Бодлогын бичиг баримтанд тусгасан төлөвлөлийн дагуу орон нутгийн удирдлага холбогдох албан тушаалтантаа зөвшилцөн шийдвэрлэх. Дараах ажлыг төлөвлөх

1. Ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг батлуулах
2. Дэд бүтцийн төлөвлөгөөг гаргаж, батлуулах
3. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг батлуулах
4. Газрыг нарийвчлан зохион байгуулалт хийх
5. Цогцолборыг бүтээн байгуулах
6. Улсын комисст хүлээлгэж өгөх
7. Тур операторуудтай хамтран ажиллах
8. Дамжин өнгөрөх аяллын бүтээгдэхүүний хөгжлийг дэмжих
9. Монгол улсын хэмжээнд үндэсний паркийн жишиг стандартыг тогтоосон тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлсэн парк болох

Хөгжлийн зорилт 3.3 Аялал жуулчлалын хөтөлбөрийн үйл ажиллагааны хөгжил

Гадаад, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйл ажиллагааг хөгжүүлэх замаар тогтвортой байдал, тогтвортой хөгжлийг бий болгоно.

1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх
2. Дотоодын жуулчдын ирэх урсгалыг тогтмол барих зорилгоор аяллын хөтөлбөр, зорих газрын бодлого, бүтээгдэхүүн төлөвлөлтийг бодлогын бичигт тусгасан эвентийг тогтмол зохион байгуулж хөгжүүлэх, шинэ аяллын хөтөлбөрийг нэмж хөгжүүлэлт хийх
3. Жуулчны баазын ойролцоо угсаатны зүйн болон бусад зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, үзэсгэлэн гаргаж үзүүлэх зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулах, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах, нутгийн ирэдийг татан оруулах

4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжиж, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг тухайн бүс нутгийн онцлогт тулгуурлан бий болгох, хөгжүүлэх
5. Соёлын өв, түүх, соёлын дурсгалт газарт суурилсан соёлын аялал жуулчлалын шинэ үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх
6. Хөдөө аж ахуйн уламжлалт өв соёл, газар нутагт суурилсан чацарганын агро-аялал жуулчлалыг хөгжүүлэх
7. Хил дамнасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, аяллын замналыг хөрш орнуудтай хамтран бий болгоход дэмжлэг үзүүлэх
8. Нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх
9. Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
10. Баруун бүсийн бусад аймгийн аялал жуулчлалын сүлжээтэй аймгийн аялал жуулчлалын сүлжээг холбон хамтын аялал жуулчлал (Community based tourism) жуулчлалыг хөгжүүлэх
11. Говь-Алтай аймгийн бренд байгалийн аяллыг түлхүү хөгжүүлэх(GG-6, Ирвэс, Аргаль, Янгир, фото зураг авах.....)
12. Сүшиг бишрэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
13. Авто, мото аялал жуулчлалыг хөгжүүлэх
14. Морин ба тэмээн аялал хөгжүүлэх
15. Өвлийн улиралд хурал цуглаан, өдөрлөг, тэмдэглэлт арга хэмжээг зохион байгуулах
16. Өвлийн спорт загасчлалыг хөгжүүлэх
17. Өвлийн нохой чарганы аяллыг хөгжүүлэх
18. Өвлийн байгалийн зураг авах аяллыг хөгжүүлэх
19. Аяллын бүтээгдэхүүний хувьд экстрим аялалуудыг бий болгож хэрэглэгчдийн зан төлөв, сонирхолд нийцүүлсэн аяллыг хөгжүүлэх
20. Богино хугацааны сонирхолтой аяллын хөтөлбөр хэрэгжүүлж, аяллын улиралыг нэмэгдүүлэх
21. Монгол улсын залуу насны бүтэц, аялагчдын сонирхол, адал явдалт аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэхийн зэрэгцээ дүрэм, журмыг нарийн баримтлан ажиллах
22. Адал явдалт, экстрим аялал сонирхогчдод зориулсан агуйн аялал, шөнийн од дурандах аялал зэрэг сонирхолтой, адал явдалт экстрим аяллуудыг дэд бүтэц муу хөгжсөн бүс нутгаар зохион байгуулах
23. Онлайн орчинд Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг сурталчилах, жуулчдын сэтгэл ханамж, хэрэглэгчийн судалгаа, байнгын хамтын ажиллагаатай байж цаг үеийн экстрим мөчүүдийг ашиглан аялал зохион байгуулах
24. Аяллын бүтээгдэхүүнийг жилийн турш байхаар зохион байгуулж ажиллах
25. БНХАУ-ын ӨМӨЗО ны жуулчин, хэрэглэгчийн сэтгэл ханамж, соёлд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлж ажиллах талаар иргэдийн нөхөрлөлүүдэд сургалт өгөх, хамтран ажиллах, стандартад нийцүүлж ажиллах

Хөгжлийн зорилт 3.4 Өрсөлдөх чадвар, маркетингийн хөгжил

Салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, тогтвортой хөгжлийг ханган Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр аялал жуулчлалын салбарын өсөлтийг 8 хувьд, аймагт жил бүр хүрэлцэн ирэх жуулчдын тоог жил бүр 20 хувиар өсгөх хэмжээнд хүргэх
2. Есөнбулаг сумд орчин үеийн зочид буудал, аялал жуулчлалын мэдээлийн төв цогцолбор шинээр барьж тохижуулан үйлчилгээний нэр төрлийг олшруулах
3. Говь-Алтай аймгийн аяллын маршрут, хөтөлбөрүүдийн дагуу аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах
4. Говь-Алтай аймгийн аяллын маршрут, хөтөлбөрүүдийн дагуу жуулчдын зорин очих дуртай газруудын төлөвлөлт, менежментийг сайжруулах
5. Говь-Алтай аймгийн гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааны ажлыг хөгжүүлэх
6. Говь-Алтай аймгийн аяллын маршрут хөтөлбөрүүдийн дагуу одоо ажиллаж байгаа жуулчдын бааз, амралт, сувиллын газруудыг тохижуулах, шинээр байгуулах
7. Музейн үзмэрүүдийг баяжуулах, аялал жуулчлалын маршрутын дагуух түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах
8. Олон улсын нөлөөллийн ажлыг зохион байгуулах замаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах
9. Олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх
10. Гадаад орнууд болон Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх
11. Говь-Алтай аймгийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад, дотоодод сурталчлах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах
12. Говь-Алтай аймгийн аяллын маршрут хөтөлбөрийг дотоодын аялал жуулчлалын байгууллагуудад танилцуулах
13. Тусгай хамгаалалттай болон соёлын өвийн бүс нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх
14. Говь-Алтай аймагт иргэдийн зүй зохистой аялах соёл, дадлыг төлөвшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах
15. Говь-Алтай аймгийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах замаар дотоодын жуулчдын захиалгын хөтөлбөрийг нэвтрүүлэх
16. Олон улсын жуулчдыг урьдчилсан захиалгаар авах боломжыг бий болгох
17. Аймгийн аялал жуулчлалын холбоог удирдлагаар ханган тогтмол ажиллуулах
18. Аймгийн бие даасан тур операторын байгууллагыг байгуулж ажилуулах
19. Аялал жуулчлалын Эвент хөтөлбөрийг тогтмолжуулах
20. Хоол үйлчилгээг стандартын шаардлага хангаж технологээр хийх
21. Жуулчны аюулгүй байдлын зөвлөмж өгөх, ханган ажиллах

Хөгжлийн зорилт 3.5 Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, чанар стандартын хөгжил

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг байгалийн унаган төрхийг хадгалах, орчны бохирдлыг багасгах, экологийн тэнцвэрт байдал, хүний эрүүл, аюулгүй орчинд аялах нөхцөл, орон нутгийн иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулна.

1. Олон улсын жуулчдыг нэгдсэн стандарт үйлчилгээ үзүүлэх замаар байгаль орчныг хамгаалах

2. Алсын хараа 2050, Тогтвортой хөгжлийн бодлого, Говь-Алтай аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасны дагуу аяллын хөтөлбөрүүдийг байнга сайжруулах, хөгжүүлэх, байгаль орчинг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэх
3. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааны дүрэм, журам, дэгийг сурталчлах, таниулах, журмыг заавал мөрдүүлж байгаль орчныг бохирдуулахгүй, сөрөг нөлөөллийг үүсгэхгүй байх, нөхөн сэргээх ажлыг тогтмол зохион байгуулах
4. Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаатай хамтран ажиллаж сумдын иргэдийн нөхөрлөлийн бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэлт хийж, орон нутгийн иргэдийг дэмжсэн, байгалийн нөөцийг хадгалж, хамгаалж, нөхөн сэргээсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх
5. аймагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бусад бодлого хөтөлбөрүүдийн дагуу иргэдийн аялах, жуулчлах зан төлөв, байгальд мөргүй аялах аяллын боловсролыг дэмжих, сурталчлах, таниулах үйл ажиллагааг зохион байгуулах
6. Хүн, ам зүй, нийгэм соёлын нөлөөллийн ажлыг зохион байгуулах замаар иргэд болон төрийн байгууллагуудын харилцан ойлголцлыг бий болгох хүрээнд төлөөллийн байгууллагуудыг дэмжин ажиллах замаар нэр хүнд, нөлөөг бий болгох
7. Аялал жуулчлалын гол чиглэлийн зам дагуу түр буудаллах болон боловсон ариун цэврийн байгууламж, хогийн цэгүүдийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шаардлагатай байршилд байгуулах
8. Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн байгууллагуудад ногоон гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж дэмжлэг үзүүлэх
9. Аялал жуулчлалын салбарт мөрдөж байгаа стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хяналтын механизмыг сайжруулсан байна
10. Байгаль, цаг уур, газар зүйн болон эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хяналтыг сайжруулах
11. Иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, боловсролыг нэмэгдүүлж, зөв зохистой аялах дадал, соёлыг нэвтрүүлэх
12. Цөлжилтийн бүсүүдийг шинэчлэн тогтоож, цөлжилтийн эсрэг зохион байгуулалттай арга хэмжээ авах
13. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэд, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудтай хамтран, тэдгээрийн санал, үйл ажиллагааг дэмжиж ажиллах
14. Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлэх;
15. Байгаль орчинд учруулсан хохирлыг эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан арилгах бодлогыг хэрэгжүүлэх
16. Газрын нөөцийн менежментийг сайжруулж, газар зохион байгуулалтын орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах
17. Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, тариалангийн талбайг тойруулж ойн зурвас тарьж ургуулах, таримал болон тэжээлийн, эмийн ургамал тариалах замаар ашиглах
18. Усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах, чиглэлээр олон нийтийг хамарсан сурталчилгааг зохион байгуулах
19. Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоог нэмэгдүүлэх
20. Байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлалт аргуудыг өргөн хэрэглэх
21. Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг эхний ээлжинд хамгаалах

22. Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах
23. Элсний нүүдлийг зогсоох, говийн ургамалжилтыг нөхөн сэргээхэд ашиглаж болох ургамлуудыг (заг, жигд, хайлаас, харгана, бүйлс, хотир, саваа мод гэх мэт) тодорхой үе шаттайгаар сонгон тариалах
24. Сул хөрсийг тогтоох, ургамалжуулах талаар гадаад орнуудын дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх
25. Цөлжилттэй тэмцэх ажилд нутгийн санаачлагатай иргэд болон ажилгүй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
26. Цөлжилттэй тэмцэх төслүүдийг боловсруулан гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудад хандан хэрэгжүүлэх арга хэмжээ авах
27. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа, тусгай хамгаалалттай газар нутгийн бүсийг камержуулах, камераар дүрэм, журмын хэрэгжилтийг хянах

Хөгжлийн зорилт 3.6 Нутгийн иргэдэд чиглэсэн аялал жуулчлалын хөгжил

Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлнэ.

1. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн нөлөөллийн ажлыг зохион байгуулах замаар тэдгээрийг төлөөлсөн байгууллагуудтай харилцан ойлголцох, хамтран асуудлыг шийдвэрлэхэд гишүүдийн санал санаачлага, нөөц боломж, чадавхыг ашиглах
2. Эдийн засгийн нөлөөллийн ажлыг зохион байгуулах замаар эрсдэлийг бууруулж, дарамтыг багасгах замаар байгууллагуудын орлогыг нэмэгдүүлэх бүтээмжийг нэмэгдүүлж татварын бүрдүүлэлтийг сайжруулна.
3. Аймгийн аяллын хөтөлбөрийн дагуух бүс нутаг, төв суурин газруудад мах, сүүний чиглэлийн үхэр, ямаа, махны чиглэлийн хонь болон гахай, тахиа, зөгий, туулайн аж ахуйг хөгжүүлэх
4. Аймгийн аяллын хөтөлбөрийн дагуух бүс нутаг, төв суурин газруудад жимс жимсгэнийн тариалалтыг өргөтгөх
5. Аймгийн аяллын хөтөлбөрийн дагуух бүс нутаг, төв суурин газруудад хүлэмжийн аж ахуй байгуулан хүнсний нарийн ногоо тариалах хөдөлгөөн өрнүүлэхийг дэмжих
6. Аймгийн аяллын хөтөлбөрийн дагуух бүс нутаг, төв суурин газруудад худалдаа, үйлчилгээний газруудыг хүчин чадал, үйлчилгээний нэр төрлөөр нь зохистой байршуулж дэмжиж ажиллах
7. Аймгийн аяллын хөтөлбөрийн дагуух бүс нутаг, төв суурин газруудад гэр, тавилга, оёмол, хатгамал зэрэг гар урлалыг дэмжиж ажиллах
8. Аймгийн аяллын хөтөлбөрийн дагуух бүс нутаг, төв суурин газруудад морь, тэмээ, сарлаг гэх мэт ердийн хөсгийг бэлтгэн нийлүүлэлтийг дэмжиж ажиллах
9. Орон нутгийн иргэдийн нөхөрлөлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөхөрлөлийн тоог нэмэх
10. Орон нутгийн иргэдийн нөхөрлөлүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах
11. Говь-Алтай аймгийн хөгжлийн бодлогийн тэргүүлэх чиглэлийг аялал жуулчлалаар дэмжих
12. Иргэдийн нөхөрлөлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, стандартын шаардлагад нийцүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт хөгжил, сав баглаа боодол, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж ажиллах

Хөгжлийн зорилт 3.7 Хүний нөөцийн хөгжил

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1. Аялал жуулчлалын хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгож, бүтээмжийг өсгөх
2. Ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх,
3. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжих
4. Шинээр сургууль төгсөж ирсэн залуу боловсон хүчнүүдийг сум орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангах
5. Аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлж
6. Хүний нөөцийн бэлтгэл үйл ажиллагаанд шинэ технологи нэвтрүүлж хурдан хугацаанд бүрдүүлэх, сургах үйл ажиллагааг хэрэгжүүлэх
7. Говь-Алтай аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл бусад бодлогын баримт бичгийн дагуу аялал жуулчлалын хүний нөөцийг бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулж, тасралтгүй бэлтгэх
8. Хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах
9. Хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;
10. Аялал жуулчлалын салбарын хөтөч-тайлбарлагч болон зочлох үйлчилгээний сургагч багш, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг хамруулах.
11. Аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг нь төрөлжсөн сургалтад хамруулах, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах
12. Аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааны хэрэгцээт мах, сүү, цагаан идээ, жимс жимсгэнэ, хүнсний ногоо, гар урлалын бүтээгдэхүүн зэргийг бэлтгэн нийлүүлэх, стандарт хангуулах, хамтран ажиллах нөхөрлөлүүдэд чадамжид суурилсан сургалт хийх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллах
13. Жуулчдад зориулан англи, герман, хятад, япон, орос, солонгос хэлтэй аяллын үйлчилгээний ажилтнуудыг бэлтгэх
14. Аяллын бүс нутагт ажиллах мэргэжилтэнүүдийг бэлдэх
15. АЗДТГазар БОАЖБТГазарт ажиллах ажилтыг дахин сургах чадавхижуулах

Хөгжлийн зорилт 3.8 Дэд бүтэц, барилга, техник технологи, материаллаг баазын хөгжил

Говь-Алтай аймгийн аяллын бүс нутаг, төв суурин газруудад зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, зорилго зорилтуудыг хэрэгжүүлэх таатай орчин бүрдүүлнэ.

1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын мэдээллийн сүлжээг хөгжүүлж, аялал жуулчлалын статистик мэдээллийг олон улсын аргачлалын дагуу боловсруулж мэдээллийн нэгдсэн санг бий болгох

2. Аялал жуулчлалын салбарын судалгаа, мэдээллийн системийг хөгжүүлэх, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:
3. Цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж вэб, аппликэйшн зэрэг цахим технологид тулгуурлан, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
4. Байршуулах, тээвэрлэх, хооллох, үзэх, сонирхох, худалдан авах чиглэлээр цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх
5. Интернет худалдаа, цахим үйлчилгээг аймгийн иргэдийн өдөр тутмын энгийн хэрэглээ болгох
6. Хөтөлбөрт хамрагдсан хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах
7. Электрон арилжаа, электрон гарын үсэг зэрэг үйлчилгээг нэвтрүүлэх
8. Сэргээгдэх эрчим хүч ашиглахыг дэмжиж, нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрийн дан болон хоршсон хэрэглээг өргөтгөх
9. Нарны илчээр ус, агаар халаах технологи, тоног төхөөрөмжийг өргөн ашиглах
10. Байршуулах хэрэгсэл буюу зочид буудал, жуулчны баазуудыг байгуулах
11. Үйлчилгээний цэгүүдийг байгуулж, хариуцах байгууллагуудыг тодорхой болгох
12. Тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудтай хамтран ажиллах
13. Аяллын тогтоосон маршрутын дагуух авто замыг засварлаж, тэмдэгжүүлэх
14. Жуулчдын ая тухтай, аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх, аялал жуулчлалын гол чиглэлд зам дагуу түр буудаллах цэгүүд, боловсон ариун цэврийн байгууламжийг шат дараатай барьж байгуулах
15. Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаатай хамтран ажиллаж дэд бүтцийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах
16. Аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээнд олон улсуудын туршлага, технологи нэвтрүүлэх замаар жуулчлалын хугацааг уртасгах
17. БНХАУ-ын ӨМӨЗО-ны жуулчдийн тооны өсөлттэй холбоотойгоор хамгийн ойр байрлалтай Бургастайн хилийн боомтыг боломжит хэмжээнд ашиглах, хамтын ажиллагааг өргөжүүлэх


Хөгжлийн зорилт 3.9 Санхүү, хөрөнгө оруулалтын хөгжил

Хөрөнгө оруулалтыг татах замаар амйгийн аялал жуулчлалын бүтээн байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

1. Аялал жуулчлалын цогцолбор, бааз байгуулах төслүүдийг боловсруулж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад санал болгох
2. Улсын болон орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтыг тусгах
3. Байгууллага, иргэдийн хандив, тусламжийн аян өрнүүлэх
4. Олон улсын байгууллагын тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт татвар

1.1.8. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУДЫН ЛОГИК ХОЛБОО

Зураг 8. Эрхэм зорилго, зорилтуудын логик холбоо



байдлыг дэмжих						ажиллагааны хөгжил	
	Хөгжлийн зорилт 2.4	Нутгийн өмнөд бүсийг хөгжүүлэх	13 ажил	Хөгж- лийн зорилт 3.4	Өрсөлдөх чадвар, маркетингийн хөгжил	4 ажил	
	Хөгжлийн зорилт 2.5	Аймгийн төвийн үйлчилгээний байгууллагыг хөгжүүлэх	6 ажил	Хөгж- лийн зорилт 3.5	Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, чанар стандартын хөгжил	7 ажил	
	Хөгжлийн зорилт 2.6	Одоо байгаа аялал жуулчлалын байгууллагыг өргөтгөх, хөгжүүлэх	10 ажил	Хөгж- лийн зорилт 3.6	Нутгийн иргэдэд чиглэсэн аялал жуулчлалын хөгжил	6 ажил	
				Хөгж- лийн зорилт 3.7	Хүний нөөцийн хөгжил	14 ажил	
				Хөгж- лийн зорилт 3.8	Дэд бүтэц, барилга, техник технологи, материаллаг баазын хөгжил	10 ажил	
			Хөгж- лийн зорилт 3.9	Санхүү, хөрөнгө оруулалтын хөгжил			
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ & 50 МЕНЕЖМЕНТ & ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО							


1.1.9. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

1.1.9.1. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны загварчлал

Говь-Алтай аймгийн ЗДТГ нь ТХГНЗ, Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо, орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллаж, бүтээн байгуулалтад чиглэсэн өргөн хүрээтэй стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр аялал жуулчлалын салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх болно. Стратегийн хэрэгжилтийн үр дүнд орон нутгийн иргэдийн ажлын байр нэмэгдэж, бүтээмж өсөж, үр ашигтай ажиллах нөхцөл бүрдэнэ. **“Говь-Алтай аймгийн аялал жуулчлал нь байгалийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалыг хүрээлэн буй орчны менежмент, стандартад нийцүүлэн бодлогын хүрээнд хөгжүүлнэ”** зорилгыг хангахын тулд дараах загвараар үйл ажиллагаагаа явуулах нь зүйтэй.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ БА Д.СИНКИЙН ЗАГВАР

Зураг 9. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны загварчлал



1.1.9.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх иж бүрдэл

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бүтэц, зохион байгуулалтыг чиг үүргийн хүрээнд оновчтой төлөвлөх нь энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх угтвар нөхцөл болох юм. Төрийн байгууллага болон хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. Дунд ба богино хугацааны бизнесийн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, биелэлтийг ханган ажиллана. Стратегийн удирдлага нь дараах 2 иж бүрдэлтэй байна. Үүнд:


1. Стратегийн төлөвлөгөө буюу (5-15 жил)
2. Хөгжлийн хөтөлбөрүүд (3-5 жил)
3. Үйл ажиллагааны төлөвлөгөө (1 жил)

Дээрх урт, дунд, богино хугацааны төлөвлөлтийг төслийн удирдлагын арга зүйгээр хэрэгжүүлэх бодлогыг баримталж ажиллах бөгөөд нэгж, хэлтэс, хувь хүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг богино хугацааны төлөвлөлтөд нарийвчлан тусгана.


Говь-Алтай аймгийн Аялал жуулчлалын стратеги




Зураг 10. Мэргэжлийн сургалт, судалгаа



Зураг 11. Төрийн зохицуулалт, дэмжлэг




Зураг 12. Орон нутгийн оролцоо



Зураг 13. Үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд


1.1.9.3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт

Зураг 14. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт




1.1.9.4. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Зураг 15. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын схем



1.1.9.5. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын маршрутын дагуух нутгийн иргэдийн нөхөрлөлийг хөгжүүлэх загвар, төлөвлөгөө

Зураг 16. Нутгийн иргэдийн нөхөрлөлийг хөгжүүлэх загвар



1.1.9.6. Говь-Алтай аймгийн нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хэрэгжүүлэх стратегийн замын зураг

Хүснэгт 7. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын стратегийн замын зураг

Хэрэглэгчийн төлөв байдал					
<i>Монгол улсын өрсөлдөх чадварын өсөлт</i>					
<i>Аялал жуулчлалын салбарын хөгжил</i>					
<i>Говь-Алтай аймгийн аяллын бүс нутгийн аялал жуулчлал хөгжих</i>			<i>Говь-Алтай аймгийн Иргэдийн орлого нэмэгдэх</i>		
<i>Нутгийн Иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал</i>			<i>Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага</i>		
Үйл ажиллагааны төлөв байдал					
<i>Иргэдийн санаачлагатай аялал жуулчлал</i>			<i>Аялал жуулчлалын нийлүүлэгч хамтрагч байгууллагууд</i>		
<i>Хамтын нөхөрлөл</i>	<i>Иргэдийн оролцоо</i>		<i>Гадаадаас жуулчин хүлээн авч нийлүүлэх</i>	<i>Дотоодоос жуулчин хүлээн авч нийлүүлэх</i>	
Санхүү, хөрөнгө оруулалтын төлөв байдал					
<i>Бүс нутагт жуулчинд үйлчилгээ үзүүлэх байр, гэр сууц</i>	<i>Хүрэлцээтэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт</i>		<i>Үндэсний сүлжээ бүхий мэдээлэл технологийн хөрөнгө оруулалт</i>	<i>Мэдлэгийн менежментийн зардал</i>	
Удирдлага зохион байгуулалт хүний нөөцийн төлөв байдал					
<i>Сайн засаглал</i>	<i>Менежментийн хөгжил</i>	<i>Хүний нөөцийн оновчтой бодлого</i>	<i>Шударга гүйцэтгэлийн тогтолцоо</i>	<i>Карьер хөгжил</i>	<i>Нийгмийн хариуцлага</i>

1.2. ГОВЬ АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН МЕНЕЖМЕНТ

Энэхүү баримт бичиг нь Говь Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөө юм. Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөөний зорилт нь баримт бичгийн захиалагч болох ЗДТГ-аас тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвлөмж хэлбэрээр бичигдсэн. Энэхүү төлөвлөгөө нь Говь Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сонирхдог эсвэл түүнд нөлөөлж болох хүмүүс болон оролцогч бүлгүүдтэй харилцахаар зөвлөх багийн зүгээс төлөвлөж байгаа арга замыг тодруулж өгөх юм. Тус төлөвлөгөөний зорилго нь орон нутгийн төрийн болон үйлчилгээний байгууллагууд, орон нутгийн иргэдийн бүлэг, бусад сонирхсон оролцогч талуудтай харилцаа холбоог бий болгох явдал билээ.

Олон улсад аливаа төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь орон нутгийн бүлэг, иргэдийн эрх, төслийн хэрэгжилтийн явцад оролцогч талуудын үүрэг оролцоо байнга шаардлагатай байдаг гэсэн үндсэн зарчмууд дээр үндэслэгддэг. Стратеги төлөвлөгөөний үр ашигтай үүрэг оролцооны гол үйл ажиллагааны зарчмуудыг доор товч хураангуйлав:


- Нутгийн иргэд, төр захиргааны байгууллагуудтай санал асуулга, зөвлөгөөн, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах
- Орон нутгийн уламжлал, нутгийн өвөрмөц зан заншлыг хүндэтгэх
- Оролцогч талуудын хэрэгцээнд нийцсэн, ойлгогдохуйц ач холбогдол ихтэй мэдээллийг бэлтгэн өгөх
- Стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөл болон хөтөлбөрийн загварт хамтрах, санал хүсэлтийг хүлээн авах
- Бизнесийн оролцогч талуудад харилцан үр ашигтай байх
- Хил орчмын оролцогч талуудын боломжид түшиглэх зэрэг болно.

Говь алтай аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд оролцогч талуудыг дараах бүлгүүдийн хүрээнд тодорхойлсон:

- Олон улсын байгууллагууд
- Төрийн(төрийн ба бүсийн хэмжээний эрх бүхий байгууллагууд)
- Засгийн газар (аймаг, сум, баг)
- Засгийн газрын бус зөвлөх
- Үйлчилгээ/ханган нийлүүлэгчид
- Үйлчлүүлэгчид
- Хүрээлэнгүүд (их сургууль, эрдэм шижилгээний байгууллагууд)
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- Улс төрийн намууд
- Дотоод оролцогч талууд (ажилтнууд)
- Олон нийтийн бүлгүүд- аялал жуулчлал, амралтын газрууд, эмнэлэг, орон нутгийн сургууль, үндэсний өвийн байгууллагууд
- Аялал жуулчлалын компаниуд
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Оролцогч талууд нь дараах түвшинд Говь Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцоно.

Зураг 17. Говь Алтай аймгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх оролцооны түвшин



Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршдог. Дээрхи зорилгын хүрээнд хамтран ажиллах бодлогын дэмжлэг авч ажиллах боломжтой.

Зам тээврийн хөгжлийн яам

Зам тээврийн хөгжлийн яам нь Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логикийн сүлжээг байгуулах зорилготой. Тус яам нь дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналтын механизмыг бүрдүүлэх замаар авто замын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн авто замын санг бие даасан үйл ажиллагаанд шилжүүлнэ;
2. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ;
3. Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, өрсөлдөөнийг бий болгож, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна гэж заасан нь Говь Алтай аймагт зорилтот аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг олгож байна.

Эрчим хүчний яам

Эрчим хүчний яамны эрхэм зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад оршино. Яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажилладаг. Үүнд:

1. эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах;
2. эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах;
3. эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах;
4. сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
5. салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
6. эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс)-ни салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг болно. Дээрхи зорилго зорилтуудыг Говь Алтай аймагт уялдуулж ажиллах нь зүйтэй.

Боловсрол, шинжлэх ухааны яам

Боловсрол, шинжлэх ухааны яам нь Боловсролын салбарын тогтолцоо, үйлчилгээний чанар, нийцийг сайжруулсан байх зорилтын хүрээнд Бүх түвшний сургалтын хөтөлбөрийнагуулгыг эх оронч сэтгэлгээ, монгол уламжлал соёлыг дээдэлсэн, хүмүүжил, төлөвшил, хувь хүний болон шинжлэх ухааны эрэл хайгуул хийх ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр залгамж холбоотойгоор шинэчилж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлсэн байна. Энэ нь нэг талаар Говь Алтай аймгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх, нөгөө талаас баруун хилийн өнгөрсөн түүхт үйл явдлуудыг боловсролын салбарын агуулгад тусгах замаар ирээдүйн аялагчдыг бэлтгэх боломж олгох юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино. Тус яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг, түүний хүрээнд гол зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх;
2. Салбарын хууль тогтоомж, стратегийн дунд, богино хугацааны бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах;
3. Хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомж, стратегийн дунд, богино хугацааны бодлогыг төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримт бичгийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;
4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг төлөвлөх, удирдлага, зохицуулалтаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, төсвийг зарцуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, тооцоо гаргах, шаардлагатай мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх.
5. Хүн ам, түүний бүлгүүдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

6. Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах;
8. Жендэрийн үндэсний хороонд зөвлөгөө, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, жендэрийн талаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж зохицуулах.
9. Салбарын гадаад хамтын ажиллагааг эрхэлж, гадаад орон, олон улсын төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулах, дэмжлэг үзүүлэх.
10. Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
11. Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, бодлогын удирдамж, мэргэжил арга зүйгээр хангах;
12. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийг ажлын байраар хангах, ядуурлыг бууруулах, тогтвортой ажлын байр бий болгохыг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
13. Ажиллах хүч гадаадаас авах, гаргах бодлогыг зохицуулах, гадаадаас буцаж ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлыг зохицуулах;
14. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах.
15. Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийн явцад дотоодын хяналт шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх замаар оновчтой бодлого, стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
16. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын мэдээллийн технологийг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг стратеги төлөвлөгөөтэй уялдуулах нь зүйтэй.

Сангийн яам

Яамны алсын хараа нь Монгол Улсын санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийнхээ амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэн Мянганы хөгжлийн зорилт, үзүүлэлтийг биелүүлж, цаашдаа хөгжингүй орнуудын дундаж жишигт хүргэх явдал мөн. Сангийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангахад оршино. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь:

1. Санхүү, төсвийн удирдлагын чадавхийг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
2. Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;

3. Гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсронгуй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
4. Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
5. Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах;
6. Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх;
7. Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын Танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
8. Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэхтэй холбоотой чиглэлүүдээр хамтран ажиллаж болно.

Гадаад харилцааны яам

ГХЯ-ны Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх, найрсгаар хандан талархагчдын хүрээг өргөтгөх, иргэд хоорондын харилцаа, харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэхэд оршино. Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

1. Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадад сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх, гадаад сурталчилгааны бүтэц бий болгохыг дэмжих;
2. монголын түүх, байгаль, зан заншил, ахуй амьдрал, хөгжил дэвшлийг харуулсан сурталчилгааны ном, товхимол, нэвтрүүлэг, кино, цомог зэргийг бэлтгэн бусад улс түмэнд түгээх, сурталчлах;
3. хоёр талын харилцааны хүрээнд гадаадад Монгол Улсыг сурталчилсан өдрүүд зохион байгуулах, үзэсгэлэн, яармаг гаргах, кино, урлагийн тоглолт үзүүлэх, уулзалт, ярилцлага зохион байгуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
4. гадаад сурталчилгааг сайжруулахын тулд бусад улс, олон улсын байгууллагын нэр хүндтэй хүмүүс, улс төр, нийгэм, соёлын зүтгэлтэн, сэтгүүлч болон хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;
5. Монгол Улсын талаар гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээ, мэдээллийг судалж байх;
6. Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны талаар олон нийт, хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг бодит мэдээллээр хангах, тэдний хүч бололцоог бусад улстай харилцаа, хамтын ажиллагаа хэвийн хөгжүүлэхэд чиглүүлэх; гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг хэрэгжүүлэхэд ардын болон соёлын дипломатын арга хэлбэрийг хэрэглэх;
7. энх тайван, найрамдлын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих.

Тус яамны гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газар нь дараах чиг үүрэгтэй ажилладаг. Үүнд:

1. Монгол Улсын гадаад бодлогыг олон улсын тавцанд үндэсний соёл, урлаг, өв уламжлал, түүхэн үнэт зүйлээр дамжуулан хэрэгжүүлэх олон нийтийн дипломат харилцаа болон соёлын бодлого, стратегийг төлөвлөх, нэгдмэл байдлаар зохион байгуулах;
2. Соёлын гадаад харилцаагаар дамжуулан Монгол Улсын гадаад сурталчилгааг эрчимжүүлэх бодлогыг нэгдсэн зохицуулалтаар хангах;
3. Дэлхийд нэр хүндтэй соёлын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар соёлын гадаад харилцааг идэвхижүүлэх, үр нөлөөг нь нэмэгдүүлэх бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;
4. Хилийн чанад дахь монгол сургууль, монголчуудын үүсгэл санаачлагын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, монгол хэл, соёл, ёс заншлыг сурталчлан таниулах, сургах үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх;
5. Гадаадын хэвлэл мэдээлээр дамжуулан Монгол Улсыг дэлхий нийтэд сурталчлан таниулах бодлого, агуулгыг төлөвлөх, нэгдсэн хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
6. Монгол Улсын гадаад бодлого, байр суурь, дипломат харилцаа, хоёр болон олон талт хамтын ажиллагаа, нийгэм эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалт, түүх, соёл, урлагийг хилийн чанадад сурталчлах;
7. “Дэлхийн Монголчууд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах ажлыг зохион байгуулах;
8. “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах ажлыг зохион байгуулах;
9. Гадаад сурталчилгааг хөгжүүлэх, зохицуулах хууль тогтоомжийн төсөл боловсруулах, олон улсын гэрээ байгуулах санал боловсруулах чиглэлийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;
10. Хилийн чанадад буй Монголын түүх, соёл, урлагийн өв, үнэт зүйлсийг судлах, бүртгэх, хамгаалах, сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг төлөвлөх, нэгдсэн хэрэгжилтийг зохион байгуулах;
11. Монгол судлалыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр санал боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;
12. Гадаадын улс орнууд дахь монгол судлалын төв, монгол судлаачдын үйл ажиллагааг дэмжиж ажиллах, мэдээ, мэдээлэл, сургалтын материалаар хангаж ажиллах;
13. Түүх, соёл, урлаг, спорт, киноны салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаагаар дамжуулан Монгол Улсыг сурталчлах бодлогыг хэрэгжүүлэх;
14. Монгол Улсын Соёлын элчийг томилох, үндсэн чиглэлээр хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах;
15. Монгол Улсын Соёлын элчийг гадаад сурталчилгааны үйл ажиллагаанд татан оролцуулах, хамтран ажиллах;
16. Гадаадын улс орнуудаас Монгол Улсад зохион байгуулах соёлын арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажиллах;
17. Хилийн чанадад хэрэгжүүлж буй гадаад сурталчилгааны үйл ажиллагаагаар дамжуулан эдийн засаг, аялал жуулчлалын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох газруудтай хамтран ажиллах, бодлого боловсруулах;
18. Хилийн чанад дахь монголчуудын холбоод, монгол үндэстнүүдтэй хамтран үндэсний соёлоо сурталчлах, Монгол Улсын тухай эерэг хандлага, ойлголт, итгэлийг нэмэгдүүлэх, харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал нэмэгдэхэд дэмжлэг үзүүлэх;

19. Монголын тухай гадаадын сурвалжлага, нэвтрүүлэг хийх, ном зохиол туурвих, орчуулах, олон улсын хурал, үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулах, соёлын өдрийг харилцан тэмдэглэх, түүхэн ойд зориулсан арга хэмжээг зохиох, хөшөө дурсгал босгох зэрэг үйл ажиллагааг нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалтаар хангах;
20. Гадаадын улс орнуудын хэвлэл, мэдээллийн салбарын ажилтнуудыг Монгол Улсад айлчлуулах зочин хөтөлбөр хэрэгжүүлэх замаар Монгол Улсыг гадаадын олон нийтэд сурталчлан таниулах бодлогыг хэрэгжүүлэх
21. Монгол Улсад байнгын болон түр ажиллах гадаадын сэтгүүлч, сурвалжлагч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын бүртгэлийг хийх, тэдэнтэй харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх;

Хүнс Хөдөө Аж ахуйн яам

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны алсын хараа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, дотоод худалдаа, үйлчилгээний салбарыг олон улсын зах зээлд өрсөлдөхүйц хөгжлийн шинэ шатанд гаргаж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ. Тус яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Тус яамны тэргүүлэх чиглэл нь:

1. Төрийн захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх;
2. Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, дотоод худалдааны салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төсөл, урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах, бодлогын үр нөлөөний үнэлгээ хийж удирдамжаар хангах, хоёр талын болон олон талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, салбарын статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах;
3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бодлого болон малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэх, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
4. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого болон хөрс, ургамал хамгаалал, үр сортын шинэчлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
5. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
6. Хүнс, хоол үйлдвэрлэл, дотоод худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
7. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах;

8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааг зохион байгуулах
9. Хөнгөн үйлдвэрийн салбарт экспортын баримжаатай болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, үнэ цэнийн болон кластерын сүлжээг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах
10. Хөнгөн үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах
11. Хүнс, хоол үйлдвэрлэл, дотоод худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
12. Хүнсний үйлдвэрлэлд үнэ цэнийн болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох болон экспортлох боломжийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, согтууруулах ундаа, тамхины үйлдвэрлэл, импортын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах
13. Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт-баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санг ажиллуулах;
14. Дотоод худалдааны оновчтой тогтолцоог бий болгох, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үйлдвэрийг худалдаагаар дэмжих бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллах боломжтой. ЖДҮХС-ийн зээл тусламж, Экспортыг дэмжих төслүүдийг аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбох нь зүйтэй.

Төрийн Банк

Төрийн Банк нь олон улсын стандартад нийцсэн орчин үеийн банк, санхүүгийн цогц үйлчилгээг орон даяар саадгүй хүргэх, бүх талын хамтын ажиллагааг дээдлэх, харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн олон талт хэрэгцээг хангахад чиглэн, Монгол орон даяар 500 гаруй салбар нэгж, 348 АТМ, 3400 гаруй картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Өнгөрсөн оны санхүүгийн үзүүлэлтээр Төрийн Банк нь 3.2 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад үзүүлэлтээрээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байна. Төрийн Банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, Монгол Улсын банкны салбарын ТОП 3 банкны нэгээр дахин шалгарч, амжилтаа баталгаажуулсан. Төрийн банк ХХК нь Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу дараах үйл ажиллагааг эрхэлдэг. Үүнд:

1. Мөнгөн хадгаламж,
2. Зээл,
3. Төлбөр тооцоо,
4. Гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах,
5. Үнэт зүйл хадгалах,
6. Гадаад төлбөр тооцоо хийх,
7. Үнэт цаас гаргах, худалдах, худалдах авах,

8. Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх,
9. Даатгалын зуучлалын үйлчилгээ,
10. Эх үүсвэртэй баталгаа, батлан даалт гаргах,
11. Эх үүсвэргүй баталгаа, батлан даалт гаргах зэрэг чиглэлээр жуулчид, иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж болно.

Төрийн бус байгууллагууд

Говь Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх оролцогч талуудын хувьд ТББ-д чухал үүрэг ач холбогдолтой. Үүнд:

1. Монголын аялал жуулчлалын холбоо (the mongolian tourism association) Тэргүүн: Д.Гантөмөр, Байгуулагдсан он: 1992 он, Утас: 700078206
2. Монголын зочид буудлуудын холбоо (mongolian hotels association) Тэргүүн: С.Мөнхбат, Байгуулагдсан он: 1997 он, Утас: 70112770, Гүйцэтгэх захирал М.Батцэнгэл 99235150,
3. Монголын жуулчны баазуудын холбоо (mongolian ger camp association) Тэргүүн: Н.Цэндсүрэн Байгуулагдсан он: 1995 он, Утас: 99135150
4. Монголын үндэсний аялал жуулчлалын байгууллага (mongolian national tourism Organization) Гүйцэтгэх захирал: Б.Эрдэнэчимэг, Байгуулагдсан он: 2007 он, Утас: 99990549
5. Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв Тэргүүн: Ч.Буянбадрах, Байгуулагдсан он: 2013 он, Утас: 91913166
6. Монголын аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг Удирдах зөвлөлийн дарга: Б.Барсболд, Утас: 96605528
7. Монголын хөтөч тайлбарлагчдын холбоо (mongolian tour guides association) Тэргүүн: Д.Бадрах, Байгуулагдсан он: 2003 он, Утас: 99104225
8. Монголын экотуризмын нийгэмлэг (Mongolian Ecotourism Society) Тэргүүн: О.Бум-Ялагч, Байгуулагдсан он: 1996 он, Утас: 318099, 99173719
9. Монголын уулын хөтөчдийн холбоо (Mongolian Mountain Guides association) Тэргүүн: Г.Өсөхбаяр, Байгуулагдсан он: 2005 он, Утас: 99115366, 99110243
www.mountainguide.mn

1.2.3. ГОВЬ АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗАГВАР


Говь Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх оролцогч талуудын загварыг дараах байдлаар тодорхойлов.



Ц.Өнөржаргал 2021

Зураг 18. Говь Алтай аймгийн аялал жуулчлалын оролцогч талууд болон үйл ажиллагааны харилцан хамаарал

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь өвөрмөц хийгээд өргөн хэмжээнд зохион байгуулагддаг. Энэ нь төр, бизнесийн болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааны түвшинд хэрэгждэг болохыг зурагт харуулав.




Зураг 19. Аялал жуулчлалын оролцогч талуудын уялдаа холбоо, хамаарал

Говь-Алтай аймгийн ЗДТГ нь ТХГНЗ, Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо, орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллаж, бүтээн байгуулалтад чиглэсэн өргөн хүрээтэй стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр аялал жуулчлалын салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой юм. Стратегийн хэрэгжилтийн үр дүнд орон нутгийн иргэдийн ажлын байр нэмэгдэж, бүтээмж өсөж, үр ашигтай ажиллах нөхцөл бүрдэнэ. “Говь-Алтай аймгийн аялал жуулчлал нь байгалийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалыг хүрээлэн буй орчны менежмент, стандартад нийцүүлэн бодлогын хүрээнд хөгжүүлнэ” зорилгыг хангахын тулд дараах загвараар үйл ажиллагаагаа явуулах нь зүйтэй.

Дээр дурдсан хүчин зүйлүүдийн хүрээнд дараах оролцогч талуудын харилцаа холбоог тодорхойлсон болно. Эдгээр нь:

Зураг 20. Говь Алтай аймгийн оролцоонд тулгуурласан аялал жуулчлалын загварчлал



Говь Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх оролцогч талуудын оролцоо нь дээр зурагт дурдсанаар хэрэгжих нь зүйтэй.

1.2.4. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС НУТГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ

Аялал жуулчлалын бизнесийн байгууллага нь утаагүй үйлдвэрлэл болохын хувьд дэлхийн эдийн засагт доривтой хувь нэмэр оруулсаар байгаа салбар юм. Хөгжсөн орнууд аялал жуулчлалын бизнесийн салбарыг дэмжин хөгжүүлж байна. Бизнесийн байгууллагууд нь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн жам ёсоор дэлхийн улс орнуудын хөгжлийн чиг хандлага болсон “Хүн төвтэй” удирдлагын стратегийг баримтлан өөрийн өнгө төрхийг олж хөгжиж байна. Монгол улсын хэмжээнд аялал жуулчлалын салбарын хүний нөөц 1993 оноос бие даасан чиг хандлагатайгаар хөгжиж ирсэн.

Хүний нөөцийн бодлогын зорилго нь аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн зорилго, стратеги төлөвлөлтийн хүрээнд чадварлаг хүний нөөцийн бааз суурийг бүрдүүлэх, бэхжүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагааны чиглэл, баримтлах зарчмыг оновчтой тодорхойлж, тогтооход оршино.

Хүний нөөцийн бодлого нь бүс нутаг дахь ажлын байр, албан тушаалд ажилтнуудыг сонгон шалгаруулах, тодорхой албан тушаалд ажиллуулах, хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнд тохирсон цалин хөлс урамшуулал бий болгох, хариуцлага тооцох, дахин сургах, хөгжүүлэх, тэдний нийгмийн асуудлыг хэсэгчлэн болон хөнгөлөлттэй байдлаар шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Баримтлах зарчим:

Бүс нутаг нь хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг удирдлага болгож мөрдөнө. Үүнд:

- Бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх үндсэн зорилго, стратеги төлөвлөлтөнд чиглэсэн, тэдгээрт нийцсэн байх
- Хүний нөөцтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг шударга, нээлттэй ил тод явуулах
- Хүний нөөцийн холбоотой асуудлаар аялал жуулчлалын байгууллагын удирдлага, ажиллагсдад тэгш байдлаар үйлчлэх
- Хүний нөөцийн үйл ажиллагааг олон талаас нь зөв бодитой үнэлдэг байх
- Аялал жуулчлалын байгууллагын хүний нөөцийг халамжлах, тэдгээрийн сэтгэл ханамжинд тулгуурласан байх
- Зохион байгуулалттайгаар сурч хөгжих нөхцөл, боломжоор хангасан байх

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт зохион байгуулах шаардлагатай хүний нөөцийн сургалтын чиглэл

Хүснэгт 8. Сургалтын чиглэл, хугацаа, үр дүн

№	СУРГАЛТЫН ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	ТУСГАЙЛСАН СУРГАЛТ	СУРГАЛТЫН ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН
Байгууллагын ажилтануудын дахин сургалтын чиглэл				
1	Мэргэжлийн мэдлэг, чадварын сургалт	Аяллын хөтөч тайлбарлагч	14 хоног	Говь-Алтай аймагт зохион байгуулах, байгууллагын ажилтныг хамруулах, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, Говь-Алтай аймгийн боловсролын газар захиалга хүргүүлэх. Боловсролын газар аялал жуулчлал хариуцсан хэлтэстэй хамтран зохион байгуулах
		Зөөгч бармен	14 хоног	
		Гэрийн үйлчилэгч	7 хоног	
		Тусгай аяллын хөтөч	14 хоног	
		Жижиг дунд үйлдвэрлэлийн сургалт	7 хоног	
		Аяллын тогооч	14 хоног	
		Аяллын жолооч	7 хоног	
2	Бие, сэтгэл зүйн чадвар	Байгууллагын ажилтны харилцааны сургалт	7 хоног	Говь-Алтай аймагт зохион байгуулах, байгууллагын ажилтныг хамруулах, үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд Говь-Алтай аймгийн боловсролын газар захиалга хүргүүлэх. Боловсролын газар аялал жуулчлал хариуцсан хэлтэстэй хамтран зохион байгуулах
		Аяллын хөтөч жуулчны сэтгэл зүйг ойлгон тайлбар хийх арга зүй	7 хоног	
		Хувь хүний соёл	7 хоног	
		Бизнесийн харилцаа	7 хоног	
		Үйлчилгээний ажилтны соёл	7 хоног	
Мэргэжлийн боловсролын сургалт				
3	Дээд боловсролын	Аялал жуулчлалын менежмент	4 жил	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр суралцах, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд Говь-Алтай боловсролын газар захиалга хүргүүлэх. Боловсролын газар аялал жуулчлал хариуцсан хэлтэстэй хамтран зохион байгуулах. ЕБС-ийн 12 анги төгсөгчдөд мэргэжлийн чиг баримжаа өгөх
		Зочлох үйлчилгээний менежер	4 жил	
		Тур операторын бизнес төлөвлөлт	4 жил	
		Аялал жуулчлалын менежер, орчуулагч	4 жил	
		Хоол үйлдвэрлэлийн технологи	4 жил	
		Гадаад хэлний орчуулагч	4 жил	
		Байгаль орчны мэргэжилтэн	4 жил	
Тусгай мэргэжлийн сургалт				
4	Тусгай аяллын хөтөч	Шувуу судлалын аяллын хөтөч	20 багц цаг	

	тайлбарлагчийн сургалт	Морин, тэмээн аяллын хөтөч	20 багц цаг	Говь-Алтай аймагт нутгийн иргэдийг сургах, гадаад хэлний хөтөч хийх чадвартай хүмүүсийг хамруулах
		Ховор амьтны зураг авах аяллын хөтөч	30 багц цаг	
		Ховор амьтан, ургамал судлах аяллын хөтөч	30 багц цаг	
		Байгалийн фото зураг авах аяллын хөтөч	30 багц цаг	
		Нүүдэлчдийн соёлын аяллын хөтөч	20 багц цаг	
		Тусгай хамгаалттай газрын аяллын хөтөч	15 багц цаг	
Гадаад хэлний сургалт				
5	Аялал жуулчлалын гадаад хэл	Англи, Япон, Франц, Солонгос, Герман, Итали, Орос, Хятад гэх мэт	240 цаг	Говь-Алтай аймагт амьдарч буй суралцах боломжтой иргэдийг хамруулах

1.2.4.1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сонголт

Хүний нөөцийн төлөвлөлт

Бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын байгуулллагууд нь хүний нөөцийн төлөвлөлтийг байгууллагын зорилго, стратегийн төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтцэд үндэслэн гаргана. Хүний нөөцийн төлөвлөлтөнд аялал жуулчлалын бүс нутаг, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөлт, санал, захиалга чухал үүрэгтэй байна. Хүний нөөцийн төлөвлөлтийг аялал жуулчлалын бүс нутаг, түүнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд /жилээр, 3 жилээр, 5 жилээр/ хэлэлцэн батална. Бүс нутгийн стратеги төлөвлөлт, хүний нөөцийн төлөвлөлтөнд тусгагдаагүй боловч тухайн цаг үеийн ажлын шаардлагаар хүний нөөц бүрдүүлэлтийн асуудал гарсан үед тухай бүр уян хатан байдлаар шийдвэрлэж болно. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөлтийн хүрээнд хүний нөөцийг сумдын удирдлагууд төлөвлөн бүс нутгийг хөгжүүлэхэд идэвхитэй оролцоно.

Хүний нөөцийн бүрдүүлэлт

Хүний нөөцийг бүрдүүлэхдээ аялал жуулчлалын байгууллагууд жилийн төлөвлөгөө гарган зах зээлийн боломжит нөөцөд үндэслэн гаргана. Бүс нутгийн хувьд орон нутгийн хөтөч бэлдэх нь чухал юм. Говь-Алтай аймгийн ЕБС-ийн 12 дугаар анги төгсөж буй сурагчдаас аялал жуулчлалын чиглэлээр ажиллах сонирхолтой сурагчдыг дэмжин ажиллана. Аялал жуулчлалын мэргэжлийн олон улсд магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрөөр сурган хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийнэ. Аялал жуулчлалын чиглэлээр суралцаж буй аймгийн оюутнуудыг бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд дэмжин ажиллана. Зуны амралтаар цалинтай дадлага хийлгэх нөхцлийг бүрдүүлнэ.

Говь-Алтай аймгийн дотоод эх үүсвэрээс бүрдүүлэх

Хүний нөөцийн дотоод эх үүсвэрийг хүний нөөцийн талаарх боловсрол, ур чадвар, мэргэжил, мэргэшлийн түвшний талаарх мэдээллийн бааз, судалгааг үндэслэн хөрвөх, өрсөлдөх чадвар бүхий ажиллагсдаас шинээр бий болсон орон тоо, сул байгаа орон тоо, ажил, албан тушаал дээр

- Бүс нутгийн удирдлагаас санал болгох
- Албан тушаал дэвшүүлэх
- Албан тушаал бууруулах
- Тохирсон ажилд нь шууд томилох
- Шаардлагатай тохиолдолд ур чадвартай боловсон хүчнээс ажиллагсдыг сонгон шалгаруулалтанд оруулах хэлбэрээр дотоодоос хүний нөөцийг бүрдүүлнэ.
- Мэргэжлийн сургууль төгссөн ур чадвартай боловсон хүчнээс сонгон шалгаруулалт зарлан авах

Албан тушаал дэвшин шууд томилогдох ажилтан дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- Аяллын бүс нутагт үр бүтээлтэй ажилласан
- Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ тогтмол 85%-иас дээш байсан
- Мэргэжлийн ур чадвар сайн
- Сахилгын шийтгэлгүй байх
- Хамт олондоо нэр хүндтэй байх

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хангалтгүй, мэргэжлийн ур чадвар тааруу, удирдлагаас удаа дараа сануулга авсан ажилтныг шууд албан тушаал бууруулж томилно.

Гадаад эх үүсвэрээс бүрдүүлэх

Хүний нөөцийн бүрдүүлэлтийг гадаад эх үүсвэрээс хийх нь мэргэжлийн ур чадвартай, онол дадлагын өргөн мэдлэгтэй, шинэ санаа бодол бүхий хүмүүсийг шалгаруулан авах давуу талтай гэж үзнэ. Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран ажиллана. Энэ хүрээнд аяллын бүс нутагт түлхүү шаардлагатай мэргэжлийн, мэргэшлийн чиглэлийн сургуулиудын талаар байнгын судалгаатай байна.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн хүнийн нөөцийн бодлого нь аялал жуулчлалын чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургуулийн мэргэжлийн ангийн төгсөгчид гэж төлөвлөнө. Сургуулиа төгсөөд ажиллах оюутантай /тодорхой шалгуур болзол хангасан/ тусгайлан гэрээ байгуулан ажиллана. Гэрээний дагуу оюутнуудад үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээх, шинээр бий болж байгаа албан тушаал болон сул байгаа ажлын байрыг зарлах, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг танилцуулах ажлыг байгууллагаас тогтмол зохион байгуулна.

Аймгийн аялал жуулчлалын байгууллагатай танилцах болон мэргэжлийн дадлага хийлгэх, тодорхой сэдвүүдээр диплом, бие даалтын ажил хийхэд өөрийн байгууллагад дадлагажуулах, тус хугацааны үнэлгээг харгалзах, улмаар туршилтын хугацаагаар ажиллуулна. Дадлагыг цалинтай хийлгүүлэх ажлыг зохион байгуулж бүс нутгаас аялал жуулчлалын чиглэлээр суралцагсадыг дэмжин ажиллана.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлал сурталчилгаа явуулах

Аялал жуулчлалын бүс нутагт сул ажлын байр болон шинээр бий болсон ажлын байранд ажилтан шалгаруулж авах талаар орчин үеийн бүхий л хэвлэл мэдээллийн эх үүсвэрүүдээс тухайн сул байгаа ажлын байр, албан тушаалаас хамааруулж аль тохиромжтойг сонгон зарлал, сурталчилгаа гаргана.

а. Сонин

Тухайн зарлаж байгаа ажлын онцлог, ажлын байрны тодорхойлолтоос хамаарч өдөр тутмын томоохон хэвлэлүүд, зар сурталчилгаагаар төрөлжсөн сонингуудыг сонгон зарлал гаргана. Орон нутгийн сонин хэвлэлийг ашиглана.

б. Телевиз

Тухайн зарлаж байгаа ажлын онцлог, ажлын байрны тодорхойлолтоос хамаарч телевизийн тусгай нэвтрүүлэгт оролцох, зар мэдээний хөтөлбөрт зарлал өгөх, урсдаг зар ашиглах зэргээр ажлын байр сонирхсон хүмүүст хүрэхүйц сувгуудаар зарлал явуулна.

в. Радио

Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд радиогоор ажлын байрны зарлал явуулах ба хот, хөдөөгийн радио сонсогчдын хүлээн авах боломжийг харгалзан Монголын радио болон бусад богино долгионы радио, өргөн нэвтрүүлгүүдээр зарлал явуулна.

Онлайн, интернэт, нийгмийн сүлжээ

Ажлын байрны болон ажил горилогчдын талаарх мэдээлэлийн сүлжээ бүхий интернет дэх вэб сайтуудаар сул чөлөөтэй ажлын байр, албан тушаалын талаар нийтэд сурталчилж, тэдгээрт байгаа ажил хайгчдын мэдээллээс шаардлагатай гэж үзсэн хүмүүсийг сонгон шалгаруулалтанд урина.

Зохион байгуулалттай яармаг, нэгдсэн арга хэмжээнд оролцох

Ажлын байрыг нэмэгдүүлэх талаар төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах нэгдсэн арга хэмжээнүүдэд байнга оролцож аялал жуулчлалын бүс нутагт байгаа сул чөлөөтэй ажлын байр, албан тушаалын талаар нийтэд сурталчилна.

Ажлын байрны зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн ба төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах

Ажлын байрны зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хөдөлмөрийн бирж, зуучлагч албадтай гэрээ байгуулан ажиллах, ажлын байранд тавигдах шаардлагын дагуу захиалга өгөх, тэдгээр байгууллагаас ирүүлсэн ажил горилогчдын талаарх мэдээллийн эх үүсвэрээс хүний нөөцийг бүрдүүлнэ.

Гадаад орны иргэн болон харъяалалгүй хүнийг ажиллуулах

Мэргэжлийн болоод техникийн өндөр ур чадвар шаардлагатай албан тушаал дээр ур чадвар, шинэ технологи, менежментийг нэвтрүүлэх, арга барилаас суралцах зорилгоор гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнийг авч ажиллуулах асуудлыг аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд санаачлагатай ажиллана.

Ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан гадаад улсын иргэнийг талууд тохиролцсоны үндсэн дээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж болно. Энд төслийн шугамаар ирж байгаа гадаад иргэнийг тооцохгүй.

Бүс нутагт аялал жуулчлалын чиглэлээр гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг авч ажиллуулахдаа Монгол улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, эрх зүйн актууд болон байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, үйл ажиллагаанд баримтлан ажилладаг бусад дүрэм журмыг баримтална.

“НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙР” хөтөлбөр

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутаг, өөрийн байгууллагын вэб хуудсанд тусгай булан нээх буюу “Ажлын байр”-ны нэгдсэн зар бүхий вэб сайтуудад, тодорхой их дээд сургуулиуд, хөдөлмөрийн биржүүдийн байранд байнгын “Нээлттэй ажлын байр”-ны зар гаргаж хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийж, тухайн албан тушаалд ажиллаж байгаа ажилтнуудтай өрсөлдүүлэх замаар сонгон шалгаруулалтыг хийж болно.

Хүний нөөцийн сонгон шалгаруулалт

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь сул байгаа орон тоо болон шинэ ажлын байранд ажилтан авахдаа хүмүүсийн дунд сонгон шалгаруулалт явуулна.

Анхан шатны шалгаруулалт:

Анхан шатны шалгаруулалтыг хүний нөөцийн менежер зохион байгуулж явуулна. Ажил горилогчдын анкетыг судлан шаардлагад нийцсэн хүмүүсээс сонголт хийнэ. Сонгогдсон хүмүүсийг урьж, шалгалт авна */гадаад хэл, болон мэргэжлийн ур чадвар/*. Мэргэжлийн шалгалтанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн, холбогдох хэлтэс, нэгжээс албан тушаалтнуудыг оролцуулна. Аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн хэмжээд мэргэжил тус бүрээр гаргасан шалгалтын стандарт материал үйлчлэх бөгөөд мэргэжлийн шалгалтыг бүх ажил горилогчдоос авна. Шалгалтанд тэнцсэн хүмүүсийг холбогдох нэгж, хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй комисс анхан шатны ярилцлаганд оруулна. Анхан шатны шалгаруулалтанд орж тэнцсэн хүмүүсийг ажлын байран дээр ажилд авах шийдвэр гарсан тохиолдолд туршилтын хугацаагаар ажиллах гэрээ байгуулна.

Хоёр дахь шатны шалгаруулалт

Анхан шатны шалгаруулалтанд тэнцсэн хүмүүсийг Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд танилцуулах ярилцлаганд оруулж, эцсийн сонгон шалгаруулалтыг шийдвэрлэнэ. Хүний нөөцийн менежер ярилцлагын бэлтгэл ажил болгож анхан шатны шалгаруулалтын материал, ажил горилогчийн ажлын байранд ажилласан тухай хэлтсийн дүгнэлтийг гүйцэтгэх захиралд урьдчилан танилцуулсан байна.

Ажилд авах, шилжүүлэх

Ажилд авах

Говь-Алтай аймагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь шинээр бий болж байгаа ажлын байр болон сул орон тоон дээр сонгон шалгаруулалтаар тэнцсэн ажилтныг ажилд авахдаа дараах 2 хэлбэрээр авна.

- ✓ Туршилтын хугацаагаар ажиллуулах
- ✓ Үндсэн ажилтнаар ажиллуулах

Шинээр ажилд орж байгаа ажилтныг туршилтын хугацаагаар ажиллуулах

Сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажилтантай аж ахуйн нэгжүүд туршилтын хугацааг 3 сараар тогтоон “Туршилтын хугацааны хөдөлмөрийн гэрээ”-г байгуулна. Туршилтын хугацаа дууссан ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарч ажилтанг үндсэн ажилтнаар ажиллуулах, туршилтын хугацааг сунгах, мөн туршилтын хугацаанаас өмнө үндсэн ажилтнаар авах асуудлыг хэлтэс, нэгжийн даргын тодорхойлолт, Хүний нөөцийн менежерийн санал, үндсэн ажилтнаар авах зорилгоор зохион байгуулсан албан тушаалтнуудын ярилцлагын дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгжийн захирлын тушаалаар эцэслэн шийдвэрлэнэ. Туршилтын хугацаа дууссан ажилтны ажлын гүйцэтгэлийг дүгнэхэд шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шалгалт авч болно. Харьяа нэгж хэлтэс нь тухайн ажилтныг туршилтын хугацаа дуусахаас нь өмнө үндсэн ажилтнаар авах санал гаргаж болно. Ажилтан тухайн албан тушаалд үндсэн ажилтнаар авах талаар тушаал гарсан тохиолдолд хөдөлмөрийн гэрээг туршилтын хугацааг оролцуулан шинээр байгуулна. Туршилтын хугацаанд ажиллах явцдаа ажилтан тухайн албан тушаалд тэнцэхгүй нь тогтоогдвол уг ажилтантай байгуулсан туршилтын хугацааны гэрээгээ хугацаанаас нь өмнө Захиргааны санаачлагаар цуцлаж болно. Ажилтантай харилцан тохиролцож, туршилтын хугацааг үргэлжлүүлэн сунгаж болно. Туршилтын хугацаагаар ажиллаж байгаа ажилтанд Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд үзүүлэх хөнгөлөлт, нийгмийн халамж, урамшуулал хамаарахгүй ба үүнийг туршилтын хугацааны хөдөлмөрийн гэрээнд тодорхой тусгана. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтаар тэнцсэн шинэ ажилтанг дадлагажуулж, үндсэн ажилтнаар авах, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах зарчим баримтлан ажиллах тул шинэ ажилтанд өөрийгөө нээн харуулах, ажлаа үр дүнтэй гүйцэтгэх шаардлагыг тавина. Хүний нөөцийн менежерийн зүгээс “Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөр”-ийн дагуу чиглүүлэх сургалтыг зохион байгуулна. Туршилтын хугацаагаар ажиллах ажилтанд дадлагажуулагчийг тусгайлан томилно. Дадлагажуулагч нь шинэ ажилтны туршилтын хугацаанд тухайн ажилтныг ажлын байрны талаарх анхан шатны мэдлэгийг олгох, тухайн мэргэжилд дадахад чиглэл өгч, цаг ашиглалтанд хяналт тавин, ажлын байранд нь заавар зөвлөгөө өгч ажиллана. Туршилтын хугацаагаар ажиллагч нь ажиллах хугацаандаа байгууллагын дотоод журам, бусад заавар журамд нэгэн адил захирагдан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллана. Үндсэн ажилтнаар ажиллуулах

1. Туршилтын хугацаа дуусч байгаа ажилтан
2. Ажлын туршлагатай, өндөр ур чадвартай, туршилтын хугацаагаар ажиллуулах шаардлагагүй гэж үзсэн ажилтанг тус тус үндсэн ажилтнаар ажиллуулна.

Туршилтын хугацаа дуусч үндсэн ажилтнаар ажиллуулах тушаалаар томилогдсон ажилтантай хөдөлмөрийн гэрээний нөхцлийг тохиролцон, ажилтантай Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хүний нөөцийн менежер хөдөлмөрийн гэрээ байгуулна. Тухайн албан тушаал, ажил үүрэгтэй холбоотой мэргэжлээр олон жил ажилласан, ажлын туршлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай хүмүүсийг туршилтын хугацаагаар ажиллуулах шаардлагагүй тохиолдолд гүйцэтгэх захирлын тушаалаар шууд үндсэн ажилтнаар ажиллуулж болно. Үндсэн ажилтнаар томилогдсон ажилтан нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн, байгууллагын дотоод дүрэм журмыг мөрдөн ажиллах үүрэгтэй бөгөөд байгууллагаас үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг тусламж болон шагнал урамшуулал зэргийг холбогдох журамд заасны дагуу хүртэх эрх нь нээгдэнэ.

Хүний нөөцийн сургалт, хөгжил

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд зорилго, зорилт, стратегитай уялдуулан үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор өөрийн ажиллагсдыг сургалтанд тогтмол хамруулах, сургалт зохион байгуулах, тэдгээрийн ур чадварыг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллана.

Хүний нөөцийн алба нь жил бүрийн эцэст дараа жилийн сургалтын төлөвлөгөөг гарган паркын төсөв, төлөвлөгөөнд оруулан батлуулна. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд хамтран аймгийн хэмжээнд хүний нөөцийн сургалтыг зохион байгуулж болно. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд захиргаанаас баталсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хүний нөөцийн алба нь тухайн сургалтыг явуулна. Сургалтыг:

- а. дотоодын сургалт
- б. гадаад сургалт гэж ангилна.

Дотоод сургалтыг:

- Шинэ ажилтны чиглүүлэх сургалт
- Ажилтнуудад зориулсан сургалт гэж ангилна
- Ажилтны ур чадварыг сайжруулах, онол, практикийн мэдлэгийг нэмэгдүүлэх

Гадаад сургалтыг:

- Аялал жуулчлалын мэргэжлийн төрөлжсөн сургалтын байгууллагын багц сургалтууд
- Хилийн чанадад /гадаадын аль нэг улс оронд/ гэж ангилна.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс санхүүжүүлж байгаа урт хугацааны мэргэших сургалтанд хамрагдах ажилтантай “Сургалтын гэрээ” байгуулна. Сургалтын гэрээний дагуу сургалтанд хамрагдсан ажилтан бүр шинэ санал, санаачлага нэвтрүүлэх, сургалтаар олж авсан мэдлэг, ур чадварыг дайчлан байгууллагын ажлын үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх, холбогдох ажилтнуудад сургалт явуулах үүрэг хүлээнэ.

Дотоод сургалт

Байгууллагын дотоод сургалтыг парк өөрийн дотоод эх үүсвэрээ ашиглан явуулна.

Шинэ ажилтны чиглүүлэх сургалт. Энэ нь 2 үе шаттай хэрэгжинэ.

- **Танилцуулах сургалт** буюу байгууллагын тухай танилцуулга, үйл ажиллагааны тухай ойлголт, байгууллагын дотоод дүрэм журам, заавар, дотоод мэдээллийн урсгал, ажлын байрны тодорхойлолт, албан тушаалын зэрэг дэв, харилцааны ёс зүй, байгууллагын соёл гэсэн сэдвүүдээр явагдана. Эдгээрийг багтаасан CD, DVD, гарын авлага, номыг шинэ ажилтанд өгнө. Энэ сургалтанд шинээр ажилд орж байгаа бүх ажилтнууд мэргэжлээсээ үл хамааран хамрагдана. Чиглүүлэх сургалт нь паркаас баталсан хөтөлбөрийн дагуу явагдана.
- **Мэргэжлийн сургалт** буюу албан тушаал бүрт хамаарах дадлагажуулах сургалтыг хийнэ. Өөрөөр хэлбэл шинэ ажилтны туршилтын хугацааны дадлагажуулагчийг томилон шинэ ажилтныг туршилтын хугацааны турш дадлагажуулж бэлтгэнэ.
- **Үндсэн ажилтны ур чадвар дээшлүүлэх сургалт**
 - Аймаг өөрсдийн дотоод нөөц бололцоог түшиглэн зохион байгуулах
 - Гадаад, дотоодын сургагч байгууллагууд, мэргэжилтнүүдийг урьж зохион байгуулах
 - Мэргэжлийн их дээд сургуулийн эрдэмтэн, профессоруудыг урьж зохион байгуулна. Нийт болон тодорхой хэсэг ажилтнуудад зориулсан зохион байгуулалттай сургалт байна.

Байгууллагын дотоод сургалтыг тусгай төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулна. Хүний нөөцийн менежер нь сургалт явуулах чиглэл, удирдамжийн дагуу сургалт явуулах нөөцүүдийг тодорхойлж, хэсэгчлэн болон бүх ажилтнуудыг хамруулах байдлаар хэлтэс, нэгжийн онцлогтой уялдуулан сургалтыг зохион байгуулна.

Гадаад сургалт:

Говь-Алтай аймгийн аялал жуулалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд гадаад сургалтанд мэргэжлийн болон бусад төрлийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг гадаадын болон өөрийн орны байгууллагын зохион байгуулж байгаа академик, мэргэжлийн, зэрэг ахиулах болон бусад ур чадварын урт, богино хугацааны сургалтанд байгууллагын зардлаар болон байгууллагын албан ёсны харилцаатай гадаад, дотоодын байгууллагын зардлаар хамрагдахыг ойлгоно. Сургалтын агуулга цар хүрээ зэргээс хамааруулан тус сургалтанд суух ажилтныг хэлтэс нэгжийн шууд удирдлага болон захирлын саналуудыг үндэслэн сонгоно. Сургалтын агуулга, зорилгоос хамаарч байгууллагын гадаад сургалтыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Боловсролын зэрэг ахиулах академик сургалт
- Мэргэжлийн зэргээ ахиулах академик сургалт
- Мэргэжил олгох академик сургалт
- Мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалт
- Мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалт

Сургалтанд хамрагдах ажилтнуудын шалгуур

Байгууллага гадаад сургалтыг зохион байгуулахдаа сургагч байгууллагуудын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулж сургалтын байгууллагуудтай гэрээ хийхээс гадна сургалтанд хамрагдаж байгаа ажилтантай тусгай гэрээ байгуулна. Сургалтын гэрээг жил бүр байгууллагын хүний нөөцийн хэлтэс дүгнэнэ. Гадаад, дотоод сургалтанд хамрагдах ажилтан дараах шалгуурыг хангасан байвал зохино. Үүнд:

- Сургалтанд хамрагдах ажлын болон хувийн хэрэгцээ шаардлагатай байх
- Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа

- Мэргэжлийн дагуу цаашид өсөн дэвжих бололцоотой
- Ажиллах хугацаандаа сахилгын шийтгэлгүй
- Байгууллагад аливаа өр зээлийн төлбөрийн зөрчилгүй байх
- Ажилдаа идэвх санаачлагатай бүтээлч ханддаг
- Гадаад хэлний мэдлэг сайтай
- Суралцах идэвх сонирхолтой

Хилийн чанадад сургалтанд хамрагдах ажилтан байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй 3 жил ажилласан байх, цаашид идэвх санаачлагатай, өсөж ажиллах ирээдүйтэй, байгууллагад үр өгөөжтэй ажиллах зэрэг шаардлагыг хангасан байна. Эдгээр шаардлагыг хангасан ажилтныг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гадаад сургалтанд хамрагдах эсэхийг шийдвэрлэнэ.

Сургалтын үр дүнг тооцох үнэлэх

Байгууллагаас санхүүжүүлсэн сургалтын үр дүнг хүний нөөцийн хэлтэс үнэлж, дүгнэнэ. Сургалтын гүйцэтгэл үр дүнг 2 хэлбэрээр гарган дүгнэж болно.

- **Суралцагчийн сургалтын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх.** Ажилтныг сургалтанд хамруулахын өмнө түүний мэдлэгийн түвшинг тогтоох тестийг авна. Энэ нь сургалтын дараа мэдлэгийн түвшин дээшилсэн эсэхэд үнэлгээ өгөхөд чиглэнэ. Суралцагчийн гадаад дотоод, урт богино хугацааны аль сургалтанд суралцсанаас хамааран сургалтын үр дүнг дараах шалгуураар дүгнэнэ.
 1. Сургалтанд хамрагдсан байдал
 2. Сургалтын тестийн үнэлгээ
 3. Сургалтын дараа ажил дээр хэрэгжүүлсэн, нэвтрүүлсэн ажил болон санал санаачлага, ур чадвар дээшилсэн эсэх
 4. Сургалтын тайлан
- **Сургагчийн сургалтын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх.** Байгууллагын дотоодын сургагч болон гадны сургагч багшийн сургалтын үр дүнг дараах шалгуураар дүгнэнэ.
 1. Сургалт зохион байгуулсан хэлбэр,
 2. Сургалтын сэдвийн хамарсан хүрээ
 3. Сургагчийн ур чадвар
 4. Сургалтын бэлтгэл, агуулга, материалын бэлтгэл хангалт
 5. Сургалтын үр дүнг тооцсон байдал, арга хэлбэр

Сургалтын үр дүн, гүйцэтгэлийг тооцох нь тухайн ажилтныг сургалтын төлбөрөөс чөлөөлөх болон дахин сургалтанд хамруулах эсэх талаар эцсийн шийдвэр гаргах үндэслэл болно. Сургалтын үр дүнг ажилтныг сургалтанд хамрагдан ирснээс хойш тодорхой хугацаанд тайлагнуулах, шууд удирдлагын зүгээс ажлын ур чадварт ахиц гарсан тухайд үнэлгээ өгч тооцно.

Ажилтны санал хүсэлтийг хүлээн авах ба шийдвэрлэх

Байгууллагын шат шатны удирдлагууд нь ажилтнуудын санаа бодол, тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлыг авч үзэж, эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэн, хариуг мэдэгдэнэ. Байгууллагын удирдлага ажлын байр, хөдөлмөрлөх нөхцлийн талаар, хөдөлмөрийн дотоод журам болон бусад журам шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудалд ажилтнуудын санал хүсэлтийг авч боломжтой хувилбараар тусгана. Ажилтан нь цалин хөлс, ажлын цаг, сонирхож буй албан тушаал, удирдах арга барил, хамт ажиллагсдын тухай, тушаал шийдвэрийн биелэлтийн талаарх асуудал, бүтээлч санал, санаачлага зэргийг хөндөж асуудал дэвшүүлж болно. Ажилтны

зүгээс гаргасан санал хүсэлт, аливаа бэрхшээлтэй асуудлыг тухайн удирдлага хөндөж ярилцахгүй тохиолдолд дараагийн шатны буюу шийдвэрлэх шатны удирдлагад хандах боломжтой. Байгууллагын удирдах ажилтны хооронд нээлттэй харилцах уур амьсгалыг бүрдүүлж өгөхийн зэрэгцээ шударга байх, нууц хадгалах зарчмыг чанд баримтална. Энэ талаар удирдах албан тушаалтнуудад тусгайлан сануулах ба хөдөлмөрийн дотоод журамд оруулсан байна.

Цалин хөлс

Байгууллага Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, холбогдох журмуудыг үндэслэн ажилтны мэдлэг боловсрол, ур чадвар, туршлага, хөдөлмөрийн бүтээмжийг нь үнэлэн хөдөлмөрийн хөлс буюу цалин олгоно.

Үүнд:

1. Үндсэн цалин
2. Нэмэгдэл цалин /илүү цаг ажилласан, томилолтоор явсан, ажил хавсран гүйцэтгэсэн/ илүү цагийн жрмын дагуу/
3. Удаан жилийн нэмэгдэл /нэмэгдлийн дагуу/
4. Олговор /хоол, унааны олговор/

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшуулал

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ. Байгууллагын ажилтнуудын ажлын үр дүн гүйцэтгэлийг хэлтэс нэгжийн дарга нар, хэлтэс нэгжийн дарга нарын ажлын гүйцэтгэлийг гүйцэтгэх захирал хагас жил, жилээр дүгнэнэ. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг /цаашид КРІ гэх/ батлагдсан маягт, аргачлалын дагуу ажилтан нэг бүрээр үнэлэх ба уг үнэлгээнд удирдах ажилтан хувийн үзэмжээр хандах, шударга бус үнэлэхийг хориглоно.

Эдийн засагч, менежер, борлуулагч КРІ-ээг төсөв төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулан үнэлэх бол бусад ажилтнуудын КРІ-ээг батлагдсан маягт, аргачлалын дагуу тооцно. Урамшуулалт цалин олгох тухай асуудлыг “Урамшуулалт тооцох журам”-аар зохицуулна. Ажлын үр дүн, гүйцэтгэлээр ажилтан хоёр улирал дараалан тогтоосон шалгуураас доош үнэлгээтэй ажилласан тохиолдолд холбогдох хэлтэс, нэгжийн дарга шалтгааныг нь тодруулан хугацаатай үүрэг өгөх, хариуцлага тооцох болон тухайн ажилтныг цаашид уг ажил албан тушаал дээр ажиллуулах эсэх талаар болон ажлаас чөлөөлөх хүртэлх асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Шагнал урамшуулал. Байгууллага нь ажилтнуудын ажлын идэвхийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийг шударга үнэлэх, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах, ашгийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөн болон мөнгөн бус байдлаар шагнаж урамшуулж болно. Мөнгөн урамшууллыг биет хэлбэрээр дараах тохиолдолд олгож болно. Үүнд:

- Байгууллагын нэр хүндийг өсгөх, ашиг орлогыг нэмэгдүүлэх үйл хэрэг хийсэн, бүтээлч аян санаачлага нэвтрүүлсэн, ашиг, орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан, ажил сайжруулах зохион байгуулалттай уралдаанд түрүүлсэн зэрэг тохиолдолд
- Байгалийн гамшиг, онцгой байдал зарласан үед авхаалж самбаа гарган гавъяат үйлс бүтээсэн болон үлгэрлэн дууриах үйлс бүтээсэн

Мөнгөн бус байдлаар шагнаж урамшуулах хэлбэрт ажилтны ажлын амжилтыг хамт олон дунд сайшаах, байгууллагын зүгээс бусад ур чадварын сургалтанд хамруулах, цалинтай чөлөөний амралт олгох, гэр бүлд нь талархал илэрхийлэх, гадаад оронд болон дотооддоо аялуулах, дотоодын амралтанд амрах эрхийн бичиг олгох, оройн зоог барих эрх, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрх олгох, байгууллагын нэрэмжит

шагнал болон бусад төрийн ба төрийн бус байгууллагын шагналд тодорхойлох байж болно.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн төлөвлөлт

Жуулчин хүлээн авах хүчин чадал: Говь-Алтай аймаг нэг ээлжинд 1118 ор (жилээр 402480 үүнээс ор ашиглалт 20 хувиар тооцоолов 10800 зочин)

Хүснэгт 9. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн төлөвлөлт

Хүний нөөцийн эрэлт	Говь-Алтай аймагт ирэх жуулчдын тооны өсөлтийн прогноз		
2023 онд ирэх жуулчдын тоо	4200 гадаад жуулчин		13000 Дотоодын жуулчин
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	Орон нутгаас
аяллын хөтөч	1000	40	
Тогооч	30		30
Жолооч	1000	40	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			3
Орон нутгийн хөтөч	20	20	
Зоог хоол үйлчилгээний ажилтан	40		40
2024 онд ирэх жуулчдын тоо	4500 гадаад жуулчин		15000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	Орон нутгаас
аяллын хөтөч	1100	45	
Тогооч	40		40
Жолооч	1100	45	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			3
Орон нутгийн хөтөч	20	20	
Зоог хоол үйлчилгээний ажилтан	50		50
2025 онд ирэх жуулчдын тоо	4700 гадаад жуулчин		17000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	Орон нутгаас
аяллын хөтөч	1200	50	
Тогооч	50		50
Жолооч	1200	50	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			4
Орон нутгийн хөтөч	25	25	
Зоог хоол үйлчилгээний ажилтан	50		50
2026 онд ирэх жуулчдын тоо	5100 гадаад жуулчин		18000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	
аяллын хөтөч	1300	55	
Тогооч	50		50

БОТЬ II-СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Жолооч	1300	55	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			4
Орон нутгийн хөтөч	25	25	
Зоог хоол үйлчилгээний ажилтан	50		50
2027 онд ирэх жуулчдын тоо	5500		21000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	
аяллын хөтөч	1400	55	
Тогооч	60		60
Жолооч	1300	55	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			4
Орон нутгийн хөтөч	30	30	
Зоог хоол үйлчилгээний ажилтан	60		60
2028 онд ирэх жуулчдын тоо	5800		25000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	
аяллын хөтөч	1500	60	
Тогооч	60		60
Жолооч	1300	55	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			5
Орон нутгийн хөтөч	30	30	
Зоог хоол үйлчилгээний ажилтан	70		70
2029 онд ирэх жуулчдын тоо	6300		28000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	
аяллын хөтөч	1600	60	
Тогооч	70		70
Жолооч	1300	55	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			5
Орон нутгийн хөтөч	35	35	
Зоог хоол үйлчилгээний ажилтан	70		70
2030 онд ирэх жуулчдын тоо	6800		30000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	
аяллын хөтөч	1700	70	
Тогооч	70		70

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Жолооч	1300	55	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			5
Үйлчилгээний ажилтан			
Орон нутгийн хөтөч	40		40
Зоог хоол үйлчилгээний ажилтан	80		80
2031 онд ирэх жуулчдын тоо	7300		33000
Шаадлагатай хүний нөөц			
	нийт	Орон нутгаас	
аяллын хөтөч	1800	70	
Тогооч	70		70
Жолооч	1300	55	
Говь-Алтайн Аяллын бүтээгдэхүүн борлуулалтын менежер			5
Орон нутгийн хөтөч	50		50
Зоог хоол үйлчилгээний ажилтан	80		80

1.2.5. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Говь-Алтай аймгийн аялал жуучлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх явцад доор дурдсан гадаад орчны аюул, бэрхшээл болон дотоод орчны сул талаас эрсдэл тохиолдож болохыг анхаарах нь зүйтэй. Эрсдэлийн тухай ойлголт нь тодорхойгүй байдлаас үүдэн бий болдог ойлголт юм. Өөрөөр хэлбэл: Тодорхойгүй байдалтай уялдаатайгаар төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх гадаад дотоод нөхцөл байдлаас гарч болох саад бэрхшээл учруулж болох аюул заналыг эрсдэл гэдэг.

Дараах эрсдэлийн матрицын аргыг ашигласан болно.

Хүснэгт 10. Эрсдэлийн үнэлгээний матриц

Нөлөөлөл		Давтамж /1-5 оноо/				
Далайц /1-5 оноо/	5	5	4	3	2	1
	5	5:5	5:4	5:3	5:2	5:1
	4	4:5	4:4	4:3	4:2	4:1
	3	3:5	3:4	3:3	3:2	3:1
	2	2:5	2:4	2:3	2:2	2:1
	1	1:5	1:4	1:3	1:2	1:1

Онооны тайлбар:

Далайц /хор хөнөөлийн зэрэглэл/

- **1 оноо** Нөлөө үзүүлэхгүй - хохиролгүй
- **2 оноо** Бага нөлөөтэй – хохирол бага
- **3 оноо** Дундаж нөлөөтэй – дундаж хохирол
- **4 оноо** Их нөлөөлөлтэй – их хохирол
- **5 оноо** Маш их нөлөөтэй – маш хохирол

Давтамж /цаг хугацааны зэрэглэл/

- **1 оноо** Илэрцгүй буюу давтамж байхгүй
- **2 оноо** Бага илэрцтэй – давтамж бага
- **3 оноо** Дундаж илэрцтэй – дундаж давтамж
- **4 оноо** Их илэрцтэй – их давтамжтай
- **5 оноо** Маш их илэрцтэй – маш маш их давтамжтай

1.2.5.1. ГАДААД ОРЧНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 11. Гадаад орчны эрсдэлийн үнэлгээ

№	АЮУЛ/БЭРХШЭЭЛ	Үүсэх эрсдэл	Дал айц 0-5	Давт амж 0-5	ҮНЭЛ ГЭЭ	зөвлөмж
Улс төрийн орчин						
1	Монгол улсын “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т “Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, үнэ өндөр, өөр хоорондоо ялгаа багатай” хэмээн тодорхойлжээ.	Жуулчдын хувьд ялгарах бүтээгдэхүүн, үйлчилгээ бага учраас ахиж ирэхгүй байх эрсдэлтэй.	3	2	2.5	Говь-Алтай аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх нарийвчилсан хөтөлбөрийг боловсруулна.
2	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тус салбарын хөгжлийн сул талыг “Дэд бүтэц муу, жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадал бага” хэмээн тодорхойлжээ.	Бүтээгдэхүүн, үйлчилгээ жуулчны эргэлтийн тоо бага байгаа нь эрсдэл үүсгэнэ.	2	3	2.5	Дэд бүтэц, жуулчинд үйлчлэх тээврийг сайжруулах ажлуудыг зохион байгуулна.
3	Аялал жуулчлалын салбарын хөгжлийн сул талыг “Монгол орны эрс тэс цаг уурын байдал” хэмээн тодорхойлжээ.	Жуулчны улирал богино учир цөөн жуулчин ирнэ.	3	3	3	Жуулчны улирлыг уртасгахад олон төрлийн эвент арга хэмжээнүүдийг төлөвлөнө.
4	“Мэргэжлийн ажиллах хүчин дутмаг, аялал жуулчлалын салбарын сургалт, судалгааны чанар хангалтгүй” хэмээн сул талыг тодорхойлжээ.	Мэргэжлийн ажиллах хүчний нөөц бага байгаа нь үйлчилгээний чанарт шууд нөлөөлнө.	3	3	3	Хүний нөөцийг бэлдэх, мэргэжлийн сургалтуудын хөтөлбөр боловсруулна.
5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тус салбарын хөгжлийн сул талыг “Жуулчдын статистик бүртгэл хөтлөх, судалгаа хийх тогтолцоо сул, мэдээллийн нэгдсэн сан байхгүй” хэмээн тодорхойлжээ.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн төлөвлөх боломж бүрдэхгүй.	2	2	2	Жуулчдад үйлчлэх мэдээллийн төв байгуулна.
6	“Жуулчдыг татахад чиглэсэн маркетинг, гадаад сурталчилгааны ажил хангалтгүй” хэмээн тодорхойлжээ.	Олон улсын зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээг таниулах боломж бага	3	4	3.5	Аялал жуулчлалын маркетингийн төлөвлөгөө боловсруулах, Олон улсын аялалын байгууллагын нэгдсэн сүлжээнд гишүүнээр элсэх зорилт тавина.
Хууль, эрх зүйн орчин						
7	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу аялал жуулчлалын	Байгаль орчны үнэлгээ хийгээгүй тохиодолд байгаль				Аялал жуулчлалын тусгай

БОТЬ II-СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

	үйлчилгээ эрхлэгч аливаа байгууллага байгаль орчны үнэлгээ хийлгэж, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх аливаа зөрчлийг төлөвлөгөө гарган залруулж ажиллана.	орчинд ахиад аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах боломжгүй болох эрсдэлтэй.	4	3	3.5	зөвшөөрөл олгох дүрэм журмыг шинэчлэн боловсруулна.
8	“Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам”-н долоодугаар бүлэгт ТХГН-т үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд 9 зүйл хориглох үйл ажиллагааг тодорхойлсон буюу уг бүс нутагт аливаа хуулийн этгээд хязгаарлалттайгаар үйл ажиллагаа эрхлэхээр заасан байна.	Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн доройтол үүснэ.	3	4	3.5	Хууль дүрмийн хэрэгжилт, хяналтыг сайжруулж ажиллах, холбогдох дүрэм журмыг боловсруулна
9	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд тавьсан шаардлага бүхий 10 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэдий ч хэт барилгын стандартын шинжтэй, үйлчилгээний стандарт шаардлага багатай, ОУ-ын жишигт хүрэхгүй байгаа нь манай улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадвар сул байгаагийн үндсэн шалтгаан болоод байна.	Үйлчилгээний стандарт журам сайн төлөвлөж боловсруулахгүй байгаа нь үйлчилгээний хэв маяг, аялал жуулчлалын үйлчилгээ олон улсын түвшинд хүрэхгүй. Хэрэглэгч нийлүүлэгчийн зөрүү үүсэх эрсдэл бий.	4	4	4	Аялал жуулчлалын салбарт дагаж мөрдөж байгаа одооны стандартуудыг ОУ-ын стандарт түвшинд хүргэх төлөвлөгөө боловсруулна.
Эдийн засгийн орчин						
10	Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн төлөвийг эерэгээр харж байгаа хэдий ч богино болон дунд хугацаанд төсөв, гадаад өрийн хувьд эрсдэл хэвээр байгааг анхааруулсаар байна.	Аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалт багасах эрсдэлтэй.	4	2	3	Хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг бий болгох ажлыг үе шаттай зохион байгуулна.
11	Гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд огцом буурсан.	Хууль эрх зүйн орчин тогтворгүй байгаа нь гадны хөрөнгө оруулалт, жуулчдын урсгалд сөргөөр нөлөөлнө.	4	3	3.5	Хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг бий болгох ажлыг үе шаттай зохион байгуулна.
12	Төгрөгийн ам доллартай харьцах ханш тогтмол өссөөр байна.	Ханшны өөрчлөлт нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний үнэнд шууд сөрөг нөлөөтэй.	3	4	3.5	Улс төр, эдийн засгийн хувьд тогтвортой байх, эрсдэлтэй үеийн эрсдэлийн төлөвлөгөө боловсруулна
13	Сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь буурсан үзүүлэлттэй байна	Дотоодын бүтээгдэхүүн аялал жуулчлалын бүтээгдэхүүн	4	3	3.5	Эдийн засгийн хувьд тогтвортой байх,

		үйлчилгээнд эзлэх хувь бага байна.				эрсдэлтэй үеийн эрсдэлийн төлөвлөгөө боловсруулна
Нийгэм соёлын орчин						
15	Монголын аялал жуулчлалын сонирхлын бүс нь зөвхөн Монгол орноор хязгаарлагдахгүй бөгөөд Монголын аялал жуулчлалын сонирхлын бүсэд БНХАУ, Япон, Солонгос зэрэг орнууд багтсан өргөн хүрээний талбайг эзэлж байна.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг төлөвлөхдөө зөвхөн орон нутгийн хүрээнд төлөвлөж байгаа нь бүс нутгийн аялал жуулчлалаас тусгаарлах эрсдэл үүснэ.	4	3	3.5	Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүс нутгийн хүрээнд боловсруулах төлөвлөгөө гаргана
16	Аялал жуулчлалын салбараас манай орны нийгэм соёлд нөлөөлөх нөлөөллийн судалгаанд иргэд аялал жуулчлалын сөрөг нөлөө хандлагыг “Биеэ үнэлэлт, архи тамхи мансууруулах бодисын хэрэглээ, хог хаягдал орчны бохирдол, орчны дуу чимээ, шуугиан, түгжрэл” хэмээн тодорхойлжээ.	Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.	4	4	4	Жуулчлах хэм хэмжээний дүрэм, журам, зөвлөмжийг боловсруулж хэрэгжүүлнэ.
Технологийн орчин						
17	Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн технологид томоохон ач холбогдолтой технологи бол усны хэмнэлтийн технологи юм. Олон улсын аялал жуулчлалын түншлэлээс манайх шиг хүйтэн сэрүүн уур амьсгалтай орны хувьд нэг жуулчны нэг хоногийн усны хэрэглээ 0,3м3-с бага болон маш сайн, 0,45м3-0.3м3-ийн хооронд бол боломжийн хэмээн стандарт тогтоосон байна. Уг үзүүлэлтэд хүрэхийн тулд жуулчны үйлчилгээний байгууллагууд усны хэмнэлтийн технологийг нэвтрүүлэх нь зайлшгүй болоод байна.	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд усны хэмнэлтийн технологийг нэвтрүүлж ашиглахгүй бол үндны усны хомсдол үүсэх эрсдэлтэй..	5	4	4.5	Аялал жуулчлалын байгууллагууд усны хэмнэлтийн технологийг нэвтрүүлж ашиглах дүрэм журмыг боловсруулна.
18	Олон улсад аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх боломжтой хүчин төгөлдөр 25 ISO болон EN стандарт байгаа ч манай улс аль ч стандартыг өөрийн оронд нэвтрүүлэх ажил эхлээгүй, үндэсний стандарт болгон нэвтрүүлээгүй байна.	Олон улсын аялал жуулчлал хөгжүүлж байгаа нөхцөлд түүнд таарсан стандартууд дагаж мөрдөх шаардлагатай. Үйлчилгээний стандартын зөрүү үүсэх эрсдэлтэй.	4	4	4	Олон улсын үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, өөрийн орны стандартын түвшинг дээшлүүлнэ.
Олон улсын орчин						
19	Аялал жуулчлал нь улс төр, эдийн засгийн хямрал, дайн дажин,	Олон улсын хүрээнд үүсэж				Улс төр, эдийн засгийн хувьд

БОТЬ II-СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

	ядуурал, байгалийн гамшиг, халдварт өвчин, олон улсын терроризм зэрэг урьдчилан таамаглах боломжгүй олон хүчин зүйлсээс шууд хамааралтай ихээхэн эмзэг салбар болохыг өнгөрсөн хугацаанд дэлхий дахинд болж буй үйл явдлууд харуулж, түүнийг хохирол багатайгаар давж, урьдчилан сэргийлэхэд улс орнууд онцгой анхаарч, бодлогоо төлөвлөх болжээ.	байгаа улс төр, эрүүл мэнд, өвчин зовлон, эдийн засгийн хямралуудаас шалтгаалж аялал жуулчлалын урсгал буурах эрсдэлтэй.	2	2	2	тогтвортой байх, эрсдэлтэй үеийн эрсдэлийн төлөвлөгөө боловсруулна.
20	Мэдээлэл, харилцаа холбооны технологи аялал жуулчлалын салбарт хүчтэй нэвтэрч байгаатай холбогдож тур оператор, тур агентын гүйцэтгэх үүрэг роль ихээхэн багасч байна. Аялал жуулчлал нэг орноос хальж улам бүр олон улсын шинжтэй улс үндэстэн дамжсан хоршсон үйлчилгээний шинжтэй болж байгаа нь аялал зохион байгуулах, жуулчдаас бүтээгдэхүүн үйлчилгээ худалдан авах, үнэ бүрдэлтийн хүчин зүйлд өөрчлөлт орох шалтгаан болж үүнийг дагалдаад аяллын өртөг хямдрах хандлагатай байна.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний хүний нөөцийг сайн төлөвлөхгүй бол жуулчдад тэр бүр хүрч үйлчлэж чадахгүй байдал үүснэ.	3	3	3	Аялал жуулчлалын хүний нөөцийг салбарынхаа хүрээнд сайн бэлдэх, сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулна.
22	Олон улсын туршлагаас харахад Орон нутгийн аяллын эдийн засгийн сул тал нь эхний үе шатанд хөгжүүлэх болон маркетингийн их хэмжээний хөрөнгө мөнгө шаарддаг, олон нийтийн үйлчилгээний хэрэгцээг өсгөдөг, ажил эрхлэлт нь бүтэн цагийн биш байх, олон нийтийн хяналт ихэсдэг, тухайн орон нутгийн амьдралын зардал өсөх эрсдэлтэй.	Үйлчилгээний хэрэгцээ өсөх нь ажилчдын цагийн ачаалал нэмэгдэнэ, тухайн орон нутгийн амьдралын зардал өсөх эрсдэлтэй.	3	2	2.5	Аялал жуулчлалын улирлыг уртасгах, эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулах хөтөлбөр боловруулна..
23	Олон улсын туршлагаас харахад Орон нутгийн аяллын нийгэм, соёлын сул тал нь орон нутгийн уламжлалт хэвшил, заншилтай зөрчилдөх, гэмт хэргийг нэмэгдүүлэх, хүмүүс олноор цугларч түгжрэл үүсгэх, тухайн нутаг орны чухал эх үүсвэр, нөөцийг ашигласнаас иргэд, жуулчдын хооронд зөрчил үүсэх, аялал жуулчлалын ашиг шимийг иргэдэд тэгш хуваарилаагүйгээс иргэд хооронд зөрчил үүсэх эрсдэлтэй.	Эзэн соёл зочин соёлын хооронд зөрчил үүсэх эрсдэлтэй.	3	3	3	Үйл ажиллагааны төлөвлөлтийг сайн зохион байгуулах, Аялал жуулчлалын ашиг шимийг иргэдэд тэгш хувиарлах дүрэм журам боловсруулна.
24	Олон улсын туршлагаас харахад Орон нутгийн аяллын байгаль орчны сул тал нь төлөвлөөгүй, хэт ихэссэн аялал болон жуулчдын биеэ авч явах байдал нь тухайн	Тухайн байгалийн орчин, түүхэн дурсгалт газрын орчныг доройтуулах				Түүхэн дурсгалт газар болон байгалийн нөөц

	байгалийн орчин, эсвэл түүхт газар орчныг доройтуулах шалтгаан үүсгэх, чимээ шуугиан бохирдол, хог хаягдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.	шалтгаан үүсгэх, чимээ шуугиан бохирдол, хог хаягдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.	4	3	3.5	газруудыг эзэнтэй болгож ашиглаж хамгаалах ажлыг зохион байгуулна.
Экологи, байгаль орчин						
25	Монгол орны газар нутаг гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай.	Уур амьсгалын эрс тэс байдал нь жуулчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй..	4	4	4	Улирлын чанартай аяллын төрлүүдийг хөгжүүлэх, маркетингийг төлөвлөх, хөтөдбөр боловсруулна.
26	Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, богино, хуурай зун, ихээхэн хүйтэн, урт өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой учраас 4 улирлын аялал жуулчлал хөгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй.	Аялал жуулчлалын улиралд жуулчдын ачаалал ихсэх, бусад улиралд орлого хомсдох эрсдэлтэй.	3	3	3	Аялал жуулчлалын улирлыг уртасгах, олон төрлийн эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах хөтөлбөр боловсруулна.
27	Жуулчны үйлчилгээний байгууллагад хийсэн байгаль орчны үнэлгээнд “ажилчид, амрагчид хог хаягдлыг ил задгай шатааснаар агаар орчин бохирдуулах” байгаль орчны болзошгүй сөрөг нөлөөтэй хэмээн үзжээ.	Агаар орчны бохирдол үүсэх эрсдэлтэй.	5	3	4	Хог хаягдалын асуудлыг цогцоор нь шийдэх төлөвлөгөө боловсруулна.
28	Жуулчны үйлчилгээний байгууллагад хийсэн байгаль орчны үнэлгээнд “хаягдал бохир усыг хөрсөнд хамгаалалтгүй шууд шингээж хөрс бохирдуулах” байгаль орчны болзошгүй сөрөг нөлөөтэй хэмээн үзжээ.	Хаягдал бохир усыг хөрсөнд хамгаалалтгүй шууд шингээж хөрс бохирдуулах	5	4	4.5	Жуулчны баазын үйлчилгээний стандартыг сайжруулах, хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтыг сайжруулах дүрэм боловсруулна.
29	Жуулчны үйлчилгээний байгууллагад хийсэн байгаль орчны үнэлгээнд “ахуйн гаралтай хатуу хог хаягдал, барилгын хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрсөнд нөлөөлөх” байгаль орчны болзошгүй сөрөг нөлөөтэй хэмээн үзжээ.	Орчны бохирдол үүснэ. Байгаль орчны доройтол үүсэх эрсдэлтэй.	4	4	4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө блоовсруулна.
30	Жуулчны үйлчилгээний байгууллагад хийсэн байгаль орчны үнэлгээнд “ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд гүний	Аялал жуулчлалын байгууллагууд хөрсний усыг хязгааргүй	3	3	3	Гүний усыг ахуйн болон үйлчилгээний хэрэгцээнд

БОТЬ II-СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

	ус ашиглах нь гүний усны нөөцөд нөлөөлөх” байгаль орчны болзошгүй сөрөг нөлөөтэй хэмээн үзжээ.	ашигласнаар сөрөг нөлөө үзүүлнэ.				ашиглах заавар зөвлөмж боловсруулна.
31	Жуулчны үйлчилгээний байгууллагад хийсэн байгаль орчны үнэлгээнд “зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, үргээх, нүүдэллэх боломжийг хязгаарлах, зөвшөөрөлгүй ан хийх” байгаль орчны болзошгүй сөрөг нөлөөтэй хэмээн үзжээ.	Жуулчны хэт төвлөрөл амьд амьтны амьдрах орчныг хязгаарлах эрсдэлтэй.	4	3	3.5	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгохоосоо өмнө сайн судлаж төлөвлөлт хийнэ..
32	“Тусгай хамгаалалттай газар нутаг аялал жуулчлал явуулах журам”-ын долдугаар бүлэгт заасанчлан ТХГН-т үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд хязгаарлагдмал нөхцөлд үйл ажиллагаа явуулах буюу хориглох заалтуудтай байдаг.	Хуулийг зөрчсөнөөр байгаль орчин,биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлнө.	3	3	3	Хууль дүрмийн танилцуулга, хэрэгжилт, хяналтыг сайжруулах, ажиллах орон тоог нэмэгдүүлэх шийдвэр гаргана.
Хэрэглэгч, зах зээлийн орчин						
33	Ирж буй нийт жуулчдын дийлэнх нь хувиараа аялалаа зохион байгуулж ирдэг бол үлдсэн цөөхөн хувь нь багц аялалын үйлчилгээг сонгож байна.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний чанар буурна. Хэрэглэгч үйлдвэрлэгчийн зөрүү үүснэ.	4	3	3.5	Салбарын бодлого тодорхойлох, аялал жуулчлалын компаниуд бүтээгдэхүүн үйлчилгээгээ төлөвлөж зар сурталчилгаа, маркетинг сайжруулах
Өрсөлдөгчийн орчин						
34	Орон нутгийн хилийн боомтын нэвтрүүлэх цэг үйлчилгээний шаардлага хангадаггүй, ажлын цаг богино	Хэрэглэгчээ алдах магадлалтай.	2	2	2	Бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах, бүс нутгийн хүрээнд хөтөлбөр боловсруулах, тусгай хамгаалалтай газрын тухай хуулийн хүрээнд хөтөлбөр боловсруулах арга замыг хайна.
35	Манай улсад ирж буй гадаад жуулчдын хамгийн их зочилдог газруудыг Тэрэлж, Говь, Монгол Алтай, Хархорин Эрдэнэзуу тэргүүлж байна.	Говь-Алтай аймаг нөөцийн хувьд давуу талтай боловч бүтээгдэхүүн	2	2	2	Говь-Алтай аймаг түүхэн дурсгалт болон байгалийн

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

		төлөвлөлт тааруу нь эрсдэл үүсгэнэ..				нөөцөө сайн төлөвлөж сурталчлах таниулах ажлыг зохион байгууна..
Хамтран ажиллагчийн орчин						
37	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлэгийн үйлчилгээг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаатай уялдуулж жуулчдад эрүүл мэндийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэх чиглэлээр хамтын ажиллагаа өрнүүлэх, сайжруулах шаардлагатай.	Жуулчны үйлчилгээний байгууллагууд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай уялдаа холбоо тааруу.	4	2	3	Салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах хамтран ажиллах журам боловсруулна.
38	Говь- Алтай аймагт ажиллаж буй үүрэн холбооны операторууд бүгд зөвхөн аймгийн төвд үндсэн салбаруудтай бөгөөд сумдад зөвхөн нэгж зарах, хугацаа сунгах агентуудтай ажилладаг тул жуулчид аялж байгаа сумаасаа үүрэн холбооны чанартай үйлчилгээ авахад хүндрэлтэй байна.	Орон нутагт зарим газарт утасны сүлжээ байхгүй нь эрсдэлтэй.	3	2	2.5	Үүрэн холбооны компаниуд үйл ажиллагааных аа цар хүрээг сайжруулж хамтран ажиллах санал гаргана..
39	Жуулчдын тоог нэмэгдүүлэхэд бэрхшээл учруулж буй гол шалтгаануудын 1 нь олон улсын болон орон нутгийн нислэгийн үнэ тарифф билээ. Энэ чиглэлээр Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.	Орон нутгийн нислэгүүдийн тоо цөөн	5	4	4.5	Орон нутгийн нислэгийг нэмэгдүүлэх, Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтын ажиллагааг сайжруулна.
Удирдлага, менежмент						
40	Аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлт дутмагаас аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын үнэ тариф харилцан адилгүй, үйлчилгээний нэгдсэн стандарт, жишиг тогтоогүй.	Төлөвлөлтгүй аялал жуулчлал явагдаж байна.	5	3	4	Аялал жуулчлалын бодлого төлөвлөлтийг сайжруулах, стандарт нэвтрүүлнэ.
42	Сумдад өөр өөрсдийн онцлогийг илэрхийлсэн аялал жуулчлалын брэнд, бүтээгдэхүүн бий болгох, түүгээрээ дагнан хөгжүүлэх, нийтэд сурталчлах үйл ажиллагаа дутагдаж байна.	Бие биенээсээ ялгарах бүтээгдэхүүн байхгүй.	4	4	4	Орон нутгийн онцлогийг илэрхийлсэн аялал жуулчлалын брэнд, бүтээгдэхүүн бий болгоно
43	Нэгдсэн байдлаар сумдын аялал жуулчлалын нөөцийг тогтоосон аялал жуулчлалын нөөцийн мэдээллийн сан байхгүй.	Аяллын бүтээгдэхүүний орц тааруу байна.	5	4	4.5	Жуулчлалын нөөцийг бий болгох, аялал жуулчлалын нөөцийн мэдээллийн сан бүрдүүлнэ.

Хүснэгт 12. Гадаад орчны эрсдэлийн үнэлгээний матриц

Нөлөөлөл	Давтамж /1-5 оноо/					
	5	4	3	2	1	
Далайц	5	17,29,40,41,43,	,28,			
/1-5 оноо/	4	9,16,18,25,30,42,	7,11,13,15,23,33,	10,36,37,38,		
	3	6,12,	3,4,8,19,22,26,31,32,39,	1,21,		
	2		2,	5,20,34,35,		
	1					

Дээрх хүснэгтээс харвал:

Гадаад орчны эрсдэлийн үнэлгээ нь нийт далайц /хор хөнөөлийн зэрэглэл/-ийн **38.2%** нь их нөлөөтэй-их хохиролтой, **32.5%** нь дундаж нөлөөтэй- дундаж хохиролтой, **17,2%** нь бага нөлөөтэй- бага хохиролтой. **12.6%** нь маш их нөлөөтэй- маш их хохиролтой гэж тус тус үнэлэгдсэн байна. Нийт далайц хор хөнөөллийн зэрэглэл нь **3,47** гэж үнэлэгдсэн байна

Харин давтамж /цаг хугацааны зэрэглэл/-ыг харвал 41,8% нь дундаж илрэц-дундаж давтамжтай, **30,2%** нь их илэрцтэй- их давтамжтай, 24,9% нь бага илэрцтэй гэж тус тус үнэлгээ гарсан байна. Нийт **давтамжаар 2,95** гэж үнэлэгдсэн. Гадаад орчны эрсдэлийн нийт үнэлгээ нь **3,29** гэж үнэлэгдсэн байна.

1.2.5.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Байгууллагын дотоод орчны шинжилгээ нь тухайн байгууллагын орц буюу бүх төрлийн нөөцүүд, зохион байгуулж буй үйл ажиллагаа, гарц буюу бүтээгдэхүүн, үйлчилгээ, удирдлага, зохион байгуулалт, менежментийн чадамж зэрэг ойлголтуудыг хамарч тодорхойлогддог.

ДОТООД ОРЧНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 13. Дотоод орчны эрсдэлийн матриц

№	СУЛ ТАЛ	ҮҮСЭХ ЭРСДЭЛ	Далайц 0-5	Давтамж 0-5	ҮНЭЛ ГЭЭ	ЗӨВЛӨМЖ
1.	Газарзүйн байршлын хувьд Улаанбаатар хот болон аялал жуулчлал хөгжсөн бүс нутгуудаас алслагдсан байдал нь сул тал болж байна.	Цаг хугацаа, орон зай болон эдийн засгийн хувьд сул тал болох талтай.	4	3	3.5	Дэд бүтцийн хөгжлийг сайжруулах хамтран ажиллагааны гэрээ байгуулж ажиллана.
2.	Орон нутгийн хилийн боомтын нэвтрүүлэх цэг үйлчилгээний шаардлага	Хил орчмын аялал жуулчлалыг				Хил хамгаалах ерөнхий газар, Тусгай хамгаалалттай

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

	хангадаггүй, ажлын цаг богино байдаг нь сөрөг нөлөө үзүүлэ байна.	хөгжүүлэхэд сөрөг нөлөөтэй.	4	2	3	газрын захиргаатай хамтран ажиллаж тусгай сонирхолын аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулна.
3.	Дэд бүтэц, эрчим хүч сайн хөгжөөгүй нь аялал жуулчлалын үйл ажиллагаа хөгжихөд таагүй нөлөө үзүүлдэг.	Аялал жуулчлалын үйл ажиллагаа өргөнөөр хөгжих боломж бүрдэхгүй.	3	3	3	Олон улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар дэ бүтцийг хөгжүүлэх санал санаачлага гаргана.
4.	Гадаад, дотоодын жуулчдад бүрэн танигдаагүй, тус аймгийн талаарх мэдээлэл хомс, танилцуулга сурталчилгаа хангалтгүй.	Өрсөлдөгчдөд зах зээлээ алдах эрсдэлтэй.	3	3	3	Орон нутгийг сурталчлах, олон улсын болон дотоодын үзэсгэлэн яармагт тогтмол оролцдог байна.
5.	Аялал жуулчлалын хувьд бусад аймгуудтай таталцал бага, хамтарсан аяллын хөтөлбөр дутагдалтай. Харилцаа хамтын ажиллагаа сул байна.	Харилцаа хамтын ажиллагаа дутагдсанаар бүсдээ хөгжлөөр хоцрох эрсдэл үүснэ.	2	2	2	Хөрш аймгуудтайгаа хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулна.
6.	Аялал жуулчлалын зах зээлийн багтаамж бага, тэлэх боломж хомс байна.	Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас олох орлого багасна.	3	3	3	Эвент арга хэмжээнүүдийг тогтмол хийнэ.
7.	Аймаг, сум орон нутаг доторх авто замын сүлжээ муу хөгжсөн, голлох аялал жуулчлалын үзмэрүүд авто замаар холбогдоогүй хоорондоо холбогдоогүй;	Аялал жуулчлалын үйл ажиллагаа өргөнөөр хөгжих боломж бүрдэхгүй	3	2	2.5	Олон улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар дэ бүтцийг хөгжүүлэх санал санаачлага гаргана.
8.	Жилийн турш аялал жуулчлалын олон төрлийг хөгжүүлэхэд, цаг агаар, уур амьсгалын нөхцөл хүнд, аялал жуулчлалын үйл ажиллагаа явагдах хугацаа бага байна.	Аялал жуулчлалын үйл ажиллагаа өргөнөөр хөгжих боломж бүрдэхгүй.	3	3	3	Улирлын онцлогт тохирсон эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулна..

БОТЬ II-СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

9.	Орон нутгийнхан аялал жуулчлалын талаар эерэг, сөрөг нөлөөллийн талаарх ойлголт байхгүй, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцоо сул хандлагатай.	Аялал жуулчлалаас олох орлого хомсдоно.орон нутгийн хөгжилд сөрөг нөлөөтэй.	2	2	2	Нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа зохион байгуулна.
10.	Үйлчилгээний стандарт хангасан жуулчны бааз, гэр буудал, амралтын газрууд цөөн;хөгжүүлэх бодлого тааруу харагдаж байна.	Байршуулах хэрэгслийн чанар сул, жуулчдын тоон өсөлтөд шууд нөлөөлнө.	3	3	3	Стандарт хангасан жуулчдын баазуудыг дэмжиж ажиллах журам гаргана.
11.	Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.	Аялал жуулчлалын үйл ажиллагаанд шууд сөрөг нөлөө үзүүлнэ.	4	2	3	Мэргэжлийн болон түр сургалтуудын хөтөлбөр боловсруулж сургалтуудыг шат дараатай зохион байгуулна.
12.	Бүх талын ашиг сонирхол, үнэт зүйлсэд нийцүүлсэн аялал жуулчлалын хөтөлбөр, стратегийн төлөвлөгөө байхгүй.	Аялал жуулчлал системтэй хөгжихгүй сул тал үүсгэнэ.	4	2	3	Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулна.
13.	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул /төрийн байгууллагын дарамт ихтэй, татварын хөнгөлөлт байхгүй, орон нутгаас дэмжих бодлого байхгүй.	Хувийн хэвшил зах зээлийн зарчмаар хөгжих боломж бүрдэхгүй.	2	3	2.5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулна.
14.	Аяллын замналын тэмдэг тэмдэглэгээ, үзмэрүүдийн дэргэд тайлбар байхгүй.	Цаг хугацаа, орон зайн хувьд эрсдэл үүснэ.	3	2	2.5	Аяллын маршрутын дагуу тэмдэг тэмдэглэгээ байрлуулна.
15.	Аялал жуулчлалын зах зээлийн судалгаа, хөгжил сул, жуулчдын эрэлтэд тулгуурласан аяллын маршрут байхгүй.	Аялал жуул зохистой хөгжихөд сөрөг нөлөөтэй.	3	4	3.5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулна.
16.	Аяллын газарт аялагчдын тав тухтай байдлыг хангах автомашины зогсоол, амрах цэг, ариун цэврийн байгууламж, хог хаях цэг байхгүй.	Аялагчдын тав тух алдагдах, байгаль орчиндсөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.	2	3	2.5	Аялал жуулчлалын бүс нутагт мөрдөх аяллын дүрэм журам боловсруулна.
17.	Стандартын шаардлага хангасан, хүчин чадал сайтай хоол үйлдвэрлэл, зоогийн газрууд байхгүй.	Жуулчдын сэтгэл ханамжид сөрөг нөлөөтэй, жуулчны үйлчилгээний	4	3	3.5	Жуулчны зэрэглэлд нийцсэн тав тухтай хоол үйлчилгээний

		стандарт алдагдана.				стандартыг нэвтрүүлнэ.
18.	Жуулчдад зориулсан үзвэр үйлчилгээ, урлаг, гар урлалын үйлдвэрлэл зэрэг аялал жуулчлалын дагалдах үйлчилгээ сайн хөгжөөгүй.	орон нутгийн төсөвт, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тааламжтай байдал үүсэхгүй.	3	3	3	Жуулчдад үйлчлэх мэдээлэл, үйлчилгээ, худалдааны төвийг байгуулна.
19.	ТХГН-т нэвтрэх цэг тодорхойгүйн улмаас хураамжийг бүрэн хураан авч чаддаггүй.	Тусгай хамгааалалттай газар нутгийн эдийн засгийн чадавхд сул тал бий болно.	4	3	3.5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулна.
20.	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, нөхөн сэргээх санхүүжилтийн эх үүсвэр дутмаг байдаг.	Түүх соёлын дурсгалт зүйлс хаягдаж үгүй болох эрсдэлтэй.	5	4	4.5	Аймгийн болон сум орон нутгийн зүгээс бодлого боловсруулна.
21.	Байгальд ээлтэй түр буудаллах газар байхгүй, майхантай аялж буй дотоодын аялагчдыг бүрэн хянаж чадахгүйгээс байгаль орчинг бохирдуулж байна.	Баягаль орчны доройтол үүсэх эрсдэлтэй.эдийн засгийн хувьд хохиролтой.	4	2	3	Аялагч жуулчдад зориулсан түр отоглох байр бий болгож журам боловсруулна.
22.	Хог хаягдлын менежментийн тогтолцоо тааруу, нэвтрүүлэх шаарлагатай.	. Байгаль орчны доройтол үүсэх эрсдэлтэй.	5	3	4	Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.
23.	Нутгийн иргэд аялал жуулчлалаас орлого олох үйл ажиллагааг орон нутгийн зүгээс дэмжлэг байхгүй, сургалт зохион байгуулдаггүй;	Нутгийн иргэдийн амжиргаа, санхүүгийн чадавх сайжрахгүй	4	2	3	НИТАЖ-ыг дэмжсэн бодлого боловсруулж хамтран ажиллана.
24.	Аялагч жуулчдад мэдээллээр хангах аялал жуулчлалын мэдээлийн төв байхгүй.	Аялагч жуулчдад мэдээлэл авах, мэдээллээр хангагдах нөхцөл бүрдэхгүй.	4	2	3	Аймагт жуулчдад зориулсан жуулчдын гудамжийг бий болгох, худалдаа үйлчилгээний цэг, мэдээллийн төвүүдийг барьж байгуулна.
25.	Жуулчны үйлчилгээний газрын төлөвлөлт болон үйлчилгээ тааруу байдаг.	Хоол үйлчилгээний чанар зэргээс шалтгаалж аялалд өгөх жуулчны үнэлгээ буурна. Жуулчны тав тух, сэтгэл ханамжийн түвшинд сөргөөр нөлөөлнө.	3	4	3.5	Жуулчны стандартыг дагаж мөрдөх, газар, хоол үйлчилгээ авто зогсоолын газруудыг цогц байдлаар төлөвлөнө.

БОТЬ II-СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

26.	Нутгийн онцлогыг харуулсан бренд бүтээгдэхүүн олж авахад төвөгтэй.	Аймгийн онцлогыг харуулсан ялгарал үүсгэх боломжгүй.	3	4	3.5	Жуулчдад үйлчлэх мэдээлэл, үйлчилгээ, худалдааны төв байгуулна.
27.	Жуулчны стандартад нийцсэн цөөн тооны зочид буудалтай, хүрэлцээ хангалтгүй.	Жуулчдын тав тух, жуулчдын тоон өсөлтөд шууд сөргөөр нөлөөлдөг.	4	3	3.5	Жуулчны стандартад нийцсэн зочид буудал, жуулчны баазыг шат дараатайгаар барьж байгуулна.
28.	Аяллын тухай олон нийтийн сүлжээнд маркетингийн мэдээлэл, сурталчилгаа тааруу байна.	Жуулчид, аялагчид мэдээлэл олж авч чадахгүй байдал үүсдэг.	3	3	3	Аймгийн зүгээс маркетингийн төлөвлөгөө боловсруулна.
29.	. Түүх соёл, хөшөө дурсгалт зүйлсийн хадгалалт, хамгаалалт тааруу, анхаарал хандуулалт муу байдаг.	Аялагч жуулчдын сэтгэл ханамж, бодож байсан төсөөлөлд хүрэхгүй аялал нурах асуудал үүснэ.	4	3	3.5	Орон нутгийн зүгээс түүхэн дурсгалт зүйлсээ бүртгэлжүүлэх, хадгалалт хамгаалалтан д нутгийн иргэдийг хамруулж ажиллуулах журам гаргана.
30.	Аймгийн хувьд аялал жуулчлал хөгжүүлэх нэгдсэн бодлого одоогоор байхгүй байна.	Аялал жуулчлал системтэй хөгжихгүй сул тал үүсгэнэ.	3	3	3	Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулна.
31.	Аялал жуулчлалын болон гадаад хэлний чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг байдаг.	Аялал жуулчлалын үйл ажиллагаанд шууд сөрөг нөлөө үзүүлнэ.	4	2	3	Мргэжлийн болон түр сургалтуудын хөтөлбөр боловсруулж сургалтуудыг шат дараатай зохион байгуулна.
32.	Байгальд ээлтэй жуулчны бааз, үзмэрийн газар, дэд бүтцийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана;	Хөрөнгө оруулалт, зардлаа нөхөх эрсдэлтэй, цаг хугацаа их шаардах талтай	4	4	4	Хувийн хэвшлийнхэн ажиллах, хөрөнгө оруулалт оруулахад боломжит нөхцлөөр хангах, дэмжих бодлого гаргана.

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

33.	Байгалийн гамшиг (ган, зуд гэх мэт) тохиолдох магадлалтай.	Байгалийн эрс тэс байдал, байгаль цаг уурын гэнэтийн тохиолдлууд аялал жуулчлалд шууд эрсдэл үүсгэдэг.	5	2	3.5	Эрсдэлийг тооцох, эрсдэлийг даван туулах төлөвлөгөө боловсруулна.
34.	Тээврийн хэрэгсэл болон хүмүүсийн хэт бөөгнөрлийн улмаас байгалийн даац хэтрэх аюултай;	Байшалв орчинд, малын бэлчээрт сөрөг нөлөөлөл, эрсдэл үүснэ	4	2	3	Эрсдэлийг тооцох, эрсдэлийг даван туулах төлөвлөгөө боловсруулна
35.	Жуулчдын урсгал нэмэгдсэнээр зэрлэг ан амьтан дайжих асуудал тавигдаж байна.	Жуулчдын болон жуулчны баазуудын хэт төвлөрөл бий болсноор ан амьтдын амьдрах орчинд сөргөөр нөлөөлнө.	4	3	3.5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулна
36.	Жуулчны баазуудаас гарах хатуу, шингэн хаягдал нь байгаль орчныг ямар ч хяналтгүйгээр бохирдуулах байдал байна.	Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх, хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй.	5	2	3.5	Жуулчны баазын стандарт хангуулах, хог хаягдлыг менежментийг боловсруулна.
37.	Аялал жуулчлалын бүх талын оролцоог хангахгүй, нэгдсэн бодлого хэрэгжихгүй байна.;	Аялал жуулчлалын үйл ажиллагаа жигд, тогтмол явагдахгүй үл ойлголцлууд гарах магадлалтай.	2	2	2	Харилцаа хамтын ажиллагааны гэрээ байгуулна.
38.	Нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого хэрэгжүүлэхгүй бол зах зээлийг алдах магадлалтай.	Нутгийн иргэдийн оролцоо багасах хандлагатай.	3	3	3	НИТАЖ-ыг дэмжсэн бодлого боловсруулж хамтран ажиллана
39.	Аялал жуулчлалын салбарыг мэргэжлийн хүн удирдахгүй бол алдаа гарах	Удирдлагын арга барил дутагдах магадлалтай	4	2	3	Аялал жуулчлал хариуцсан мэргэжлийн бүтэц бий болгох бодлого гаргана.
40.	Орон нутгийн иргэдэд аялал жуулчлалын сургалтыг урьдчилж явуулахгүй бол буруу чиглэлд хөгжиж болно.	Аялал жуулчлалын үйл ажиллагаанд шууд сөрөг нөлөө үзүүлнэ.	3	3	3	Мэргэжлийн болон түр сургалтуудын хөтөлбөр боловсруулж сургалтуудыг шат дараатай зохион байгуулна.

Хүснэгт 14. Дотоод орчны эрсдэлийн үнэлгээ

Нөлөөлөл	Давтамж /1-5 оноо/				
	5	4	3	2	1
Далайц	5				
/1-5 оноо/	4	32,	1,17,19,27,29,35,	2,5,11,12,21,23,24,31,34,39,	
	3	15,20,25,26,	3,4,6,8,10,18,22,28,30,38,40	7,14,	
	2		13,16,	9,37,	
	1				

Дээрх хүснэгтээс харвал:

Дотоод орчны эрсдэлийн үнэлгээ нь нийт далайц /хор хөнөөлийн зэрэглэл/-ийн **42.5 %** нь их нөлөөтэй-их хохиролтой, **42.5%** нь дундаж нөлөөтэй- дундаж хохиролтой, 7,5 % нь бага нөлөөтэй- бага хохиролтой. **5%** нь маш их нөлөөтэй- маш их хохиролтой гэж тус тус үнэлэгдсэн байна. Нийт далайц хор хөнөөллийн зэрэглэл нь **3,4** гэж үнэлэгдсэн байна

Харин давтамж /цаг хугацааны зэрэглэл/-ыг харвал **47,5%** нь дундаж илрэц-дундаж давтамжтай, **12,5%** нь их илэрцтэй- их давтамжтай, **40%** нь бага илэрцтэй гэж тус тус үнэлгээ гарсан байна. Нийт давтамжаар **2,7** гэж үнэлэгдсэн. Гадаад орчны эрсдэлийн нийт үнэлгээ нь **3,02** гэж үнэлэгдсэн байна.

1.2.5.3. ЭРСДЭЛИЙН ХАРИУ ҮЙЛДЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Эрсдэлийн удирдлага нь эрсдэлийг таних, тодорхойлох, үнэлэх, хариу үйлдлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах гэсэн чиг үүргээр хэрэгжиж байдаг. Говь-Алтай аймгийн бодлогын бичиг баримт боловсруулах ажлын хүрээнд аялал жуулчлалын үйл ажиллагаанд шууд ба шууд бус нөлөөлөх микро макро орчны шинжилгээ хийх, дотоод орчны судалгааг гүйцэтгэж, орчны нөхцөл байдалд үнэлгээ өгч боломж, бэрхшээл, давуу болон сул талуудыг тодорхойлох, нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр нэгдсэн дүгнэлт гаргаж ДБ, СБ, ДА, СА стратегиудын шийдлийг тодорхойлох зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Судалгааны баг судалгааны арга зүйн хувьд бодлогын орчинд баримтын судалгаа, асуумж судалгаа, процессийн шинжилгээ, Гар шинжилгээ, Вилсоны матриц, асуудал шалтгааны шинжилгээ, мексоны шинжилгээ, экспертийн шинжилгээ, SWOT шинжилгээ, Нөлөөллийн үнэлгээний арга, CROSS SWOT шинжилгээ, Эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ зэргийг ашиглаж түүвэр судалгаа, ажиглалт судалгаа болон харьцуулан жиших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэсэн. Судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэнээр аймгийн төлөв байдалд нарийвчилсан шинжилгээ, оношлогоо хийх, үнэлгээ өгөх, удирдлагын шийдвэр гаргах, бодлогын бичиг баримт боловсруулахад

тус дөхөм болохуйц суурь мэдээллүүд нэгтгэгдэж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан болно.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын эрсдэл нь динамик эрсдэлийн ангилалд багтана. Динамик эрсдэл гэж нийгмийн өөрчлөлтийн үр дүнд бий болдог, мөн нийгмийн өөрчлөлтийг бий болгодог эрсдэл орно. Эрсдэлийн үнэлгээний нэг гол арга зүй нь экспертийн үнэлгээ бөгөөд тус стратегийн баримт бичиг нь задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг өргөн ашигласан. Эрсдэлийн үнэлгээгээр харьцангуй дундаж нөхцөл байдалтай байна гэж үзлээ.

1.2.5.4. Эрсдэлийн үнэлгээний нэгтгэл

Хүснэгт 15. Эрсдэлийн үнэлгээний нэгтгэл

№	АЮУЛ БЭРХШЭЭЛ, СУЛ ТАЛ	Далайц	Давтамж	ҮНЭЛГЭЭ
	Гадаад орчны эрсдэлийн дундаж үнэлгээ	3.47	2,81	3.09
	Дотоод орчны эрсдэлийн дундаж үнэлгээ	3.4	2,7	3.02
	Эрсдэлийн нэгдсэн дундаж үнэлгээ	3.43	2,75	3.05

Хүснэгтээс үзвэл: Аймгийн гадаад орчны болон дотоод орчны эрсдэлийн үнэлгээ нь дунджаас дээгүүр эрсдэлтэй буюу 3.05 гэсэн оноогоор илэрхийлэгджээ. Гадаад орчны эрсдэл нь 0.68 оноогоор дотоод орчны эрсдлээс илүү байна.

1.2.5.5. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалд хэрэгцээтэй менежмент

Хүснэгт 16. Менежментийн хэрэгцээ

МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛҮҮД		Тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа	Бүтээн байгуулалтад чиглэсэн үйл ажиллагаа	Хөгжүүлэх үйл ажиллагаа	НИЙТ
3.1	Чадамжийн удирдлага	1		4	5
3.2	Хүнийн нөөцийн удирдлага			2	2
3.3	Суралцагч байгууллагын удирдлага				
3.4	Мэдлэгийн удирдлага			4	4
3.5	Зөрчилдөөний удирдлага				
3.6	Авъяасын удирдлага				
3.7	Ур чадварын удирдлага			2	2
3.8	Стрессийн удирдлага				
3.9	Хувь хүний удирдлага				
3.10	Уур уцаарын удирдлага				
3.11	Карьерын удирдлага				
3.12	Багийн менежментийн удирдлага				
3.13	Гомдлын удирдлага				
	НИЙТ	1		12	13


1.2.5.6. Хяналттай холбоотой нэвтрүүлэх менежментүүд

Хүснэгт 17. Хяналттай холбоотой нэвтрүүлэх менежментүүд

МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛҮҮД	Тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа	Бүтээн байгуулалтад чиглэсэн үйл ажиллагаа	Хөгжүүлэх үйл ажиллагаа	НИЙТ
4.1	Засаглалын удирдлага		2	2
4.2	Бүтээмжийн удирдлага			
4.3	Гүйцэтгэлийн удирдлага	1	1	2
4.4	Чанарын удирдлага	2	5	7
4.5	Санхүүгийн удирдлага		1	1
4.6	Өртөг зардлын удирдлага		1	1
	НИЙТ	3	10	13

Төслийн стратегийн хүрээнд ажлын явцыг дараах загвараар удирдан явуулна.

Зураг 21. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөлтийг хэрэгжүүлэх төслийн ажлын явцын загвар



Түүнчлэн төсөл хэрэгжих явц дунд төсвийн зарцуулалт болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн зөрүүг олон улсын стандартын дагуу дараах аргачлалуудаар тооцон харуулна.

Зураг 22. Төсөл хэрэгжих явц дунд төсвийн зарцуулалт болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн олон улсын стандарт

PPR Бүтээгдэхүүн төлөвлөлтийн зам	RAM үнэлгээ Эрсдлийн үнэлгээний
PV Төлөвлөгдсөн үр дүн.	BCWS Ажлын хуваарийн төсөвлөгдсөн
EV Анхны үр дүн	BCWP Гүйцэтгэлийн төсөвлөгдсөн
AC Зарцуулагдсан төсөв	ACWP Ажлын гүйцэтгэлд зарцуулсан
BAC Хаалтын төсөв	CPI Зардлын гүйцэтгэлийн индекс
SPI Хуваарийн гүйцэтгэлийн индекс	EAC Хаалтын тооцоолол
ETC Тоонооллыг хаахТ	TCPI Гүйцэтгэлийн хаалтын

Цагийн менежментийг дараах загвараар боловсруулж MS-Project программаар гүйцэтгэв.

Зураг 23. Цагийн менежментийн загвар



1.2.6. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аливаа бүс нутгийн аялал жуулчлал өсөхийн зэрэгцээ хог хаягдал нэмэгдэж, үүнийг зайлуулах асуудал тулгарч ирдэг. Үүнийг шийдвэрлэх хамгийн том алхам бол иргэдийн хог хаягдлын талаарх боловсролд онцгой анхаарах явдал юм.

Иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх:

-Хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр ангилан ялгаж, гарах хог хаягдлын хэмжээг багасгах ажиллагааг дэмжин, хог хаяхгүй байх болон хог ангилан ялгах талаар сургалт

сурталчилгааны ажлыг явуулах,

-Хог хаягдлын талаар батлагдсан хууль, журам, эрх зүйн баримт бичгийг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар сурталчлах

-Энгийн болон аюултай хог хаягдлын талаар иргэд олон нийтэд үнэн, зөв мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулах;

Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих;

Хог хаягдлыг төрөлжүүлэх:

Хог хаягдлыг багасгах зорилгоор анхнаас нь хогийг төрөлжүүлж хаях суурийг тавьж өгөх нь маш чухал байдаг.

-Ялзарч муудах хоолны үлдэгдэл (эдгээрийг ялзмагжуулж, бордоо хийж болно)

-Дахин ашиглаж болох зүйлс: (цаас, шүлтлэг, ус, шар айрагны лааз, лонх)

-Хорт бодис (хуванцар, бензин, тос гэх мэтээр ялгаж тэмдэглэнэ)

Хог хаях бүх цэгүүдийг маш сайн цэвэрлэж, зориулалтын савуудыг байршуулсан байх ёстой. Хогийг зориулалтын цэг рүү хүргэж хаяхаас гадна норж нуурын эрэг рүү урсан оруулахгүйн тулд бетонон тавцан хийж өгнө. Мөн өнгө өнгийн дахивар хог хаягдлын савыг байрлуулж, заавар самбаруудыг хадсан байна. Хог цэвэрлэх хөлсийг зочид гийчдээс авах төлбөр болон хувийн түрээслэгч нараас авах татвараас төлнө. Хог хаягдлыг тухайн бүсийн хил хязгаараас аль болох алсуулж хаях бөгөөд ойрхон байрлах сумын хогийн цэг хаях, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг тус байгууллагад нь өгнө.

Хог хаягдлыг цуглуулах , тээвэрлэх үйл ажиллагааг сайжруулах

Аймгийн аялал жуулчлалын салбарын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажиллагааг сайжруулахын тулд хог хаягдлыг зайлуулах тээврийн хэрэгслийг сонгон шалгаруулна. Түүнийг санхүүжүүлэх, үйлчилгээний хураамж төвлөрүүлэхэд мөрдөх журмыг боловсруулан батлуулна. Тээвэрлэх цагийн хуваарийг гаргаж, хяналт тавьж ажиллана. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу нэг иргэнээр тооцон шинэчлэн батлах ажлыг зохион байгуулна.

Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах

Ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг зохион байгуулна. Цаашид хог боловсруулах жижиг үйлдвэр барих тооцоог гарган, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллана.

Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем

Байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын цогцолбор барихад тухайн бүс нутгийг хамгаалан ойр орчмын газруудад зөвшөөрөлгүй байгууллахгүй байх талаар аймгийн стратегийн бодлогоор хамгаалуулах нь зөв юм. Учир нь олон жижиг төлөвлөөгүй байгууламж баригдах нь эмзэг хөрсийг гэмтээх, талхлах, замбараагүй байдал бий болгох аюултай.

- Ойр орчинд олон зам гаргаж хөрсийг эвдлэхгүй байхын тулд паркийн бүс нутагт орох үед санамж бичиг, гарын авлага өгөх бөгөөд албан ёсны зам талбайгаар зорчоогүй бол торгууль ногдуулдаг байх

- Ойр орчмын бүх талбайд сайжруулсан, засмал зам болон явган хүний, дугуйн зам тавих, хогийн цэгүүдийг олноор байгуулах, саравч сүүдрэвч хийх
- Хогийг тухай бүр нийтийн хогийн цэгт ачуулах, хаях
- Машин угаахыг хориглох
- Бохир усыг тогтмол бохирын системд нийлүүлэх
- Тухайн бүсд буудаллаж буй майхантай аялагчдад тусгай зөвшөөрөл өгөх, тэдний хог хаягдал, хөрсний бохирдол зэргийг цэвэрлүүлэх зэрэг арга хэмжээг тогтмол авах
- Аяллын бүс нутагт шувуу агнах, ургамал түүхийг хориглох
- Шувуу, амьтдыг үргээхгүйн тулд дуу чимээг багасгахад анхаарах
- Гол усанд шууд орох, угаалгын бодис ашиглан юм угаахыг хориглох, гол, ус, нуурын биологийн төрөл зүйлд сөрөг аюул учруулахгүй байх
- Гол, ус, нуурын орчим эко жорлон, хогийн савуудыг 500 метрээс хол зайд байршуулах шаардлагатай

Ашиглах дүрэм журам, Засгийн газрын тогтоолын жагсаалт

-Жагсаалт батлах тухай, /Монгол Улсад ашиглахыг хязгаарласан болон хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт/ 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн Газрын 95 дугаар тогтоол

- “Усыг бохирдуулсанд нөхөн төлбөр ногдуулах журам” БОХУХ-ны 1992 оны 06 дугаар тогтоол

-“Хаягдал ус зайлуулах цэг тогтоох тухай”, БО-ны ДБХ-ийн, ЭМ-ийн сайдын 1995 оны 167/335/а 171 дүгээр хамтарсан тушаал

-“Ахуйн бохир усны цоонгийг доторлох ашиглах журам” БО-ны, ЭМ-ийн сайдын 1995 оны 169/171 дүгээр тушаал

- “Бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх үйлдвэрийн бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээ” БО-ны, ДБХ-ний, ЭМНХ-ын сайдын 1997 оны а/11/05/а/18 дугаар хамтарсан тушаал

- Аюултай хог хаягдлын ангилал, зэрэглэл батлах тухай БО-ны сайд, ЭМ-ийн сайд, БСШУ-ы сайд 2006 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 324/318/336 тоот тушаал

-Ангилал батлах тухай /Химийн аюултай бодисын ангилал/ - БОАЖ-ын сайд, ЭМийн сайдын 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 04/04 дугаар хамтарсан тушаал

- “Хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” БОАЖ-ийн сайд, ЭМ-ийн сайд, ОБЕГ даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын хавсралт

- Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журам, ЭМНХ-ын сайдын 2000 оны 33 тоот тушаалын хавсралт

Аяллын бүс нутагт байгаль орчинд сөрөг нөлөөг бууруулах

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулах бөгөөд ус ашиглалт, хог хаягдлын зохицуулалт, бохир усны асуудлыг оновчтой шийдвэрлэн нутгийн иргэдтэй хамран хэрхэн сайн ажиллаж буй байдлаас нь голлон шалтгаална. Тиймээс нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бий болгож нийлүүлэлтийн зарим зүйлийг ихэнхийг нь орон нутгаас худалдан авна.

1. Цэвэр ус ашиглалт

Тухайн орчныхоо гадаргын болон газрын доорх усны нөөцийг судлан үзэж, үүн дээр үндэслэн усны хэрэгцээг тогтооно. Нэг жуулчинд хоногт оногдох халуун хүйтэн болон,

хэрэглээний ус, ундны ус зэргийг нарийвчлан гаргах эндээс хэмнэж болох аргыг аль болохоор эрж хайхаар авах болно.

2. Бохир усны ашиглалт

Жуулчдын болон бусад ахуй хэрэгцээнээс гарах бохир усыг нарийн тооцож гаргах

1. Бохир усны шүүн цэвэршүүлэх
2. Шууд байгальд, хөрсөнд шингэж болох
3. Үлдсэн ялзмагийг тусгай бодисоор задалж түүнийгээ хөрсөнд бордоо болгон ашиглах арга замыг хайна.
4. Орчин үеийн шинэлэг шийдлүүдийг нэвтрүүлнэ.

3.Түлш эрчим хүчний хэрэгцээнд байгаль орчинд халгүй технологийг ашиглах

Тухайн баазын оршин буй бүс нутгийн нар, салхи, шатдаг хийг ашиглан эрчим хүчний нөөцийг зөв тодорхойлсны үндсэн дээр эрчим хүчний нийт ашиглалтын 20 хувь хүртэл дээрх эх үүсвэрүүдээс ашиглах.

- Өдрийн цагаар болон бусад онц шаардлагагүй үед илүүдэл эрчим хүч ашиглах үйл ажиллагаанд хязгаарлалт хяналтыг нэвтрүүлэх;
- Жуулчдын хэрэгцээ шаардлагыг хангах эрчим хүчний ашигтай зарцуулалт бүхий тоног төхөөрөмжийг ашиглах;
- Жижиг оврын цахилгаан үүсгүүрийг ашиглах тохиолдолд хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө, дуу чимээ, хорт утаа зэргийг тооцож үүнийг багасгах болон бууруулах арга хэмжээ авсан байна
- Цахилгаан үүсгүүрийн дуу чимээ нь жуулчид, болон нутгийн оршин суугчид, шувуу, амьтанд сөрөг нөлөө, үзүүлж зөрчилдөөн үүсгэхгүйгээр зохицуулсан үр дүнтэй арга хэмжээ авах зэргийг төлөвлөнө.

Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх ажил

Хорт болон аюултай бодисын тухай хуулийн 8.1-д “Иргэн аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлнэ”, хуулийн 13.6-д “ААН, байгууллага нь химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагчдад аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх болон анхны тусламж үзүүлэх сургалтын өөрийн зардлаар зохион байгуулна”, хуулийн 12.3-т “Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцан ажиллагч нь тухайн бодисын бодисын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг, дадлагатай байна”, хуулийн 15.1-т “Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй” гэж тус тус заасан байдаг.

Хорт бодис бүхий ажлын орчин нь химийн бодисын **алдагдал, асгаралт үүсэх эрсдэлийг** хамгийн бага байлгахад чиглэсэн арга хэмжээг шалгаж тодорхойлсон байх шаардлагатай. Химийн бодисын алдагдал нь хадгалалт, тээвэрлэлт, шилжүүлэлт, ашиглалт болон устгалын үйл ажиллагааны явцад тохиолддог. Тиймээс хадгалж буй шүүгээ нь бат бөх болон хэт олон бодис дүүртэл хадгалсан зэргийг шалгана. Бат бөх чанарыг нэмэгдүүлэх зориулалтаар химийн бодисын шүүгээ нь хана болон шаланд сайтар бэхлэгдсэн эсэхийг шалгана. Химийн бодис нь лабораторид ажиллаж буй хүн бүр хүрэхэд хялбар өрөгдсөн байх ёстой. Харааны түвшинөөс дээгүүр байрлуулж болохгүй. Том лонх болон савтай бодис нь аль болох шалны төвшинтой ойр хадгалагдсан байх

ёстой. Бодистой савыг хэрэв стандартыг хангасан сав, эсвэл тээвэрлэлтийн савлагаатайгаа байгаа үеээс бусад тохиолдолд шууд шалан дээр байлгаж болохгүй, гэмтэх асгарах бусдын хөлд үрэгдэх эрсдэлтэй. Том, хүнд эсвэл олон тооны савлагаатай химийн бодис тээвэрлэх үед ачиж буулгахдаа ачиж буулгахад авсаархан тэрэг болон асгарсан үед ашиглах цэвэрлэгээний иж бүрдлийг бэлэн байлгана. Их хэмжээтэй химийн бодисыг зөөхөд хоёр болон түүнээс дээш хүн оролцох хэрэгтэй. Шилэн савнуудыг лонх зөөвөрлөгч болон бусад алдагдлаас хамгаалах нэмэлт савтай нь зөөнө. Нийтийн эзэмшлийн зам талбайгаар **аюултай ачаа тээвэрлэхдээ холбогдох дүрэм журмыг чандлан сахина**. Том савнаас шингэн бодис авахдаа асгахгүйн тулд насос, шахуурга болон бусад механик хэрэгсэл ашиглана. (Амаараа сорж болохгүй). Шингэн бодис шилжүүлэн ачих явцад асгаралт алдагдлыг зогсоох алдагдлын үеийн иж бүрдэлийг хэрэглэнэ. Шатамхай шингэнийг торхноос юүлэх үед дэлбэрэлт болон оч алдаж үүсэх эрсдлээс зайлсхийн бүх торхнууд гадаргуу дээр тэгш, хамтдаа байрласан байх ёстойг хатуу анхаарах ёстой. Энэ ашиглах, тээвэрлэх дүрэм журмыг хатуу мөрдсөнөөр хөрсөнд хортой бодис алдагдах аюул багасах боломжтой.

Онцгой байдалд ажиллах арга хэмжээний ажил

Аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй барилга байшинд болон ойр орчимд байгалийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг удирдах, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах, батлуулах, тодотгох, хянаж ажиллана. Эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Гамшгийн голомтод ажиллах мэргэжлийн ангийн тактикийн сургуулилтыг зохион байгуулах, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний гамшгаас урьдчилан сэргийлэх чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна. Мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх саналыг боловсруулж, паркийн удирдлагад танилцуулах, гүйцэтгэх үүргийг тодорхойлох, нөөц бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа гаргаж, хангах асуудлыг шийдвэрлүүлнэ. Онцгой байдал илэрсэн тохиолдолд өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх, санаачлага гаргах, шаардлагатай үед тухайн нөхцөл байдалд тохируулан зөв шийдвэр гаргаж хэрэгжүүлж ажиллана. Мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажиллах нөхцлийг бүрдүүлж, байнгын бэлтгэл байдалтай байна. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгнө.

Аймгийн онцгой байдлын мэргэжлийн анги нь дараах шуурхай бүлгийн бүтэц, бүрэлдэхүүнтэй байх бөгөөд мэргэжлийн ангийг дарга түүний эзгүйд орлогч буюу гамшгийн үеийн удирдлагын томилогдсон дарга удирдан зохион байгуулна. Үүнд:

1. Удирдлага, нөөц хангалтын бүлэг: Бүлэг удирдлага, нөөц хангалтын хэсгээс бүрдэн бүлгийг газрын дарга ахлан, удирдлагын хэсгийг мэргэжлийн ангийн дарга, нөөц хангалтын хэсгийг нөөц хангалтын ажилтан ахлан, бусад томилгоот гишүүдээс
2. Аврах, эрэн хайх бүлэг: Бүлэг аврах, эрэн хайх хэсгээс бүрдэн бүлгийг сэргээн босголтын асуудал хариуцсан ажилтан ахлан, бусад томилгоот гишүүдээс,
3. Аюулгүй ажиллагаа, гал унтраах бүлэг: Бүлэг аюулгүй ажиллагаа, гал унтраах, хэв журам сахиулах хэсгээс бүрдэн бүлгийг аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан ахлан, хэв журам хариуцсан ажилтан бусад томилгоот гишүүдээс,
4. Сургалт сурталчилгааны бүлэг: Бүлэг сургалт сурталчилгаа, зарлан мэдээллийн хэсгээс бүрдэн бүлгийг сургалт сурталчилгааны ажилтан ахлана, зарлан

мэдээлэх хэсгийг холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан ахлан бусад томилгоот гишүүдээс,

5. Анхны тусламжийн нөхөрлөл: Нөхөрлөл нь анхны тусламжийн нөхөрлөл, зөөвөрлөх хэсгээс бүрдэн эмнэлэгийн яаралтай тусламж хариуцсан ажилтан ахлан, бусад томилгоот гишүүдээс тус тус бүрдэнэ.

1.2.6.1. Аялал жуулчлалын үйл ажиллагааны стандарт

Монгол улсын хэмжээнд нийт 5900 орчим стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй оролцогч талуудад хамгийн өндөр нөлөөлөлтэй 10 стандарт байна.

Хүснэгт 18. Аялал жуулчлалын үйл ажиллагааны стандарт

№	Стандартын дугаар	Стандартын нэр, тэмдэглэгээ
1	MNS 5824 - 2007 3x	Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага
2	MNS 5409 - 2004 4x	Чөлөөт цаг. Аялал жуулчлал. Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо
3	MNS 6426 - 2013 10x	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
4	MNS 6043 - 2009 7x	Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага
5	MNS 4934 - 2002 12x	Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага
6	MNS 4588 - 2008 9x	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ -Зочид буудалд тавих ерөнхий шаардлага
7	MNS 4946 - 2005 16x	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага
8	MNS 5231 - 2003 3x	Жуулчны авто тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага
9	MNS ISO 14001 - 2016 34x	Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар
10	MNS ISO 14015 - 2002 20x	Байгаль орчны удирдлага (менежмент) – Байрласан газар ба байгууллагын талаарх байгаль орчны үнэлгээ (БББОУ)
11	MNS 5851: 2008	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ, дүрэмт хувцас. Ерөнхий шаардлага Хамрах хүрээ Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулагдаж буй бүх ангиллын тусгай хамгаалалттай газарт энэхүү стандартыг мөрдөнө.

Монгол улсын аялал жуулчлалын салбарын стандартчлалыг судалж үзвэл манай улсын аялал жуулчлалын салбарыг бүрдүүлэгч аж ахуйн нэгжүүд болох амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, рестораны барилга, орчин нөхцлийн ерөнхий шаардлага тал уруугаа стандартууд түлхүү боловсруулагдаж батлагдсан байдаг нь дээрх жагсаалтаас харагдаж байна. Харин аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг олон улсын түвшинд түлхүү өсгөж чадах үйлчилгээ, ажиллах хүчний стандартууд дутмаг байгаа нь цаашид анхаарах шаардлагатай хууль эрх зүйн орчны томоохон бэрхшээл болон харагдаж байна.

1.2.6.2. Ус болон ариун цэврийн байгууламжийн стандартууд

Хүснэгт 19. Ус болон ариун цэврийн байгууламжийн стандартууд

№	Стандартын дугаар	Стандартын нэр	Тайлбар
1	MNS 5924: 2015	Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага	Хамрах хүрээ Төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын ахуйн хэрэгцээнд хэрэглэх зориулалттай нүхэн жорлон, угаадасны нүхний зураг төсөл зохиох, барьж ашиглах, хяналт тавихад энэхүү стандартыг мөрдөнө.
2	MNS 6279 : 2011	Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томьёо, тодорхойлолт – Тайлбар толь	Хамрах хүрээ Энэхүү стандарт нь ус хангамж, ариун цэврийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээнд хамаарах нэр томьёо, тодорхойлолтыг тогтооход хамаарна. Үүнд: а) нэр томьёо, тодорхойлолтыг илүү нарийн болгоход үндэслэх суурь ойлголт өгөх, б) ус хангамж, ариун цэврийн байгууламжийн салбарт “Мянганы Хөгжлийн Зорилт (МХЗ)”-ын хэрэгжилтэд үнэлгээ өгөх ба хуулийн нэр томьёо, тодорхойлолтыг боловсруулах зэрэгт нарийвчилсан суурь ойлголт болох. Нэр томьёог дотор нь: ашиглалт, үйлчилгээний төрлөөр нь ангилж бүлэглэсэн ба бүлэг бүрийн нэр томьёог цагаан толгойн үсгийн дарааллаар байршуулж индексжүүллээ.
3	MNS 4586-1998	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага	Хамрах хүрээ Энэхүү стандарт нь хүний эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор усан орчны чанарын шаардлагыг тогтооход хамаарна.
4	MNS EN 12566-1-5 багц стандарт : 2011	50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж 1-р хэсэг. Угсармал септик	Хамрах хүрээ Энэхүү стандарт нь угсармал болон газар дээр нь угсарсан, 50 хүртэл хүн амын ахуйн (зочид буудал, олон нийтийн барилга) бохир усыг цэвэрлэх байгууламжийг турших, стандартчилах, стандартын тохирлыг шалгахад тавигдах тусгай шаардлагыг тогтооход хамаарна.
5	MNS 4943 : 2015	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага	Хамрах хүрээ Энэхүү стандарт нь ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэглээнээс гарсан хаягдал усыг хүрээлэн байгаа орчинд нийлүүлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна. 2.2 Уг стандартыг хүрээлэн байгаа орчинд хаяж зайлуулах хаягдал устай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавихад мөрдөх ба ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөр тогтоох үндэс болно.

6	MNS 4288 : 1995	Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага	Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага
7	MNS 3342 : 1982	Байгаль орчны хамгаалал, усан мандал, газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага	Хамрах хүрээ Энэ стандарт нь газрын доорхи усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлагыг тогтооно.
8	MNS EN 12255-1-15 :2012 багц стандарт	Бохир ус цэвэрлэх байгууламж. 1-р хэсэг: Байгууламжийн ерөнхий зарчмууд	Хамрах хүрээ Энэхүү стандарт нь оршин суугчид ба эквивалент хүн амын нийт тоо нь 50-аас дээш үед ашиглах бохир ус цэвэрлэх байгууламжийн хийц, тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлагыг тогтооно. Хот суурин газрын болон ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжид голчлон хэрэглэнэ. Бохир ус цэвэрлэх байгууламжид хамаарахгүй барилга, байгууламжид тавигдах шаардлагыг энэхүү европын стандартаар тогтоохгүй бөгөөд бусад EN стандартыг ашиглах нь зүйтэй. Зөвхөн бохир ус цэвэрлэх байгууламжид тусгайлан зориулагдаагүй тоног төхөөрөмжүүдийн хувьд тухайн бүтээгдэхүүнд хамаарах стандартыг мөрдөнө. Гэхдээ тэдгээр тоног төхөөрөмжийг бохир ус цэвэрлэх байгууламжид ашиглахад тавигдах тусгай шаардлагуудыг энэхүү стандартад зааж өгсөн. Энэхүү стандартад барилгын, механикийн болон цахилгааны ерөнхий зарчмууд нь хамаарахгүй. Энэхүү стандартад цэвэрлэгээний технологийн сонголт хамаарахгүй. Европын хэмжээнд бохир ус цэвэрлэгээний олон янзын хувилбарыг ашигладаг бөгөөд системийг тус бүрт нь боловсруулсан байдаг. Энэхүү стандарт нь тэдгээр системүүдийн талаарх үндсэн мэдээллийг өгөх зорилготой бөгөөд бүх системийг тодорхойлох зорилгогүй. Энэхүү стандартад тусгаснаас бусад системийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг номзүйд заасан материалуудаас авах боломжтой.

1.2.6.3. Барилга байгууламжинд шаардлагатай стандартуудын жагсаалт¹

Хүснэгт 20. Стандарт болон норм дүрмийн жагсаалт

д/д	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1	БНБД 31-03-03	Олон нийт иргэний барилга.
2	БНБД 23-02-08	Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг
3	MNS 5021: 2007 5 х.	Худалдааны газар түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага
4	MNS 6506: 2015 6 х.	Худалдааны үйлчилгээ. Худалдааны газрын ангилал, нэр томьёо
5		
6	MNS 5364: 2011 8 х.	Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага
7	MNS 4598: 2011	Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага
8	MNS 5342: 2007	Автомашинь зогсоол
9	MNS 5537: 2016	Автозам дагуух үйлчилгээний цогцолборын ангилал
10	MNS 5343: 2011 7 х.	Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
11	MNS 5344: 2011 5 х.	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
12	MNS 6592: 2016 12 х.	Авто замын төлбөр хураах цэг. Ерөнхий шаардлага
13	MNS 4968:2000.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага;
14	MNS 5738:2007 6 х.	Дэн буудал. Ерөнхий шаардлага
15	MNS 6314:2012 48 х.	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хэрэглэх дохио тэмдэг, төрөл загвар, нэр томьёо, тодорхойлолт, суурилуулах ба байрлуулах
16	MNS 4191: 1993 2 х.	Байгаль орчин хамгааллын стандартын систем. Монгол орны уур амьсгал. Үндсэн үзүүлэлт
17	MNS 5851: 2008 23 х.	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ, дүрэмт хувцас. Ерөнхий шаардлага
18	MNS CAC RCP 1:2003,	Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим,
19	БНБД II-80-85	Нийтийн хоолны газар
20	MNS 3757-15:2015	Барилгын зураг. Барилгын зураг төслийн тогтолцоо. Ерөнхий журам /цогц стандарт/
21	БНБД – 40-06-16 2	Цэвэр, бохир ус, болон дулааны шугам хоолойн байрлал, угсралт
22	MNS 6055: 2009	Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин үндсэн шаардлага,
23	MNS 5283: 2014 5 х.	Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага
24	MNS 4100: 1990 9 х.	Барилгын дулаан техникийн нэр томьёо тодорхойлолт.
25	MNS 5386: 2004 46 х.	Чанарын удирдлагын тогтолцоо- Шаардлага MNS ISO 9001:2001 стандартыг барилга угсралтын байгууллагад хэрэглэх заавар
26	MNS ISO 9000: 2017 88 х.	Чанарын менежментийн тогтолцоо. Үндсэн ойлголт ба тайлбар толь
27	MNS OHSAS 18001: 2012 41 х.	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо. Шаардлага

¹ <https://mcis.gov.mn/main/norm>

28	MNS ISO 22000: 2007 62 х.	Хүнсний аюулгүй байдлын удирдлага-Хүнс үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавих шаардлага
29	MNS 5323 багц: 2012	Дээд боловсролын мэргэжлийн стандарт
30	БНБД 3.02.01-90	Барилгын ул хөрсний зондчиллын ажил
31	БНБД 3.02.05-89	Барилгын газар шороо ба суурь, суурийн ажил
32	СНиП 3.02.01-87	Кемпьяные сооружение
33	БНБД 51-05-05	Өрөг бүтээц
34	БНБД 52-05-05	Цутгамал бетон, төмөрбетон бүтээц
35	БНБД 52-03-05	Угсармал бетон, төмөрбетон бүтээц
36	БНБД 53-04-05	Ган бүтээц
37	БНБД 54-02-05	Модон бүтээц
38	БНБД 31-07-05	Дээврийн ажил
39	БНБД 31-08-05	Дуу, дулаан тусгаарлалтын ажил
40	БНБД 31-09-05	Шалны ажил
41	БНБД 31-10-05	Заслын ажил
42	БНБД 33-03-05	Голын гидротехникийн барилга байгууламж
43	БНБД 3.07.03-89	Мелиорацийн барилга байгууламж
44	БНБД 3.01.06-90	Барилгын орчмын тохижилтын ажил
45	БНБД 3.05.06-90	Цахилгаан техникийн ажил
46	БНБД 3.05.07-85	Автоматжуулалтын систем
47	БД 43-101-03	Цахилгаан байгууламжийн дүрэм
48	БД 43-102-07	Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах
49	БНБД 3.05.01-88	Дотор сантехникийн систем
50	БНБД 3.05.04-90	Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж
51	БД 40-102-06	Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах үндсэн журам,
52	БНБД 44-02-08	Төв /магистраль/ дамжуулах хоолойн угсралт
53	БНБД 3.05.05-89	Технологийн тоног төхөөрөмж дамжуулах хоолой
54	БНБД 3.05.03-95	Дулааны шугам сүлжээ
55	СНиП III.Г10.4-67	Дулааны эрчим хүчний төхөөрөмж, ажил гүйцэтгэх ба хүлээн авах журам
56	БД 41-101-08	Халаалтын системийн металл, полимер хоолой төлөвлөх ба угсрах
57	БНБД 42-02-04	Хийн хангамжийн угсралт
58	БНБД40-01-06	Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж
59	MNS EN 12975-1 :2012 12 х.	Нарны дулааны тоног төхөөрөмжийн систем ба иж бүрдэл. Коллекторууд 1-р хэсэг: Ерөнхий шаардлага
60	MNS EN 12975-2 :2012 106 х.	Нарны дулааны тоног төхөөрөмжийн систем ба иж бүрдэл. Коллекторууд 2-р хэсэг: Турших арга
61	MNS ISO 7345: 2011 9 х.	Дулаан тусгаарлалт. Физик хэмжээс ба тодорхойлолтууд
62	MNS ISO 9346: 2011 16 х.	Барилга, барилгын материалын чийг дулаан дамжуулалт. Масс солилцооны нэр томьёо, тодорхойлолт. Тайлбар толь
63	MNS ISO 9229 :2010 30 х.	Дулаан тусгаарлах материал. Нэр томьёо, тодорхойлолт
64	91.010	Барилгын үйлдвэр ²
65	93.010	Иргэний байгууламжийн нийтлэг асуудал ³

² <http://www.estandards.gov.mn/admin/editors/spaw2/uploads/files/MON-CAT2018.01.03.pdf> стандартын жагсаалтаас 91.010 барилгын үйлдвэр бүлэг стандартыг харах

³ <http://www.estandards.gov.mn/admin/editors/spaw2/uploads/files/MON-CAT2018.01.03.pdf> стандартын жагсаалтаас 93.010 иргэний байгууламжийн бүлэг стандартыг харах


Хүснэгт 21. Үйлчилгээний технологи буюу олон улсын стандартууд

№	Тэмдэглэгээ	Стандартын нэр
1	ISO 21101:2014	Адал явдалт аялал жуулчлал – Аюулгүйн зөвлөмж – Үндсэн шаардлага
2	ISO/AWI 21902	Нийтэд зориулсан аялал жуулчлалд хамаарах үйлчилгээ – Үндсэн шаардлага ба санал зөвлөмж
3	ISO 18065:2015	Тусгай хамгаалалттай газарт нийтийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх – Үндсэн шаардлага
4	ISO 13810:2015	Аялал жуулчлалын үйлчилгээ - Үйлдвэржилтийн аялал жуулчлал
5	ISO 17679:2016	Аялал жуулчлалын үйлчилгээ – Спа – Үйлчилгээний шаардлага
6	ISO 13009:2015	Аялал жуулчлалын үйлчилгээ – Далайн эргийн аялал жуулчлалд тавих үндсэн шаардлага, санал зөвлөмж
7	ISO/TR 21102:2013	Адал явдалт аялал – Манлайлагчдын ур чадвар
8	ISO/TS 13811:2015	Аялал жуулчлалын үйлчилгээ – Байрлах хэрэгслийг барихад байгальд ээлтэй элементүүд хэрэглэх нь
9	ISO 18513:2003	Аялал жуулчлалын үйлчилгээ – Зочид буудал болон бусад төрлийн байрлах хэрэгслүүд- Нэр томъёо
10	ISO 21103:2014	Адал явдалт аялал – Мэдээлэл өгөх нь
11	ISO/AWI 22483	Адал явдалт аялал – Байрлах хэрэгсэл: Зочид буудал – Үйлчилгээний шаардлага.
12	ISO 14785:2014	Аялал жуулчлалын мэдээллийн төв – Жуулчинд мэдээлэл өгөх ба угтатвар үйлчилгээ – Үндсэн шаардлага
13	ISO/DIS 20611	Адал явдалт аялал – Сайн туршлагауд – Үндсэн шаардлага ба санал зөвлөмж
14	ISO 17680:2015	Tourism and related services – Thalassotherapy – Service requirements
15	ISO 20121:2012	Арга хэмжээний удирдлагын тогтолцоо – Үндсэн шаардлага ба гарын авлага
16	ISO 31000:2009	Эрсдэлийн удирдлага – Зарчмууд ба гарын авлага
17	<u>CSN EN 13809</u>	Tourism services - Travel agencies and tour operators - Terminology
18	<u>CSN EN 15565</u>	Tourism services - Requirements for the provision of professional tourist guide training and qualification programmes
19	ISO 50001	Эрчим хүчний удирдлагын тогтолцоо
20	ISO 14001	Байгаль орчны удирдлагын тогтолцоо
21	ISO 9001	Чанарын удирдлагын тогтолцоо
22		Global Code of Ethics for Tourism – Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан.

1.3. МАРКЕТИНГ ТӨЛӨВЛӨГӨӨ


1.3.1. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРКЕТИНГИЙН БОДЛОГО

Говь- Алтай аймгийн аялал жуулчлалыг Jafar Jafari болон Brent Ritchie нарын онолын дагуу тодорхойлогдсон бөгөөд энэ онол нь аялал жуулчлалын үйл ажиллагааг иж бүрнээр харж төлөвлөх үйл явц байдаг.



Зураг 24. Ж.Жафарын загвар

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг системийн хувьд иж бүрэн тодорхойлогдсон болно.



Зураг 25. Системийн загвар

1.3.1.1. МАРКЕТИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Говь-Алтай аймгийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд таниулах, тэднийг татах хүрээнд дараах зорилго, зорилтуудыг тавьж байна. Үүнд:

Зорилго 1: Говь-Алтай аймгийн аяллын жуулчлалын 3- н бүсийг жишиг бүс болгох.

Зорилтууд:

1. Байгалийн аялал жуулчлалын үйлчилгээний стандартад нийцсэн бүс болгон зарлах;
2. Говь-Алтай бренд аялал, эвенттэй болох;
3. Хүн бүр Говь-Алтай аймгаар заавал аялах ёстой гэсэн хоногшуулалтыг иргэдийн далд ухамсарт суулгах.

Зорилго 2: Говь-Алтай аймгийг “Нэг аяллаар хамгийн олон үзэсгэлэнт газруудаар аялах, олон эвент арга хэмжээнд оролцох” зорих газар болгох.

Зорилтууд:

1. “Хамгийн хамгийн” жишиг маршрут, эвентийн хөтөлбөр боловсруулах;
2. Маршрут, хөтөлбөрийг баяжуулах.

Зорилго 3: Ээж хайрхан, Хар Азрага, Алаг Хайрхан, Говийн Их Дархан Газар А, Б Монгол Элс, Бурхан Буудай, Хасагт Хайрхан, Шарга Манхан, Аж Богд, Сутай хайрхан зэрэг газруудад байгалийн зураг авалтын гол цэгүүдийг бий болгох.

Зорилтууд:

1. Зураг авалтын хамгийн оновчтой цэгүүдийг сонгож фото цэгүүдийг байгуулах
2. Байгаль болоод хүнийг хослуулсан зураг авалтын сонирхолтой, хөгжилтэй, классик санаануудын жагсаалт боловсруулах;
3. Говь-Алтай аймгийн аялал ба эвент үйл ажиллагаанд хүмүүсийн үзүүлж буй реакцинийг харуулсан бичлэгүүдийг хийж, олон нийтийн сүлжээгээр цацах;

Зорилго 4: Говь-Алтай аймгийн хүрээлэн буй орчин, эко системийг хамгаалангаа ашиглах ухамсрыг аялагчдад бий болгох.

Зорилтууд:

1. Монголчуудын сүсэг бишрэлээр дамжуулан уул ус, амьтан ургамалыг шүтээнжүүлэх
2. Ховор ан амьтанд хөрөнгө оруулах аялал, эвентийг хөгжүүлэх
3. Аялагчдад эко аялах зөвлөмж тарааж өгөх
4. Аялал жуулчлалын байгууллага бүр журам хэрэгжүүлэх
5. Аль болох аяллын маршрутыг ан амьтан, ургамлыг хөндөхгүйгээр төлөвлөх

Хүснэгт 22. Маркетингийн зорилтууд ба тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд

№	Зорилтууд	Шалгуур үзүүлэлт
1	Говь-Алтай аймаг аялал жуулчлалын үйлчилгээний стандартад нийцсэн байгалийн аялал жуулчлалын бүс болох зарлах;	Мэдээлэл хүрсэн хүмүүсийн тоо
2	Говь-Алтай аймаг байгалийн брэнд аялалтай болгох;	брэнд гэж үзэх хүмүүсийн тоо
3	Хүн бүр Говь-Алтай аймаг аймгаар заавал аялах ёстой гэсэн хоногшуулалтыг иргэдийн далд ухамсарт суулгах.	Говь-Алтай аймаг аймгаар заавал аялахыг хүсэх хүмүүсийн тоо
4	“Хамгийн хамгийн” жишиг эвент, маршрут	Говь-Алтай аймаг аймгийн жишиг аяллын талаар мэдээлэлтэй хүмүүсийн тоо
5	Зураг авалтын хамгийн оновчтой цэгүүдийг сонгож фото цэгүүдийг байгуулах	Фото цэгүүдийн тоо
6	Байгаль болоод хүнийг хослуулсан зураг авалтын сонирхолтой, хөгжилтэй, классик санаануудын жагсаалт боловсруулах;	Жагсаалтад багтсан санаануудын тоо
7	Аймгийн аялал ба эвент үйл ажиллагаанд хүмүүсийн үзүүлж буй реакшинийг харуулсан бичлэгүүдийг хийж, олон нийтийн сүлжээгээр цацах;	Реакшин бичлэгүүдийн тоо
8	Монголчуудын сүсэг бишрэлээр дамжуулан уул ус, амьтан ургамалыг шүтээнжүүлэх	Бий болгосон зан үйл, тэдгээрийн талаар мэдээл
9	Ховор ан амьтанд хөрөнгө оруулах аялал, эвентийг хөгжүүлэх	Хөрөнгө оруулсан хүмүүсийн тоо
10	Аялагчдад эко аялах зөвлөмж тарааж өгөх	Тараах материалын тоо
11	Аялал жуулчлалын байгууллага бүр журам хэрэгжүүлэх	Журмын хэрэгжилт
12	Аль болох аяллын маршрутыг ан амьтан, ургамлыг хөндөхгүйгээр төлөвлөх	Маршрутын төлөвлөлт


Бүтээн байгуулалтын ажил хийгдэж дууссаны дараа дээрх зорилго, зорилтуудын хүрээнд жил бүр маркетингийн төлөвлөгөөг үе шаттайгаар боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.3.1.2. Аялал жуулчлалын олон улсын байдал

1) Дэлхийн аялал жуулчлалын тойм

Дэлхий улс орнуудыг хамарсан эдийн засгийн глобалчлал, технологийн дэвшил, бизнесийн шинэ загвар, хөгжиж буй орнуудад нийгмийн дунд анги нэмэгдэж буй байдал, боломжийн үнэтэй аялалууд, визний хөнгөвчлөл зэргээс шалтгаалан олон улсын жуулчдын тоо 2019 онд өмнөх оноос 6%-иар өсөн 1.46 тэрбумд хүрч аялал жуулчлалын салбараас 1.481 тэрбум ам.долларын орлого олжээ. 2019 он хүртэл аялал жуулчлалын салбар нь ДНБ-ний 10%, гадаад худалдааны 7%, үйлчилгээний салбарын 30%, хөдөлмөрийн зах зээл дээрх 10 ажлын байрны 1-ийг бүрдүүлж байлаа.

Зураг 26. Олон улсын жуулчдын тоо болон аялал жуулчлалаас олсон орлого



International tourist arrivals (million) and tourism receipts (USD billion) Data as of November 2020. Source: World Tourism Organization (UNWTO). * Provisional data.

2020 он хүртэл дэлхийн хэмжээнд аялсан нийт жуулчдын тоо бүх бүс нутагт өссөн үзүүлэлттэй гарч Ойрхи Дорнод (+8%) буюу хамгийн өндөр өсөлттэй, удаагаар нь Европ, Ази болон Номхон далайн орнууд (+4%), бусад бүс нутаг бага зэргийн өсөлттэй буюу (+2%)-иар нэмэгдсэн байна. .


Хүснэгт 23. Жуулчдын тооны өсөлт бүс нутгаар

	Өөрчлөлт				
	2016	2017	2018	2019	2009-2019
Дэлхийн хэмжээнд	3.8%	7.2%	5.6%	3.8%	5.1%
Европ	2.5%	8.8%	5.8%	3.7%	4.6%
Ази, Номхон далайн орнууд	7.7%	5.7%	7.3%	4.6%	7.1%
Америк	3.7%	4.7%	2.4%	2.0%	4.6%
Африк	7.8%	8.5%	8.5%	4.2%	4.4%
Ойрхи Дорнод	-4.7%	4.1%	3.0%	7.6%	2.7%

Франц, Испани, АНУ, Хятад, Итали, Турк, Мексик, Тайланд, Герман, Их Британи зэрэг улс жуулчдыг хүлээн авагч тэргүүлэх 10 оронд багтаж байгаад бөгөөд эдгээр улс дэлхийн хэмжээнд аялж буй жуулчдын 40%-ийг хүлээн авсан байна.


Дэлхийн нийт улс орнуудад аялсан жуулчдын 55% нь амралт, чөлөөт цагаараа, 28% нь найз нөхөд, хамаатныдаа зочлох, шашин эмчилгээний зорилгоор, 11% нь албан хэрэг, бизнесийн зорилгоор аялсан байна. Амралт чөлөөт цагаар аялагчдын тоо 2020 онд нийт аялагчдын 50%-ийг эзэлж байна. Тээврийн хэрэгслийн хувьд нийт аялагчдын 59% нь агаарын тээврээр, 35% нь газраар, 5% нь усан замаар, 1% нь галт тэргээр зорчсон байна.

Зураг 27. Жуулчдын аяллын зорилго




Гэвч дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас дийлэнх улс орнууд онцгой дэглэм тогтоон хилээ хааснаар жуулчдын урсгал огцом буурч улмаар аялал жуулчлалын салбар алдагдалд орж эхэлсэн. 2019 онд олон улсын жуулчдын тоо ойролцоогоор 1.5 тэрбумд хүрч байсан бол 2020 онд ердөө 381 сая жуулчин аялж 74%-иар даруй буурсан үзүүлэлт гарчээ /Зураг 3/.

Зураг 28. Жуулчдын тооны өөрчлөлт бүс нутгаар



2019 оноос аялал жуулчлалын салбар үндсэндээ тэг зогсолт хийсэн бөгөөд 2021 оны сүүлээс аажим сэргэх хандлага байгааг ДАЖБ тооцоолон гаргажээ/Зураг 4/.


Зураг 29. Жуулчдын тооны урьдчилсан тооцоо, 2021-2024



Эх сурвалж: ДАЖБ

Бүс нутгуудаар аваад үзвэл Ази болон Номхон далайн орнуудын аялал жуулчлал 2022 онд 57%-иар, 2023 онд 95%-иар сэргэнэ гэсэн тооцоо гарчээ/Зураг 5/.

Зураг 30. Ази болон Номхон далайн орнуудыг аялал жуулчлалын хэтийн төлөв



2. Гадаад өрсөлдөгчийн судалгаа

Монгол орны аялал жуулчлалын зах зээлийн хувьд гадаад өрсөлдөгчийн тоонд Казакстан, болон Өвөр Монголын Өөртөө Засах Орон гэсэн 2 орон зайлшгүй тооцогдож байгаа юм. Эдгээр хоёр орон нь эдийн засгийн хөгжил, газарзүйн байршил, байгаль, түүх, соёлын нөхцөл, ард түмний зан заншил, амьдралын хэв маяг зэрэг олон хүчин зүйлсээрээ Монгол улстай адилавар шинж чанартай гэж үзэн эдгээр хоёр орны аялал жуулчлалын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж үзлээ.


Казакстан улсын аялал жуулчлалын тойм

Казакстан улс нь газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 9-р байрыг эзлэх далайд гарцгүй орны нэг юм. Казакстан улсын аялал жуулчлалын салбар нь 2000 оны эхэн үеэс

эрчимтэй хөгжиж эхэлсэн хэдий ч тухайн орны эдийн засагт маш бага үүргийг гүйцэтгэдэг, 2014 онд аялал жуулчлалаас олсон орлого нь ДНБ-ний дөнгөж 0.3%-ийг бүрдүүлж байжээ. Тус улсын Засгийн Газар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх талаар нэлээдгүй дорвитой ажлуудыг хийсний үндсэн дээр аялал жуулчлалаас олох орлого нь 2018 онд ДНБ-ий 5.7%-ийг бүрдүүлэх болсон байна.

Олон жилийн хугацаанд Казакстан улс нь хүний эрхийг зөрчиж, улс төрийн эсэргүүцлийг дарах замаар түүхэндээ авторитар дэглэмийг тогтоосон гэж тодорхойлогддог Казахын засгийн газар "Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх төлөвлөгөө 2020" нэртэй санаачлага гаргасан билээ Энэхүү санаачлага нь Казахстан, Астана хот, Алмата хот, Зүүн Казахстан, Өмнөд Казахстан, Баруун Казахстан зэрэг аялал жуулчлалын таван кластер байгуулах зорилго тавин ажиллаж 2020 он гэхэд дөрвөн тэрбум долларын хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын салбарт 300 мянган ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөсөн нь аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжихэд гол хөшүүрэг болжээ. Энэхүү санаачлагын үр дүнд гадаадаас ирэх жуулчдын тоо 2000 оноос эрчимтэй өсөж 1996 онд 202,0 мянган жуулчин хүлээж авдаг байсан бол 2019 онд 8,5 сая жуулчин гадаад улс орнуудаас хүлээн авч 2.9 тэрбум ам.дол орлого олсон нь/Зураг 6/ Казакстан улсын экспортын 4%-ийг бүрдүүлж байна.

Зураг 31. Казакстанд ирсэн гадаадын жуулчдын тоо болон АЖ-ын салбарын орлогын хэмжээ



Казакстан улсууд ирж буй жуулчид голдуу хөрж зэргэлдээ Станы орнууд, Зүүн болон Өмнөд Европын орнуудаас ирдэг байна.

Казакстан улсын иргэд гадаад улс орон луу жуулчлах нь 2000 оноос огцом нэмэгдэж 2014 онд 10.2 сая жуулчин гадаад улс орон луу аялнаас 2019 онд Монгол улсад 16,2 мянган жуулчин Казакстан улсаас аялахаар иржээ/Хүснэгт 2/.

Хүснэгт 24. Гадагшаа аялсан Казакстан улсын жуулчид/мян/

	1996	2000	2002	2004	2006	2008	2010	2012	2014	2018	2019
Дэлхийд	523,0	1247,0	2274,0	3915,0	3615,0	4239,0	5893,0	8875,0	10230,0	10646,0	10707,0
Монголд		1,5	1,8	3,1	3,9	5,4	5,7	10,5	13,5	16,4	16,2

2020 онд олон улсын зах зээлд Нүүдлийн соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн-үйлчилгээг трэнд болгож буй Узбекистан, Казакстан улсын эрэлтийг Монгол улстай харьцуулав.


Узбекстан, Казакстан улсын аяллын бүтээгдэхүүн-үйлчилгээг Монголын аялал жуулчлалын зах зээлийн 24 хувийг бүрдүүлж буй ОХУ тэргүүлж байна.

2020												
	Mongolia				Uzbekistan				Kazakhstan			
	Online Searches		GDS Booked Return Passengers		Online Searches		GDS Booked Return Passengers		Online Searches		GDS Booked Return Passengers	
	Origin country name		Origin country name		Origin country name		Origin country name		Origin country name		Origin country name	
1	United States	4.23M	Korea	1.7K	Russia	6.73M	UK	2.93K	Russia	4.96M	Germany	2.52K
2	Korea	2.80M	France	1.54K	United States	1.71M	Germany	944	Germany	3.45M	Russia	1.08K
3	Germany	678K	Germany	475	Germany	1.34M	France	796	United States	2.04M	United Arab Emirates	739
4	France	601K	Italy	265	Korea	912K	Spain	605	UK	762K	Korea	586
5	UK	592K	Russia	203	Japan	897K	Korea	566	Turkey	731K	China	190
6	China	579k	United States	188	China	817K	Russia	563	Korea	728K	Poland	166

Хүснэгт 25. Монголын аялал жуулчлалын зах зээлийн харьцуулалт

ӨМӨЗО-ны улсын аялал жуулчлалын тойм

БНХАУ-ын ӨМӨЗО нь нийтдээ 1.1 сая хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй, 25.2 сая хүн амтай бөгөөд аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын арвин их нөөцтэй Монгол улсын гол өрсөлдөгч орны нэг юм. ӨМӨЗО нь 1999 онд 363.7 мянган гадаад жуулчин хүлээн авдаг байсан бөгөөд энэ тоо жил бүр нэмэгдсээр 2019 онд нийтдээ 1.87 сая гадаадын жуулчин хүлээн авсан байна. Жилийн дундаж өсөлт нь 10.28% байна.



Зураг 32. ӨМӨЗО-д ирсэн гадаад жуулчдын тоо

2017 онд Өвөр Монголын олон улсын аялал жуулчлалаас олсон орлого 1250.0 сая ам.доллар, харин 2019 онд авч 1,340 сая ам.долларын орлого олжээ. 1998-2019 оны хооронд Өвөр Монголын олон улсын аялал жуулчлалын орлого жил бүр нэмэгдэж 130.0-аас 1340.0 сая ам.доллар болж, жилийн өсөлт нь 2019 онд 14.66% болж өсчээ.

Тус орны аялал жуулчлалын салбарт 2017 оны байдлаар нийтдээ 43.5 мянган хүн ажиллаж байгаа тооцоо гарчээ. Түүнчлэн Өвөр монголчууд 2018 онд 1850.0 мян, 2019 онд 1,96 мянган жуулчин гадаад улс орон луу аялсан байна.

Дотоод өрсөлдөгчийн судалгаа

2019 оны 12-р сард БНХАУ-д гарч эхэлсэн шинэ төрлийн Ковид-19 халдвар дэлхий нийтэд маш хурдацтай тархаж цар тахлын хэмжээнд хүрсэн нь улс орнууд хөл хорио тогтоон хилээ хаах, нислэгүүдээ зогсоосноор аялал жуулчлалын салбарт хүнд цохилт болсон билээ. Аялал жуулчлалын салбарын дийлэнх орлого нь гадаадаас ирэх жуулчдын урсгалаас хамаарал ихтэй орнуудын хувьд дотоод аялал жуулчлалыг нэмэгдүүлэх тал дээр дэлхийн улс орнуудын ЗГ болон аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүд ихээхэн анхаарал хандуулж байна.

Нэгэнт олон улсын аялал жуулчлал 2024 он хүртэл сэргэх найдвар бага байгаа үед дотоодын аялагчдыг тандах зорилгоор аяллын ямар төрөлд, хэрхэн хамрагдах төлөвтэй, ямар аймгуудаар аялах төлөвтэй байгааг цахим түүврийн аргаар нийтдээ 1098 хүнээс 2020 онд судалгаа авсан юм. Үндэсний Статистикийн Хорооны мэдээлсний дагуу 2019 онд гадаад улсруу жуулчлах зорилгоор 150 795 Монголчууд зорчжээ. Эдгээр хүмүүс энэ жил гадагш аялах боломж хязгаарлагдмал байгаа тул дотооддоо аялах боломжтой гэж үзэж байна.

Тус судалгаанд хамрагдагсдын хувьд аялах газраа сонгоход хамгийн их нөлөөтэй хүчин зүйлсийг эрэмбэлвэл:

- i. зорих газрын байгалийн үзэмж (89%),
- ii. улсын онцгой байдлын хөл хорио(78%),
- iii. тухайн газрын үзмэр (70%),
- iv. хувийн унаатай байх (68%),
- v. эрүүл мэндийн байдал (62%),
- vi. өрхийн орлого (63%) гэсэн хариултуудыг өгчээ.


Энэхүү судалгаагаар Монголын дотоодын аялагчид хаашаа аялах төлөвтэй байгааг тандахад /Зураг 8/ дотоодын жуулчдын 53% нь Архангай аймагт аялах төлөвтэй байгаа бол Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Завхан аймгуудыг зорих аялагчид судалгаанд хамрагдагсдын 41-47%-ийг бүрдүүлж байна. Олон сонголттой уг асуултад давхардсан тоогоор нийт хүмүүсийн 41-53 хувь нь эдгээр аймгуудыг аялах газраар нэрлэжээ.

Төв, Сэлэнгэ, Увс, Орхон, Дархан-Уул, Хэнтий аймгуудад 31-38% нь аялахаар байна. Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Баян-Өлгий, Дундговь, Ховд, Дорноговь аймгуудад 22-29% нь аялах төлөвтэй байна. Дотоодын жуулчдын анхаарлыг хамгийн бага татаж байгаа газруудад Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр аймгууд багтаж байгаа ба 7-19% -тай байна.

Дотоодын аялагчдын дийлэнх олонхи (87%) нь гэр бүлээрээ аялахаас гадна 5% нь найз нөхөдтэйгөө, ажлын хамт олноороо 12% нь аялах төлөвтэй. Ганцаараа аялах сонирхолтой болон бусад хэлбэрийн аялагчид 6% болон 3% -ийг тус тус эзэлж байна. Иймд жуулчдыг хүлээн авах аймгууд болон аялал жуулчлалын байгууллагууд аялал

жуулчлалын ямар зах зээлд бэлтгэлтэй байх хэрэгтэйг аялагчдын аяллын зохион байгуулалтын хэлбэр харуулж байна.

Зураг 33. Дотоодын аялагчдын аялах чиглэл, аймгуудаар




Судалгаанд оролцогсдын 96% нь аяллаа хувиараа зохион байгуулна гэсэн бол аялал жуулчлалын компаниар болон аяллын клубээр дамжин аялах бүлэг дөнгөж 5% эзэлж байгаа нь Монголчуудын хувьд мэргэжлийн аялал жуулчлалын байгууллагаар дотооддоо үйлчлүүлэх соёл хэвшээгүй, нөгөө талаас яагаад ямар зорилгоор эдгээр үйлчилгээг авах нь тодорхойгүй, зах зээл дээрх бүтээгдэхүүний нэр төрөл цөөхөн байгаатай холбоотой байж болох юм. Газарзүйн байршлын хувьд засмал замтай, хувийн унаагаар явж болох Улаанбаатараас 1000 орчим километрийн тойрогт байгаа Хангайн бүсийн аймгууд зонхилох зорих газрыг бүрдүүлж байна.

Судалгаанд хамрагдагсдын 60% нь 2-7 өдрийн аялал төлөвлөж байгаа бол 8-14 өдрийн аяллаар явах хүмүүс 30%-ийг, хоёроос гурван долоо хоногийн хугацаагаар аялах хүмүүс 6%-ийг, цөөнх (3%) нь 22-с дээш өдрөөр эсвэл 1 өдрийн аялал төлөвлөжээ. Хэдийгээр дийлэнх нь 7 хүртэлх өдрөөр аялахаар төлөвлөж байгаа ч олон өдрийн аяллаар аялах хүсэлтэй хүмүүс 39%-ийг бүрдүүлж байгаа нь Монгол аялагчид илүү урт хугацаагаар аялахад бэлэн байгааг харуулж байна.

Дотоодын аялагчдын 68% нь майхантай аялах сонголтыг хийх гэж байгаа бол боловсон ариун цэврийн байгууламжтай амралтын газар, жуулчны баазад 47% болон 38% нь тухлах сонирхолтой байна. Рашаан сувилалд амрах нь 27%, хамаатан садныдаа байх нь 25%, нутгийн иргэдийн ажиллуулдаг гэр буудалд байх нь 20%-ийг бүрдүүлж байна.

Аяллын төрлүүдээс явган аялал, авто аялал, рашаан эмчилгээ, цагаан идээ хэрэглэх, нутгийн онцлогтой соёлоос суралцах, фото зургийн аялал, ууланд авирах, жимс түүхийг аялагчдын 22-30% нь хийх зүйлстээ оруулжээ/Зураг 9/. Харин аялагчдын 12-19% нь морин аялал, нутгийн онцлогтой хоол идэх, ховор амьтад ажиглах, шавар эмчилгээ хийлгэх, загасчлахыг дурьджээ. Тусгай сонирхолын аяллуудыг цөөн буюу 2-8% нь дурьдаж үүнд мотоцикл, палеонтологи, мөөг түүх, шашин, археологи, шувуу ажиглах, бясалгал, шүхрээр буух гэх мэт аяллын төрөл багтжээ.


Зураг 9. Дотоодын аялагчдын аяллын төрлүүд



Бүс нутгийн өрсөлдөгчийн судалгаа

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн гол үзэл баримтлал нь эдийн засгийн өсөлтийн төвүүд болон таталцлын тэнхлэгүүд, кластерийг бий болгох үүднээс ТХГН-ийн эко системд түшиглэсэн байгаль орчин эдийн засгийн хамтын менежментийг хөгжүүлэхэд оршиж байна. Энэ зорилгын хүрээнд монгол орны аялал жуулчлалын бүс нутгууд нь байгаль, түүх, соёлын нөөцөөс хамааран өөрийн гэсэн өвөрмөц дүр төрх бүхий хэд хэдэн кластеруудад хуваагдаж байна.

Зураг 34. Аялал жуулчлалын бүс нутгийн ялгарал



Баруун бүсийн аяллыг сонгох шалтгаан	<ul style="list-style-type: none"> • Адал явдалт аялал -36% • Угсаатны аялал-19% • Агнуурын аялал-9%
Зүүн бүсийн аяллыг сонгох шалтгаан	<ul style="list-style-type: none"> • Байгальд түшиглэсэн аялал 36% • Нүүдлийн соёлын аялал-19% • Хил орчмын аялал 9%
Говийн бүсийн аяллыг сонгох шалтгаан	<ul style="list-style-type: none"> • Байгальд түшиглэсэн аялал 36% • Паоеонтологийн аялал-19% • Фото сафари аялал 9%
Хөвсгөлийн бүсийн аяллыг сонгох шалтгаан	<ul style="list-style-type: none"> • Байгальд түшиглэсэн аялал-21% • Угсаатан соёлын аялал-21% • Адал явдалт аялал 18%


Монгол орны аялал жуулчлалын бүс нутгууд нь газарзүйн байршил, байгаль, цаг уурын нөхцөл, хүн амын нутагшил, нийгэм эдийн эдийн нөхцөл байдал, дэд бүтэц, зам харилцаа зэрэг олон хүчин зүйлсээс хамааран аялал жуулчлалын хувьд харилцан адилгүй хөгжиж байна /Хүснэгт 24/.

Хүснэгт 26. Бүс нутгуудад аялсан жуулчдын тоо үзүүлэлт/ТХГН-т нэвтэрсэн хүний тоо/

		Баруун	Хангай	Төвийн	Зүүн
Дотоодын	Жуулчдын тоо	32 729	130 226	53 599	10 333
	Эзлэх %	9%	36%	64.9%	2%
Гадаадын	Жуулчдын тоо	2 593	25 037	193 797	2183
	Эзлэх %	3.1%	29.8%	53%	2.2%

Зураг 35. Жуулчдын тооны харьцаа бүс нутгаар

Бүс нутагт аялсан гадаад, дотоодын жуулчдын харьцаа (2019 он)



Хүснэгт 27. Бүсүүдийн жуулчин хүлээн авах хүчин чадал


№	Эдийн засгийн бүсүүд	Зочид буудлын тоо	Жуулчны баазын тоо	Отоглох цэг	Нийт ор хоногийн тоо
1	Баруун бүс	40	54	6	4126
2	Төвийн бүс	163	72	2	9103
3	Хангайн бүс	40	189	12	16734
4	Зүүн бүс	32	43	4	3211
	Нийт	275	368	24	33174

Монгол улсын бүсүүд болон аймаг орон нутагт дотоодын жуулчдаас гадна хөрш зэргэлдээ Хятад улсаас ирэх жуулчид аялал жуулчлалын зах зээлийн тодорхой хэсгийг бүрдүүлж байдаг. Иймээс 2019 оноос өмнө Монгол улсад аялсан нийт 720 хятад жуулчдаас Монгол улсад аялах хугацаанд тухайн аялсан газрын сэтгэл татах байдал, аялал жуулчлалын байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аяллын тав тух зэрэг нь жуулчдын сэтгэл ханамжинд хэрхэн нөлөөлж буй болон дахин Монгол улс руу аялах сонирхол байгаа эсэхийг тодруулах үүднээс асуулга судалгаа авсан болно.

Судалгаанд оролцсон нийт 720 хятад жуулчны дийлэнх нь буюу давхардсан тоогоор 100% нь Төвийн бүс-Улаанбаатарт, 93% нь Төвийн бүс Тэрэлж, 45,9% нь Орхон Хархорины бүсэд, маш цөөхөн жуулчид буюу 6.2% нь Говийн бүсэд, 3.6% нь Баруун бүсэд, 4.4% нь хилийн бүсэд аялсан байна/Зураг 12/. Баруун бүсэд хятад жуулчид маш цөөн тоогоор аялсан байгаа нь дараах хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд:

- Улаанбаатар хотоос хэт алслагдсан
- Хил залгаа орон нутагт ажиллаж буй улирлын чанартай боомтоор жуулчид олноор нэвтрэх боломжгүй
- УБ-аар дамжин ирж буй тохиолдолд аялалд олон өдөр зарцуулагдах болдог
- Аяллын төрөл цөөн
- Жуулчдын хүлээн авах байгууллага цөөтэй
- Сонирхол татах үзэмэр хоорондын зай ихтэй зэрэг болно.

Зураг 36. Хятад жуулчдын Монгол орноор аялсан бүс нутгууд



Монгол орны Баруун бүсээр аялсан нийт хятад 26 жуулчнаас 69.2% нь тухайн зорих газрын байгалийн үзэмрийн үнэ цэн, үзэмрийн төрөл, үзэмрийн онцлогт бүрэн сэтгэл ханамжтай, 50% нь аялахад цаг агаарын хувьд тааламжтай гэж үзжээ /Хүснэгт 26/.

Үйлчилгээтэй холбоотой бүлэг асуултад орон нутгийн бэлэг дурсгал, түүний сонголтод хамгийн өндөр буюу 69.2% болон 42.3% нь бүрэн сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгчээ.

Хүснэгт 28. Баруун бүсээр аялсан хятад жуулчдын үнэлгээ

Үзүүлэлтүүд		(N=720)				
		Бүрэн сэтгэл ханамжтай	сэтгэл ханамжтай	Дундаж	Сэтгэл ханамжгүй	ОГ сэтгэл ханамжгүй
Зорих газрын сэтгэл татам байдал	Байгалийн үзмэрийн үнэ цэн	18	4	4		
	Байгалийн үзмэрийн төрөл	18	2	5	1	
	Байгалийн үзмэрийн онцлог	18	5	2	1	
	Уур амьсгал	18	4	3	1	
	Цаг агаарын тааламжтай байдал	13	8	4	1	
Үйлчилгээ	Хоолны нэр төрөл	11	11	4		
	Хоолны онцлог шинж	7	14	4	1	
	Орон байрны тав тух	4	15	7		
	Орон нутгийн бэлэг дурсгал	18	2	6		
	Бэлэг дурсгалын сонголт	11	8	7		
	Хөтөч тайлбарлагчийн чадвар	10	10	6		
	Тэмдэглэлт үйл явдал	2	17	7		
	Үзвэр үйлчилгээний онцлог	2	17	7		
	Үзвэр үйлчилгээний төрөл	3	16	5	2	
Үзвэр үйлчилгээний үнэ	2	18	5	1		
Тээвэр харилцаа	Тээврийн үйлчилгээ	6	10	9	1	
	Тээврийн төрөл	9	5	11	1	
	Харилцаа холбооны нөхцөл	8	10	7	1	
	Нутгийн иргэдийн найрсаг байдал байдал	13	8	5		
	Аяллын мэдээллийн нэгдсэн систем	12	7	7		
	Замын тэмдэг, тэмдэглэгээ	9	9	8		
	Аяллын талаарх мэдээлэл	10	7	9		

Хоолны нэр төрөл, онцлог шинж хөтөч тайлбарлагчийн ур чадвар зэрэг үзүүлэлтэд 76-84% нь бүрэн сэтгэл ханамжтай, сэтгэл ханамжтай хэмээн хариулсан байна. Харин хамгийн доогуур үнэлгээ өгсөн үзүүлэлт бол орон байрны тав тух гэсэн хариулт байсан бөгөөд асуулганд оролцогчдын 26.9% сэтгэл дундуур, 57.6% нь сэтгэл ханамжтай гэж үнэлжээ.

Асуулганд оролцсон хятад жуулчдын 30-42% нь Баруун бүс рүү хийсэн аяллын тээврийн үйлчилгээ, түүний төрөл, аялах үеийн замын тэмдэг, тэмдэглэгээ, аяллын талаарх мэдээлэл зэрэг үзүүлэлтэд сэтгэл дундуур гэсэн хариултыг өгч харин 80 гаруй хувь нь

нутгийн иргэдийн найрсаг байдалд бүрэн сэтгэл ханамжтай болон сэтгэл ханамжтай гэж хариулсан байна.

Монгол улсад аялсан нийт 720 жуулчны аялахаас өмнөх аяллын хүлээлт, аялсны дараах сэтгэл ханамжийн зөрүү Говийн бүс, Орхон Хархорины бүс, Баруун бүсэд хамгийн өндөр зөрүүтэй, Булган Сэлэнгийн болон хилийн бүсэд хамгийн бага зөрүүтэй гарчээ. /Хүснэгт 27/.

Хүснэгт 29. Жуулчны аялахаас өмнөх аяллын хүлээлт, аялсны дараах сэтгэл ханамж, дахин ирэх сонирхол

№	Зорих газар	N	Хүлээлт	Сэтгэл ханамж	Зөрүү	Statistical sig.betw. groups	Дахин ирэх сонирхол	Зөрүү	Statistical sig.betw. groups
1	Төвийн бүс-Улаанбаатар	720	4.407	4.185	-0.222	.000	4.252	0.067	.000
2	Төвийн бүс-Тэрэлж	675	4.426	4.213	-0.213	.000	4.228	0.15	.000
3	Орхон Хархорины бүс	331	4.456	4.192	-0.264	.000	4.274	0.082	.000
4	Хөвсгөлийн бүс	227	4.361	4.123	-0.238	.000	4.217	0.094	.000
5	Зүүн бүс	240	4.363	4.116	-0.246	.000	4.248	0.132	.000
6	Булган Сэлэнгийн бүс	68	4.441	4.387	-0.054	.001	4.312	-0.076	.395
7	Говийн бүс	45	4.444	4.163	-0.281	.001	4.360	0.197	.001
8	Баруун бүс	26	4.462	4.204	-0.258	.003	3.900	-0.304	.409
9	Хилийн бүс	32	4.391	4.277	-0.114	.000	3.644	-0.633	.707

Бүс нутгуудыг аялахаас өмнөх хүлээлт болон бодит сэтгэл ханамжаар эрэмбэлээд үзэхэд аялахаас өмнөх хүлээлт Баруун бүсэд хамгийн өндөр 1-рт, бодит сэтгэл ханамж гэсэн үзүүлэлтээр 8-рт эрэмбэлэгдсэн байна. Ингээд эрэмбийн нийлбэр үр дүнгээр Орхон Хархорины бүс, Булган Сэлэнгийн бүс, Говийн бүсийн дараагаар Баруун бүс нь Төвийн -Тэрэлжийн бүстэй адил 2-рт эрэмбэлэгдэж байна. /Хүснэгт 28/.

Хүснэгт 30. Зорих газрын эрэмбэ (жуулчны бодит сэтгэл ханамжаар)

№	Зорих газар	N	Хүлээлт			Бодит сэтгэл ханамж= Аяллын сэтгэл ханамж+дахин ирэх сонирхол			Эрэмбийн үр дүн	
			Эрэмбийн утга	Эрэмбэ	Оноо	Эрэмбийн утга	Эрэмбэ	Оноо	Нийт оноо	Нэгдсэн эрэмбэ
1	Төвийн бүс-Улаанбаатар	720	4.407	VI	4	4.219	V	5	9	III
2	Төвийн бүс-Тэрэлж	675	4.426	V	5	4.221	IV	6	11	II


3	Орхон Хархорины бүс	331	4.456	II	8	4.233	III	7	15	I
4	Хөвсгөлийн бүс	227	4.361	IX	1	4.17	VII	3	4	V
5	Зүүн бүс	240	4.363	VII	2	4.182	VI	4	6	IV
6	Булган Сэлэнгийн бүс	68	4.441	IV	6	4.35	I	9	15	I
7	Говийн бүс	45	4.444	III	7	4.262	II	8	15	I
8	Баруун бүс	26	4.462	I	9	4.052	VIII	2	11	II
9	Хилийн бүс	32	4.391	VII	3	3.961	IX	1	4	V

Монгол улсад аялсан 720 хятад жуулчдаас зорих газрын сэтгэл татам байдал, үйлчилгээ, тээвэр гэх 3 бүлэг асуултаар авсан асуулгыг мөн тус бүрд нь эрэмбэлэн нийлбэр эрэмбийн дүн гаргасан болно. /Хүснэгт 29/.

Хүснэгт 31. Нэгдсэн эрэмбийн дүн

№	Зорих газар	Сэтгэл татам байдал				Үйлчилгээ				Тээвэр				Эрэмбийн үр дүн	
		Эрэмбийн н утга	Эрэмбэ	Оноо	Эрэмбийн н утга	Эрэмбэ	Оноо	Эрэмбийн н утга	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	
1	Төвийн бүс- Улаанбаатар	0.667	I	9	0.667	V	5	0.533	V	5	V	19			
2	Төвийн бүс- Тэрэлж	0.333	II	8	0.975	I	9	0.65	II	8	I	25			
3	Орхон Хархорины бүс	0.667	I	9	0.68	IV	6	0.512	VI	4	V	19			
4	Хөвсгөлийн бүс	0.667	I	9	0.675	VI	4	0.586	III	7	IV	20			
5	Зүүн бүс	0.667	I	9	0.678	III	7	0.533	V	5	III	21			
6	Булган Сэлэнгийн бүс	0.667	I	9	0.667	VII	3	0.667	I	9	III	21			
7	Говийн бүс	0.667	I	9	0.557	VIII	2	0.667	I	9	IV	20			
8	Баруун бүс	0.667	I	9	0.667	VII	3	0.431	VII	3	VI	15			
9	Хилийн бүс	0.667	I	9	0.679	II	8	0.576	IV	6	II	23			

Нийлбэр эрэмбийн үр дүнгээр Баруун бүс бусад бүсүүдээс хамгийн сүүлийн байрыг эзэлж байгаа нь тухайн бүсэд хятад жуулчдыг тав тухтай байрлуулах жуулчны бааз, амралтын газруудыг бий болгох, аяллын сонирхолтой хөтөлбөрүүдийг санал болгох, сурталчилгаа хийх, тээвэр болон аялал жуулчлал, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зэрэг аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлого зайлшгүй хэрэгтэй байгааг харуулж байна.



Зураг 37. Баруун бүсийн аялал жуулчлалын үндсэн чиглэл

21 аймгийн байрших хэрэгсэл судалгаа /2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Аймаг	Зочид буудлын тоо	Орны тоо	Дэн буудал	Орны тоо	Рашаан сувилал	Орны тоо	Жуулчны бааз, амралтын газар	Орны тоо	Гэр буудал	Орны тоо	Аялал жуулчлалын салбар ажиллагсад	Жуулчдын тоо гадаад	Жуулчдын тоо дотоод
1	Архангай	6	141	32	407	3	210	30	2726	91	1380	935	21822	76708
2	Баянхонгор	9	300	2	31	3	541	9	514	8	129	415	2000	70080
3	Баян-өлгий	13	425	4	95	2	180	15	704	5	145	303	8000	4000
4	Булган	4	95	11	103	6	1234	16	905	32	2205	753	6825	40827
5	Говь-Алтай	5	165	13	129	3	155	2	67			474	574	14069
6	Говьсүмбэр	1	38	1	17			1	12			77	4724	42211
7	Дорноговь	18	616	33	263	3	230	7	430	26	511	276	20182	70200
8	Дорнод	8	271	28	198			4	285	20	337	312	6555	52175
9	Дундговь	5	125	7	89	1	60	13	1004	12	212	200	16767	5285
10	Завхан	5	152	26	311	8	236	11	597			791	766	23115
11	Орхон	25	603	12	95			2	280			1745	1072	26774
12	Өвөрхангай	13	682	8	212	6	550	38	2094	31	660	800	26137	31666
13	Өмнөговь	61	1026					26	2128	61	1047	916	42132	12955
14	Увс	9	375	2	28	2	52	15	1052	3	65	394	45104	18980
15	Дархан	31	758	11	116			18	1758			1038	4108	25712
16	Сүхбаатар	14	243	4	39			7	248	1	25	180	946	23150
17	Сэлэнгэ	14	317	6	57	5	174	10	452			152	1000	5000
18	Төв			5	46	10	712	103	5878	95	829	823	72224	70384
19	Хөвсгөл	8	245	7	80			91	3659	141	2782	1137	26137	56531
20	Хэнтий	10	309	46	646	5	806	32	1856	12	56	808	6105	65030
21	Ховд	8	313	6	111	1		7	360			390	6892	45630
	Нийт	267	17567	264	5896	45	5140	457	27009	538	10383	12919	320072	780482


Хүснэгт 32. 21 аймгийн байрлах хэрэгсэлийн судалгаа

Дотоодын аялагчдаас авсан асуулга судалгааны үр дүн

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын зах зээлийн нөхцөл боломж, тус аймаг руу аялах дотоодын аялагчдын эрэлтийг тодорхойлох үүднээс 37 хаалттай асуулт, 1 нээлттэй асуулт бүхий нийт 38 асуулттай анкет асуулга судалгааг 2021 оны 9-р сарын 15-нээс 11-р сарын 20-ны хооронд авлаа. Судалгаанд Улаанбаатар хот, төв суурин гэхээсээ илүүтэй хөдөө орон нутгийн иргэдийн оролцоог жигд хангах үүднээс судалгааг хэвлэмэл байдлаар тараан авч боловсруулалтыг SPSS 21 программын тусламжтайгаар боловсруулан үр дүнг гаргасан болно.


Судалгаанд нийтдээ 949 хүн оролцож асуулга судалгааг бөглөсөн бөгөөд судалгаанд оролцогчдын 39.8% нь 18-24 насных, 20.2% нь 25-34 насных, 17.2% нь 35-44 насных, 13.9% нь 45-54 насных, 5.6% нь 55-64 насных, 65-аас дээш насныхан 3.3% байсан бөгөөд 41.8% нь эрэгтэйчүүд, 57.7% нь эмэгтэйчүүд, 0.5% нь бусад хүйсийн хүмүүс оролцжээ.

Зураг 38. Судалгаанд оролцогчдын насны бүлэг



Уг судалгаанд аль болохоор бүх аймаг орон нутгийн иргэдийг хамруулах гэж хичээсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 23% нь Улаанбаатар, 24.2% нь Хангайн бүсийн, 19.8% нь Төвийн бүс, 18.8% нь Баруун бүс, 8.5% нь Зүүн бүс, 5,7% нь Говийн бүсийн иргэд оролцсон байна.


Зураг 39. Судалгаанд оролцогчдын харьяалал



Асуулга судалгаанд оролцогчдын 40.6% нь гэрлэсэн, 46.7% нь гэрлээгүй, үлдсэн 12.7 хувь нь бэлэвсэн, салсан, хамтран амьдрагчтэй гэж хариулжээ. Боловсролын хувьд 49.1% нь дээд, 29.7% нь бүрэн дунд, 16.1% нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй ба үлдсэн 5.1 хувь нь тусгай дунд болон бага боловсролтой байна.

“Та Монгол орноор жилд хэдэн удаа амрах зорилгоор аялдаг вэ?” гэсэн асуултанд асуулганд оролцогчдын 52.2% нь 1 удаа, 36.9% нь 2-3 удаа, 7.3% нь 4-5 удаа, 3.7% нь 6-аас дээш удаа аялдаг гэж бөглөжээ. Эндээс харахад дотоодын аялагчид жилд нэг удаа амрахдаа олон хоногоор сонирхолтой хэлбэрээр амардаг гэсэн үр дүн гарч байна.

Зураг 40. Нэг жилд Монгол орноор аялах давтамж



Судалгаанд оролцогчдоос “Монгол орны хэдэн аймаг аялсан бэ” гэсэн асуултад давхардсан тоогоор хамгийн хүн аялсан аймагт судалгаанд оролцогчдын 64.8% нь Архангай, 54.8% нь Төв аймаг, 53.3% нь Хөвсгөл, 52.8% Дархан-Уул аймаг, 50.7% нь Өвөрхангай аймгуудад аялсан байна. Энэ нь дотоодын аялагчдын ихэнх нь Хангайн болон Төвийн бүсийн аймгуудаар илүүтэй аялдаг болох нь харагдаж байна.

Хүснэгт 33. Дотоодын аялагчдын аялсан аймгууд

Аймгууд	Зорин очиж аялсан		Аймгууд	Зорин очиж аялсан	
	Аялсан хүний тоо	Эзлэх хувь		Аялсан хүний тоо	Эзлэх хувь
Архангай	615	64.8%	Орхон	348	36.6%
Баянхонгор	345	36.3%	Өвөрхангай	482	50.7%
Баян-Өлгий	215	22.1%	Өмнөговь	261	27.5%
Булган	437	46.0%	Сүхбаатар	241	25.3%
Говь-Алтай	307	32.3%	Сэлэнгэ	410	43.2%
Говьсүмбэр	216	22.7%	Төв	519	54.6%
Дархан-Уул	502	52.8%	Увс	270	28.4%
Дорноговь	254	26.7%	Ховд	256	26.9%
Дорнод	223	23.4%	Хөвсгөл	506	53.3%
Дундговь	246	25.9%	Хэнтий	324	34.1%
Завхан	339	35.7%			

Дотоодын аялагчдын 75.9% нь бие даан аяллаа зохин байгуулдаг бол маш цөөн хувь болох 7.6% нь ямар нэг аяллын компаниар дамжуулан аялж үлдсэн 16.5% нь бусад хэлбэрээр аяллаа зохион байгуулдаг гэсэн үр дүн гарч байгаа нь аялагчид илүү хямд зардлаар аялах сонирхол ихтэй байгааг харуулж байна.


Дотооддоо хэнтэй хамт аялдаг талаар асуухад давхардсан тоогоор нийт асуулганд оролцогчдын 80.5% нь гэр бүлээрээ, 43.7% нь найз нөхөдтэйгээ, 20.1% нь ажлын хамт олонтойгоо, 3.3% нь нам, эвсэл холбоодын гишүүдтэй хамт, 4.2% нь сонирхлын бүлэгтэй аялдаг гэсэн үр дүн гарчээ.

“Монгол орноороо аялахдаа аяллын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцогчид хэд хэдэн мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл авдаг бөгөөд давхардсан тоогоор

- интернэт эх сурвалжаас 55.8%,
- найз, нөхөд хамаатнаасаа 60.5%,
- нийгмийн сүлжээнээс 29%,
- мэдээллийн хэрэгслээс 20.7%,
- гарын авлага, танилцуулга, товхимол 5%,
- аяллын компаниас 8.4%,
- үзэсгэлэн, яармагаас 3.4%,
- бусад эх сурвалжаас 4.3% нь авдаг байна.


Монгол орноор аялах голлох шалтгааныг авч үзвэл мөн давхардсан тоогоор судалгаанд оролцогчдын 74.4% нь амрах, алжаалах тайлах, 43.4% нь найз, нөхөд, хамаатныдаа зочлох, 31.1% нь чөлөөт цагаа өнгөрүүлэх, адал явдал эрэлхийлэх, 17.5% нь эмчилгээ сувилгааны зорилгоор аялдаг байна.

Зураг 41. Монгол орноор аялах шалтгаан



“Хэрэв та Говь-Алтай аймаг руу аялах бол аяллын ямар замналаар аялах вэ?” гэсэн асуултанд нийт санал асуулганд оролцогчдын 55.5% нь хил залгаа аймгуудтай хамтад нь аялна, 24.9% нь шууд Говь-Алтай аймгийг зорин очиж аялна, үлдсэн 19.6% нь сайн хэлж мэдэхгүй байна хэмээн хариулсан байна.

Зураг 42. Говь-Алтай аймаг руу аялах аяллын замнал



Судалгаанд оролцогчдын аяллын замналыг нас болон орлоготой нь холбон авч үзвэл насны бүлэг болон орлогын түвшинд дотоодын жуулчдын Говь-Алтай аймаг руу хил залгаа аймгуудтай хамтад нь аялна гэсэн хариулт голлох байр суурийг эзэлж байна/Хүснэгт 32, 33/.

Хүснэгт 34. Аяллын зохион байгуулах хэлбэр насны бүлгээр

Count		аяллынзамнал			Total
		1	2	3	
нас	18-24	79	213	86	378
	25-34	51	107	34	192
	35-44	41	96	26	163
	45-54	34	74	24	132
	55-64	17	23	13	53
	65-74	10	9	0	19
	75-84	4	4	3	11
	85 дээш	0	1	0	1
Total		236	527	186	949

Аялал зохион байгуулах хэлбэр
 1-шууд Говь-Алтай аймгийг зорин очиж аялна
 2-Хил залгаа аймгуултай хамтатган аялна
 3-Сайн хэлж мэдэхгүй

Хүснэгт 35. Аяллын зохион байгуулах хэлбэр орлогын түвшингээр

Count		аяллынзамнал			Total
		1	2	3	
орлого	420000 хүртэл	73	161	58	292
	420001-550000	21	33	15	69
	550001-800000	28	72	15	115
	800001-1000000	41	81	30	152
	1000001-1500000	37	84	41	162
	1500001-2000000	18	50	12	80
	2000001-2500000	10	28	6	44
	2500001 дээш	7	17	8	32
Total		235	526	185	946

Говь-Алтай аймаг нь аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөхүйц зорих газар болон хөгжихийн тулд зорилтот хэрэглэгчдийнхээ эрхэмлэдэг зүйл, хүсэл сонирхлыг тодорхойлох, тэдний эрэл хэрэгцээнд нийцэхүйц аяллын хөтөлбөр, аяллын үйлчилгээ бий болгох нь чухал билээ. Энэ үүднээс дотоодын аялагчдаас Говь-Алтай аймгийн талаар хэр мэдээлэлтэй, аялахаар

шийдвэр гаргах үйл явцад ямар хүчин чухал зүйлс нөлөөтэй зэргийг тодорхойлох

үүднээс дараах 3 бүлэг 17 асуулт бүхий асуулгаар дотоодын жуулчдын хандлагыг тодорхойлох гэж оролдлоо. /Хүснэгт 34/. Судалгааны үр дүнг тоймловол:

- Дотоодын аялагчид Говь-Алтай аймаг руу аялах хүсэл сонирхол байгаа хэдий ч тухай аймаг жуулчдад бүрэн танигдаагүй, аймгийн талаарх мэдээлэл хангалтгүй байна. Иймээс зорих газрын талаарх сурталчилгаа мэдээллийг олон сувгаар өгч жуулчдыг сэдэлжүүлэх хүчтэй маркетинг зайлшгүй хэрэгтэй байна.
- Асуулганд оролцогчид Говь-Алтай аймаг нь бусад зорих газраас ялгарах өвөрмөц онцлогтой, аялахад аюулгүй гэж үздэг хэдий ч олонх нь аялал жуулчлал сайн хөгжөөгүй гэдэгтэй санал нийлж байна. Иймээс тус аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц арга хэмжээ, брэнд зорих газраас ялгарах брэндийн болгох шаардлагатай байна.
- Аяллын нөхцөл байдлын хувьд аяллын сонирхолтой хөтөлбөр, тээврийн аюулгүй байдал, байршуулах хэрэгслийн тав тух, үйлчилгээний чанар, хоолны амт чанар, аяллын үнийг чухалчлан шийдвэр гаргана гэж үзжээ. Эдгээр хүчин зүйлсийг тооцон үзсэн аяллын хөтөлбөрүүдийг болосвруулан жуулчдад санал болгохоос гадна амралт, жуулчны бааз, хоол унд, үйлчилгээний байгууллагын стандартыг сайжруулах дорвитой ажлуудыг нэн даруй хийх шаардлагатай байна.
- Хэрэв дээр дурдсан шаардлагуудыг хангасан тохолдолд асуулганд оролцсон дотоодын жуулчдын дийлэнх Говь-Алтай аймагт дахин аялах, бусдад аялахыг санал болгоно гэж үзсэн байна.

Хүснэгт 36. Дотоодын аялагчдын Говь-Алтай аймгийн талаарх хандлага

№	Асуултууд	Огт санал нийлэхгүй					Маш сайн санал нийлж байна				
		1	2	3	4	5	1	2	3	4	5
1	Би Говь-Алтай аймгийн талаар маш сайн мэднэ	38.1%	22%	17.9%	9.8%	12.1%					
2	Би Говь-Алтай аймгаар аялахыг хүсдэг	8.6%	11.4%	26%	20%	34%					
3	Говь-Алтай аймаг миний хувьд танил санагддаг	28.3%	21%	22.4%	12%	16.3%					
4	Говь-Алтай аймгийн иргэд зочломтгой, найрсаг	14.2%	12.4%	33.3%	19.1%	21%					
5	Би олон төрлийн мэдээллийн эх сурвалжаар дамжуулан Говь-Алтай аймгийн аяллын талаарх мэдээлэлтэй болсон	28.3%	21%	22.6%	13.6%	14.5%					
6	Говь-Алтай аймаг нь бусад аймгуудаас ялгарах өвөрмөц онцлогтой	8.5%	10.5%	29.4%	22.3%	29.3%					
7	Говь-Алтай аймагт аялахад аюулгүй гэж итгэдэг	8.6%	10%	30.2%	24.5%	26.7%					
8	Говь-Алтай аймагт аялал жуулчлал сайн хөгжсөн гэж үздэг	17.8%	21.8%	34.5%	15.3%	10.6%					
9	Би Говь-Алтай аймгийн талаар эерэг зүйлсийг хүмүүст ярина	6.1%	9.2%	28.2%	27.3%	29.2%					
10	Говь-Алтай аймаг руу аялах тухай шийдвэрт аяллын сонирхолтой хөтөлбөр чухал нөлөөтэй	5.8%	6%	20.1%	20.7%	47.4%					
11	Говь-Алтай аймаг руу аялах тухай шийдвэрт тээврийн аюулгүй байдал чухал нөлөөтэй	2.6%	3.7%	10.4%	13.6%	69.6%					

12	Говь-Алтай аймаг руу аялах тухай шийдвэрт аяллын хямд үнэ чухал нөлөөтэй	5.3%	5%	21.7%	20.1%	47.9%
13	Говь-Алтай аймаг руу аялах тухай шийдвэрт амралтын газар, жуулчны баазын тохь тух чухал нөлөөтэй	3.9%	2.8%	10.7%	18.4%	64.1%
14	Говь-Алтай аймаг руу аялах тухай шийдвэрт хоолны амт чанар чухал нөлөөтэй	3.5%	3.6%	15.3%	20.3%	57.3%
15	Би Говь-Алтайд сэтгэл ханамжтай аялна гэж итгэдэг	3.2%	5.3%	24%	26.5%	50%
16	Би Говь-Алтай аймагт аялахыг бусдад санал болгоно	5.3%	8%	29.1%	22.7%	34.9%
17	Би Говь-Алтай аймгаар дахин аялна	11.8%	9.2%	29.4%	18.3%	31.3%

Дээр дурдсан 17 асуултыг

- дотоодын жуулчдын Говь-Алтай аймгийн талаарх мэдлэг ойлголт, хүртээмжтэй мэдээлэл, танигдсан байдал зэрэг 1-7-р асуултуудыг нэг бүлэг болгон “Аймгийн танил байдал”,
- аяллын шийдвэр гаргалтанд нөлөө үзүүлэх тээвэрлэлтийн аюулгүй байдал, аяллын сонирхолтой хөвөөлбөр, аяллын үнэ, амралт, жуулчны баазын тав тух, хоол, үйлчилгээний байгууллагын чанарын түвшин зэрэг 9-14-р асуултуудыг бүлэглэн “аяллын үйлчилгээ”,
- аяллаас авах сэтгэл ханамж, тухайн аймгийн бусдад аялахыг санал болгох зэрэг 8, 15-17-р асуултуудыг бүлэглэн “аяллын нөхцөл байдал”


гэсэн 3 хүчин болгон аялах хүсэл шийдвэр гаргалттай ямар хамааралтай байгааг регрессийн шинжилгээ хийж үзлээ. Регрессийн шинжилгээний үр дүнд нийт асуулганд оролцогчдын аялах хүсэл, шийдвэр гаргалтанд аймгийн танигдсан байдал, аяллын үйлчилгээ, аяллын нөхцөл байдал гэсэн 3 хүчин зүйлс бүгд шууд хамааралтай, эерэг үзүүлэлттэй гарч байгаа тул эдгээр хүчин зүйлсийг харгалзсан Говь-Алтай аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлого зайлшгүй буйг нотлон харуулж байна.

Хүснэгт 37. Регрессийн шинжилгээний үр дүн

Үл хамаарах хувьсагч	Хамаарах хувьсагч	Регрессийн коэффициент	Стандарт алдаа	P
Аяллын нөхцөл байдал	Аялах хүсэл, шийдвэр гаргалт	.412***	.036	.000
Аяллын үйлчилгээ		.298***	.031	.000
Аймгийн танил байдал		.190***	.031	.000
*:P<.05				

“Та Говь-Алтай аймаг руу аялбал ямар улиралд аялах вэ?” гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдын 72.3% нь зуны 7 ба 8-р саруудад, 12.8% нь 9, 10-р саруудад, 10.8% нь хаврын сүүл саруудад, маш цөөхөн хувь буюу 4.1% нь өвлийн 1, 2-р саруудад аялна гэсэн хариултыг өгчээ.


Зураг 43. Аялах улирал



“Говь-Алтай руу ямар зорилгоор аялах вэ?”

гэсэн асуултад асуулганд оролцогчдын давхардсан тоогоор байгалийн сайхныг үзэхээр 87.1% нь, зэрлэг ан амьтдыг үзэхээр 45.3% нь, адал явдалт аялал хийхээр 45.1%, найз нөхөд, хамаатныдаа зочлохоор 30.5%, ТХГН-т нэвтрэхээр 25.9% нь, эмчилгээ сувилгаа хийх зорилгоор 22.7% нь, эвент үйл ажиллагаанд оролцох зорилгоор 14.3% нь, шашин мөргөлийн үйл ажиллагаатай холбоотойгоор 7.9% нь аялна гэж хариулжээ. Иймээс дээр дурдсан зорилгыг хангах аяллыг дотоодын жуулчдад санал болгох нь зүйтэй юм.

Зураг 44. Говь-Алтай аймаг руу аялах аяллын зорилго



Дотоодын аялагчдын Говь-Алтай аймаг руу хийгдэх аяллыг насны бүлгээр аваад үзэхэд залуучууд адал явдалт аялал, эвент арга хэмжээнд оролцох, байгалийн сайхныг үзэх, зэрлэг ан амьтдыг үзэхийг илүүтэй сонирхож байгаа бол дунджаас дээш насныхан эмчилгээ сувилгаа, шашин сүсэг бишрэл, найз нөхөд хамаатныдаа зочлох гэдгийг аяллын гол зорилгон аялна гэсэн үр дүн гарч байна. Иймээс Говь-Алтайн аяллыг

төлөвлөхөд насны бүлгийн онцлог, сонирхлыг тусгасан аяллын хөтөлбөрийг санал болгох нь аялагчдыг эрэлтийг хангах нөхцөл болно.

Хүснэгт 38. Говь-Алтай аймаг руу хийгдэх аяллын зорилго насны бүлгээр/хувиар/

	Байгалийн сайхныг үзэх	Зэрлэг ан амьтдыг үзэх	Эмчилгээ сувилгаа хийх	Найз нөхөд, хамаатныдаа зочлох	ТХГН-т нэвтрэх	Шашин мөргөлийн үйл ажиллагаа	Адал явдалт аялал хийх	Эвент үйл ажиллагаанд оролцох	Бусад
18-24	40.3%	36.7%	16.7%	31.4%	36.6%	24%	48.5%	41.9%	52.2%
25-34	20.2%	21.2%	20.4%	19.7%	20.7%	17.3%	19.9%	25.7%	18.2%
35-44	17.8%	17.9%	21.8%	22.8%	19.9%	22.7%	15.9%	18.4%	15.9%
45-54	13.7%	15.3%	19.9%	15.2%	15%	16%	11.3%	11.8%	9.1%
55-64	5%	5.3%	11.1%	6.9%	4.9%	10.7%	2.8%	1.5%	4.6%
65-74	1.7%	2.1%	5.5%	2.4%	0.8%	4%	0.9%	0.7%	-
75-84	1.2%	1.2%	4.2%	1.6%	2.1%	5.3%	0.7%	-	-
85-аас дээш	0.1%	0.2%	0.4%	-	-	-	-	-	-
	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

Дотоодын аялагчдын Говь-Алтай аймаг руу хийх аяллын зорилгыг аялагчдын харъяалал тус бүрээр авч үзэхэд байгалийн сайхныг үзэх, зэрлэг ан амьтдыг харах, шашин сүсэг бишрэлтэй холбоотойгоор аялах гэсэн сонголтууд асуулганд оролцсон бүх аймгийн иргэдэд хамгийн өндөр сонголтыг хийсэн байна.

Хүснэгт 39. Говь-Алтай аймаг руу хийгдэх аяллын зорилго дотоод аялагчдын харъялалаар/аялагчдын тоогоор/

	Байгалийн сайхныг үзэх	Зэрлэг ан амьтдыг үзэх	Эмчилгээ сувилгаа хийх	Найз нөхөд, хамаатныдаа зочлох	ТХГН-т нэвтрэх	Шашин мөргөлийн үйл ажиллагаа	Адал явдалт аялал хийх	Эвент үйл ажиллагаанд оролцох	Бусад
Архангай	35	17	13	10	7	4	13	1	1
Баянхонгор	22	12	7	4	13	4	9	5	2
Баян-Өлгий	11	1	1	2	4	-	7	4	-
Булган	25	17	6	8	9	3	12	2	-
Говь-Алтай	30	17	8	25	11	4	15	7	4
Говьсүмбэр	7	2	2	5	3	1	4	2	-
Дархан-Уул	40	20	11	12	9	2	23	5	4
Дорноговь	15	6	5	7	2	-	7	4	1
Дорнод	27	12	9	12	11	3	15	12	5

Дундговь	9	5	3	1	3	-	5	2	2
Завхан	43	24	10	19	12	3	21	5	-
Орхон	21	15	5	6	5	2	15	1	3
Өвөрхангай	47	19	9	13	10	-	17	7	1
Өмнөговь	20	9	4	5	8	1	13	6	1
Сүхбаатар	13	6	5	4	4	1	10	2	-
Сэлэнгэ	29	12	6	10	4	2	12	5	3
Төв	95	51	25	26	29	10	48	19	1
Увс	32	11	12	13	8	2	20	4	1
Ховд	34	21	15	20	9	2	18	9	3
Хөвсгөл	48	30	15	17	18	12	21	5	3
Хэнтий	28	17	6	9	4	2	13	-	8
Улаанбаатар	194	106	39	62	63	17	110	29	63

Говь-Алтай аймаг руу аялах хугацааны талаар асуулганд оролцогч нар 37.6% нь 3-6 хоногийн, 36.9% нь 7-10 хоногийн, 10% нь 11-14 хоногийн, 9.4% нь 1-2 хоногийн, үлдсэн 6% нь 15-21 хоногийн аялалд хамрагдана гэж үзжээ. Иймээс Говь-Алтай аймагт дунд хугацааны аяллуудыг төлөвлөх нь илүү зохимжтой юм.

Хийгдэх аяллын хувьд нийт судалгаанд оролцогчдын 82.6% нь Говь-Алтай аймаг руу хийгдэх аяллыг өөрсдийн хувийн унаагаар, 8.2% нь орон нутгийн зорчигч тээврээр, 5.4% нь жуулчны компаниас түрээслэх байдлаар, 3.8% нь онгоцоор Говь-Алтай руу нисч очоод орон нутгаас унаа түрээслэх байдлаар аяллаа зохион байгуулна гэж хариулсан байна.

Тус аймаг руу хийгдэх аяллын 1 өдрийн зардлыг

- 25% нь 50к төг хүртэл
- 38.6% нь 50-100к
- 17.4% нь 100-150к
- 9.2% нь 150-250к
- 4.7% нь 250-350к
- 2.1% нь 350-500к
- 3% нь 500к-аас дээш төгрөгний зардлаар аялах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ.

Харин энэ үзүүлэлтийг насны бүлэгтэй хамааруулан авч үзэхэд дараах үр дүн гарч байна.


Хүснэгт 40. Нэг өдөрт Говь-Алтай аймгийн аялалд зарцуулах зардал насны бүлгээр

Насны бүлэг	Нэг өдөрт зарцуулах аяллын зардал, төг						
	50 000 хүртэл	50 001-100 000	100 001-150 000	150 001-250 000	250 001-350 000	350 001-500 000	500 001-ээс дээш
18-24	94	125	48	26	12	5	5
25-34	32	65	25	16	15	2	3
35-44	17	44	30	15	3	4	5
45-54	29	36	19	8	2	2	9
55-64	13	13	8	2	3	1	1
65-74	3	5	2	1	1	2	0
75-84	2	5	0	2	0	0	0
Бүгд	190	293	132	70	36	16	23

Говь-Алтай аймагт аялах явцад аяллын хөтөлбөрт ямар сонихорлтой хийх зүйлс байхыг сонирхож буй талаар асууж үзэхэд асуулганд оролцогчид давхардсан тоогоор 45.1% нь явган аялал хийх, 44.1% нь ууланд авирах, 39.9% нь морь унах, 36.8% нь малчин айлд зочлох, 24.9% нь уул ус тахиx, 23.3% нь урлагийн үзүүлбэр үзэх зэрэг идэвхтэй аяллын хөтөлбөрийг сонирхож буй нь аяллын компаниуд эдгээр үйл ажиллагааг багтаасан

аяллыг дотоодын жуулчдад санал болговол Говь-Алтай аймаг руу аялахаар шийдвэр гаргах болно.

Зураг 45. Аяллын үед хийхийг хүссэн зүйлс



Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон зорих газрын хөгжлийн загвараар авч үзвэл Монгол орон нь бүтээгдэхүүний хөгжлийн нээлтийн үе шатандаа байгаа бөгөөд хязгаарлагдмал зах зээл, цөөн тооны хэрэглэгчидтэй тусгай сонирхлын зорих газар юм. Энэ ч утгаараа Говь-Алтай аймаг нь Монголын аялал жуулчлалын зах зээлд хүчтэй өрсөлдөгчид болох Хөвсгөл аймаг болон Хангайн бүсийн аймгуудтай харьцуулан үзэхэд харьцангуй шинэ зорих газар бөгөөд цаашид аялал жуулчлалыг цогц бодлогоор хөгжүүлж өрсөлдөх чадварын нэмэгдүүлж чадахын бол аялал жуулчлалын зах зээлд өөрийн гэсэн өвөрмөц дүр төрх бүхий зорих газар болон хөгжих бололцоотой юм. Иймээс Говь-Алтай аймаг нь эхний үе шатанд дотоодын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөхүйц зорих газар болон хөгжихийн тулд өөрийн бусдаас ялгагдах имиджээ бий болгон брэнджүүлэх шаардлагатай болоод байна.

Өнөөдөр бизнесийн аль ч салбарт өөрийн бараа бүтээгдэхүүнээ олонд таниулах, зах зээлд амжилттай борлуулахад нөлөөлөх хүчин зүйлсийн нэг нь брэнд гэж яригдах олонд танигдсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болоод байна. Иймээс энэхүү асуулга судалгаанд дотоодын аялагчдаас Говь-Алтай аймгийн бусад аймгуудаас ялгарах онцлогийг төлөөлж буй зүйлсийг 3 үгээр илэрхийлэх нээлттэй хэлбэрийн асуултыг оруулж өгсөн бөгөөд асуулганд оролцогчид дараах байдлаар хариулсан болно. Асуулганд оролцогчид Говь-Алтай аймгийг байгаль, зэрлэг ан амьтад, говь, уул ус зэрэг үгээр хамгийн их давтамжтай төсөөлж бичсэн бөгөөд хоорондоо хамааралтай үгээр нь бүлэглэн эрэмбэллээ.

- Элс, говь
- Уул, Эж хайрхан, Сутай, Сэгс цагаан богд, Арц богд
- Байгалийн сайхан, хангай, байгалийн өвөрмөц тогтоц, Эрээн нуур, Хүнхэр
- Амьтад, мазаалай, хавтгай, бөхөн, тэмээ
- Чацаргана, дарс, нэрмэл, давжаа алим
- Тусгай хамгаалалттай газар нутгууд
- Бигэрийн сувилал
- Олдворууд
- Хилийн сонирхолтой бүс
- Найрсаг зочломтгой ард түмэн

1.4. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Maria. E, Fernandez-Gimenez and Barbara- Allen-Diaz (1999), *Testing a non-equilibrium model of rangeland vegetation dynamics in Mongolia* - Journal of Applied Ecology, 36,871-885
2. ТНС., (2013), “Хамгаалах шаардлагатай, экологийн хувьд чухал ач холбогдолтой газар нутгийн хүрээлэн буй орчны товч тодорхойлолт”, Улаанбаатар
3. БОЯ. *Монгол Улсын улаан ном*. УБ
4. Дэлхийн байгаль хамгаалах сан., (2011), *Хар нуур-Ховд голын ай сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө*. Жаргалант сум, Ховд аймаг
5. Завхан аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан (2017)
6. Жалбаажамц.Б, (1985), “БНМАУ-ын уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас”, Будапешт
7. Монголын түүхийн тайлбар толь, 2019
8. Мягмарсүрэн .Д, Намхай.А, (2012). *Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд*. Улаанбаатар хот
9. Ойн судалгаа хөгжлийн төв, (2016). *Монгол орны ойн сан*. Улаанбаатар хот
10. Саруул.А, Насанжаргал. Ж, (2017), “Соёлын өвийн эрдслийн атлас”, Улаанбаатар хот
11. МУ-ын “*Үндэсний атлас*”, (1999). Улаанбаатар хот
12. “*Монгол улсын Газарзүйн атлас*”, (2004). Улаанбаатар хот
13. “*Монгол улсын Үндэсний атлас*”, (2009). Улаанбаатар хот
14. Монгол улсын түүх. УБ. 2003
15. Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр, УБ 2012
16. Энхбат. Г, Анхсанаа. Г, *Түүх соёлын үл хөдлөх дурсгалын лавлах*. Улаанбаатар хот
17. Мөнхбаяр. В, (2020). *Говь-Алтай аймгийн байгаль газарзүйн судалгаа* Улаанбаатар хот
18. Мөнхбаяр. В, (2019). *Говь-Алтай аймгийн Хасагт хайрхан ирвэстэй бүс нутгийн судалгаа*, Улаанбаатар хот
19. Мөнхбаяр. В, (2013). *Монгол орны аялал жуулчлал*, Улаанбаатар хот
20. Мөнхбаяр. В, (2007). *Загасчлах аяллын гарын авлага* , Улаанбаатар хот
21. *Монгол нутаг дахь соёлын үл хөдлөх өвийн хадгалалт хамгаалалт*, (2006), Улаанбаатар хот
22. Шагдар.Ш, (2008), *Монгол орноор жуулчлах зуун зам*, Улаанбаатар хот
23. Түвшинжаргал.Т, (2007), *Оюутны эрдэм шинжилгээний бүтээл*, Улаанбаатар хот
24. Цэвээндорж.Д, Баяр.Д, Очирхуяг.Ц, Цэрэндагва.Я, (2003), *Монголын археологи*, Улаанбаатар хот
25. Баяр.Д, (2002), *Монголчуудын чулуун хэрэг*, Улаанбаатар хот
26. Майдар.Д, (1972), *Монголын архитектур ба хот байгуулалтын тухайд*, Улаанбаатар хот
27. Цэвээндорж.Д, (1985), *Эртний оршуулга*, Улаанбаатар хот
28. *Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал*, (1999), Улаанбаатар хот
29. Наваан.Д, (1980), *Эртний монголын түүхийн дурсгалууд*, Улаанбаатар хот

30. Намнандорж.О, (1981), *Жуулчдын замнал үзэх зүйлийн тайлбар*, Улаанбаатар хот
31. Мөнхбаяр.В., Ганпүрэв.Ө., Өнөржаргал.Ц., Жигжид.Ш., Алтансүх.С., Соёлмаа.Г.,Хашбат.Г.,Уянгаа.Л.,Маралгоо.М.,Чингүүн., (2021). *Говь-Алтай аймгийн маршрут, аяллын бүтээгдэхүүн нөөцийн судалгааны тайлан* , Улаанбаатар хот

Цахим хуудас

- a. www.google.mn
 - b. www.1212.mn
 - c. www.travelnews.mn
 - d. www.mongolbank.mn
 - e. www.mesc.gov.mn
 - f. www.mhq.ub.gov.mn
 - g. www.cac.gov.mn
 - h. www.inspection.gov.mn
32. Бусад
- a. Монгол улсын авто замын зураг
 - b. Монгол улсын Засгийн газрын тогтоол. 1998 №235 /Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт/